

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

/ Байгууллагын нэр: Эрүүл мэндийн газар/

Төлөвлөгөөг хянасан:

Аймгийн Засаг дарга

(албан тушаал)

Тэмдэг



/Б.Зоригтбаяр/

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

(албан тушаал)

-

/Ж.Баасансүрэн/

(гарын үсэг)


(огноо)

Төлөвлөгөө тайлагнасан:

Эрүүл мэндийн газрын дарга

(албан тушаал)

Тэмдэг



/Ц.Мөнхцэцэг/

(гарын үсэг)

(огноо)

2025.12.05

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Орхон аймаг

2025.12.04

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн цогц бодлогыг хэрэгжүүлэх, иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1.Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
1	1.1.1.Шинээр батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг сурталчлах,хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж,нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг бүрдүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ. ⁵		Сурталчиглаанд хамрагдсан хүний тоо	2000	3000	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийг 37 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 14374 хүнд сурталчлан сум, өрхийн эрүүл мэндийн төв, сургууль цэцэрлэг,албан байгууллагын эмч, эрүүл ахуйч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтанд 72 удаагийн уулзалт ярилцлага, сургалтад давхардсан тоогоор 3114 хүнд зохион байгуулж хуулийн таниулга хийсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны А/84 дүгээр захирамжаар Эрүүл мэндийн газрын бүтцэд байгаа Нийгмийн эрүүл мэндийн төвд 5 эмнэлгийн мэргэжилтэн хүн амд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг сурталчлах,хэрэгжилтийг хангах чиглэлээр удирдлага, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан.Анхан шатлалд нийгмийн эрүүл мэндийн 9 ажилтан орон тоогоор ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5-аар нэмэгдэж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, Эрүүл чийрэг эр хүн, Сэтгэцийн эрүүл мэнд, Иргэний эрүүл мэндийн боловсрол зэрэг 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 2024 онд 88.3, 2025 онд 88.5 хувийн хэрэгжилттэй байгаа нь суурь үзүүлэлтээс 0.2 хувиар нэмэгдэж, нийт 33 удаагийн өдөрлөг, аян, форум, 334 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 41276 иргэнийг хамруулж, 32 төрлийн сурталчилгааны материалыг 8453 иргэнд түгээж, цахим хуудаст 848 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 101,318 иргэний хандалттай байна. -Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 7 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 38 аж ахуйн нэгж,	100

						байгууллага, 36452 иргэнийг хамруулан мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 12 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. -Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, 22500 гаруй багш, хүүхдийг хамруулсан байна.	
2	1.1.2.Хүн амын дунд эрүүл мэндийн суурь судалгааг хийж, түүнд түшиглэсэн эрүүл мэндийг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлнэ ⁴		Суурь судалгааны дүн	1	1-2	Тайлант хугацаанд 2 удаагийн Эрдэм шинжилгээний хуралд нийт 49 илтгэл хэлэлцүүлж, 201 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж,эрүүл мэндийн 3 суурь судалгаа хийгдсэн. Үүнд: -БЗДХ илрүүлэх ПГУ шинжилгээний судалгаанд 2025 онд 360 эрэгтэй хамрагдсан ба 78.1% (281) нь эерэг илэрч, 36.1% нь нэг үүсгэгчтэй, 41.7% нь 2–5 төрлийн үүсгэгч илэрсэн.Тэдгээрийн 9.3% нь тэмбүүгийн халдвартай хавсарсан байна. Нийт 281 хүнд 537 үүсгэгч давхардсан тоогоор илэрч, үүнээс 87.3% нь нянгийн, 6.7% нь вирусийн, 6% нь мөөгөнцрийн халдвар байна.Нянгийн халдвар дотор Mycoplasma,Ureaplasma, Gardnerella vaginalis зонхилж байна. -Улаанбурхан, гахайн хавдар, улаануудын эсрэг товлот дархлаажуулалтаас хоцорсон болон бүртгэлгүй 2635 хүүхдийг судлахад 59.5% нь аймгийн харьяалалтай, 89.2% нь товлолын вакцинаа хамрагдсан байв.Хоцорсон 284 хүүхдийн 47.8% нь нөхөн дархлаажуулсан, 36-д зөвлөгөө өгсөн. 112 нь боломжгүй нөхцөлтэй байсан бөгөөд хоцорсон шалтгаанд эцэг эхийн хайхрамжгүй байдал(27.1%),ЭМБ-ын үйл ажиллагаа (18.6%), шилжилт хөдөлгөөн (18%) зонхилсон байна.Судалгааны үр дүнд БОЭТөвд БЗДХӨ-ний оношилгоонд шаардлагатай ПГУ-ын аппаратын төсвийг шийдүүлэх,улаан бурхан өвчнөөс сэргийлэх хариу арга хэмжээний хүрээнд товлот дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэхэд эцэг эх асран хамгаалагчдад чиглэсэн сургалт сурталчилгааг эрчимжүүлж ажилласан. -Цагаан тоосны нөлөөллийн бүсэд амьдарч буй 500 иргэдийн дунд хийсэн судалгаагаар оролцогчдын 29.5% нь тамхи хэрэглэдэг бөгөөд тэдний дийлэнх нь эрэгтэйчүүд байна. Тамхи татдаг иргэдийн олонх нь өдөрт 10 хүртэлх ширхэг хэрэглэж, ихэнх нь стресст орсон үедээ тамхи татах сэдэл авдаг байна. Судалгаанд оролцогчдын 75.7% нь дам тамхидалтанд өртөж байгаа нь бусдын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Тамхинаас гарах хүсэлтэй байгаа иргэд олон боловч, арга замын талаар мэдлэг дутмаг байна.Судалгаанд оролцогчдын 59.3% нь стрессийн нөлөөгөөр тамхи татдаг нь сэтгэлзүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.Тамхи татдаг иргэдийн 70% нь эрэгтэй, харин дам	100

						тамхидалтад өртөгчдийн 89.5% нь эмэгтэйчүүд байгаа нь хүйсийн тэнцвэргүй байдал, гэр бүлийн орчны сөрөг нөлөөг онцлон авч үзэх үндэслэлтэй. Тамхи татдаг хүмүүсийн 49.2% нь тамхинаас гарах аргыг мэддэггүй нь энэ чиглэлийн мэдлэг олгох сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.	
3	1.1.3.Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж,зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх, хэнийг ч орхигдуулахгүйгээр тусламж үйлчилгээг хүргэнэ. ^{3,5}		Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн эзлэх хувь	98.0%	98.5%	Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулж,18 байгууллагын 1467 хүнийг хамруулан эрүүл мэндийн даатгалын хамралт 92.5 хувь байна. -Тайлант хугацаанд 4 удаагийн нээлттэй хаалганы өдрөөр 1384 хүн, цэрэг татлагаар 1241 залуучуудыг сургалт сурталчилгаанд хамруулснаас 50 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан. Жаргалант суманд зохион байгуулсан малчид, тариаланчдын өдрөөр 106 хүнийг сургалтад хамруулан 30 хувийг Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулсан байна. -Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан.Үүнээс эрүүл мэндийн даатгалгүй зорилтот бүлгийн 116 хүний 82%-ийг үзлэг шинжилгээнд хамруулсан. -Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагууд явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй шуурхай үзүүлсэн байна. -Эрүүл мэндийн даатгалгүй, зорилтот бүлгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь 95% байна.	80
4	1.1.4.Нас,хүйс,эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх үзлэг болох “Ургийн гажиг, нярай, сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэг,ажлын байран дах болон хавдрын эрт илрүүлэг”-ийг зохион байгуулж, харьяа хүн амыг бүрэн хамруулахад иргэд,бүх		Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	34,0%	34,3%	Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа “Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо” арга хэмжээнд харьяа хүн амыг бүрэн хамруулах чиглэлээр үзлэг зохион байгуулах салбар дундын ажлын хэсгийг ЭМГ-ын даргын 2025 оны А/05 тушаалаар байгуулан хурал 12, дэмжлэгт хяналт 10, хяналт үнэлгээ шинжилгээ 6, идэвхжүүлэх аян 4, тэмдэглэлт өдрийн үйл ажиллагааг 15 удаа зохион байгуулахад салбар дундын оролцоог ханган төлөвлөгөөний хэрэгжилт 94,6%-тай байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагуудаар аймгийн хэмжээнд нийт 728,121 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 260,844 хийгдэж 35.8 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар өссөн байна -Аймгийн хэмжээнд пренатологич 2 эмчтэй болж ургийн үзлэг	100

	шатны төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын оролцоог нэмэгдүүлэн, үр дүнг тооцож ажиллана.^{1,2,5}				тогтмолжин тайлант хугацаанд 1357 үзлэг хийж, өвчний учир 928, идэвхтэй хяналтад 429 эх бүртгэгдсэн. Жирэмсний эрт үеийн нийлмэл илрүүлэгт 141 эхийг хамруулж, эрсдэлтэй 20-оос 13 NIPT, 5 ургийн усны шинжилгээ хийж, эрхтэн тогтолцооны гажигтай 2 жирэмслэлтийг эрт шийдвэрлэсэн байна. Ургийн бүтцийн ЭХО-д давхардсан 270 гаруй эмэгтэй хамрагдаж, олон урагтай 18, дээд шатлалд 7 эмэгтэй илгээсэн. RH-сөрөг жирэмсэн 2, төрөл бүрийн ургийн гажигтай 11 тохиолдлыг оношилон 3-р шатлалд илгээн жирэмслэлт тээлтийг шийдүүлсэн. -Төрсөн 1610 нярайг нярайн тандалт скрининг шинжилгээнд 100% хамруулснаас түнхний үений эхо оношилгоонд 1605 /99,6%/, сонсголын скрининг 1111, нүдний угийн улаан рефлекс 1605, бодисын солилцооны 5 төрлийн эмгэг илрүүлэх оношилгоонд 1180 нярайг хамруулсан байна. 10-р сараас пульсоксиметрийн скрининг нэвтэрч 165 нярайд зүрхний эмгэг илрээгүй. Бодисын солилцооны скринингт 1180 нярай хамруулж, өөрчлөлттэй 1 нярайг хяналтад авсан. -Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2554 буюу 99,1 хувь нь хамрагдаж, 1773 буюу 68,8 хувьд өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрч, 720 буюу 28,1 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Үүнд: Шүдний илрүүлэгт 2433 хүүхэд хамрагдахаас 94,4% нь хамрагдсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхэд фторт түрхлэг түрхүүлсэн, шүдний цооролтой 1991 /81,8%/, шүдний гажигтай 673 /27,6%/, шүдээ бүрэн угаадаггүй 1974 /81.1%/, шүдний эмчилгээнд хамрагдсан 720 /48,4%/ хүүхэд байна. Нүдний илрүүлэгт 2425 хүүхэд хамрагдахаас 94,1% нь хамрагдсан. Илрүүлгээр нарийн мэргэжлийн эмчид үзүүлэх шаардлагатай 496 буюу 20.5% нь байна. Холын хараа тэнцээгүй 289 /11.9%/, ойрын хараа тэмцээгүй 84 /3.4%/, стерео хараа тэнцээгүй 206 /8.5%/ байна. Зүрхний эмгэг илрүүлэг үзлэгт 2393 хүүхэд хамрагдахаас 92.9%-ыг хамруулж, үүнээс зүрхний цахилгаан бичлэгт өөрчлөлттэй илэрсэн 363/ 15,1%/ хүүхдээс 315 буюу 86,7%-ийг зүрхний эхо оношилгоонд хамруулан 27 хүүхдэд зүрхний эмгэг илэрч, хяналтад авсан байна. -Ажлын байран дах эрт илрүүлэг үзлэгт 122 байгууллагын 4071 ажилтан лавлагаа шатлалын урьдчилан сэргийлэх багцад хамрагдсан. -БОЭТөвийн Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвд нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдаж, шинээр 147 хавдар илэрч, идэвхтэй хяналтад орсон. 2025.09.07-нд Хойд бүсийн ХСҮТ-ийн салбар нээгдэж, мэргэжлийн 3 эмч ажиллан 111 иргэнд үзлэг, зөвлөгөө үзүүлж бүсийн хэмжээнд хавдрын эрт илрүүлгийн чадавхи нэмэгдсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 296 шинэ хорт хавдрын тохиолдол бүртгэгдсэн байна.	
--	---	--	--	--	--	--

5	1.1.5. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг /хөх, умай, чихрийн шижин, цусны даралт ихсэх/ үзлэгийг эрчимжүүлнэ. ^{3,4}		Эрт илрүүлгийн дундаж хувь	89,5%	89,6%	Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний 5 төрлийн эрт илрүүлэгт 136861 хүн хамруулахаар төлөвлөснөөс 115748 хүн хамрагдаж, хамрагдалтын хувь 84,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3,7%-иар буурсан. Үүнд: Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгт нийт 18-с дээш насны 49835 буюу хамрагдвал зохих хүн амын 78.6 хувийг эзэлж, өмнөх оноос (15.7) хувиар буурч, үр дүнгийн үзүүлэлтээр 0.7 хувь нь онош батлагдсан. Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн үзлэгт нийт 35-дээш насны 41471 буюу хамрагдвал зохих хүн амын 100.1 хувийг эзэлж, өмнөх оноос (13.3) хувиар нэмэгдэж, үр дүнгийн үзүүлэлтээр 0.4 хувь онош батлагдсан байна. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт зорилтот насны нийт 3213 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 55.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (37.7) хувиар буурсан. Нийт 2913 шинжилгээнээс 2627 буюу 90.1 хувь нь хэвийн гарсан байна. Хөхний эрт илрүүлэг үзлэгт 19236 эмэгтэй хамрагдаж, хамрагдвал зохих насны эмэгтэйчүүдийн 78.6 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс (12.1) хувиар буурсан байна. Элэгний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт зорилтот бүлгийн 40-65 насны 1993 (107.3%) хүн хамрагдсан. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг идэвхжүүлэх чиглэлээр салбар дундын хурал 6 удаа, дэмжлэгт хяналт 4 удаа, зөвлөмж 2 удаа өгч, мэргэжил арга зүйн дэмжлэгээр ханган ажилласнаар эрт илрүүлэг үзлэгийн төлөвлөгөөний хэрэгжилт 92,4 %-тай хэрэгжсэн байна.	70
6	1.1.6. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа “Эрүүл Монгол хүн”, “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах”, “Эрүүл шүд”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх”, “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээ /2024-2027/-г хэрэгжилтийг хангахад салбар дундын оролцоог хангаж, хяналт тавьж ажиллана. ⁵	237,0 сая ОНТ	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь	88.1%	88,5%	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилт дунджаар 89,7 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,8%-иар нэмэгдсэн байна. 2025 онд нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд нийт 237.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн хэрэгжилтийг хангахад АЗДТГ, БГ, ХГБХГ, ЦГ, ОБГ, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Төрийн бус 10 байгууллагатай хамтран салбар дундын оролцоог хангаж ажилласан. Үүнд: Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд арга хэмжээний төлөвлөгөө, “Эрүүл Монгол хүн”, “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулан эрүүл зөв амьдралын мэдлэг хандлага, эрүүл мэндийн боловсролын түвшинг нэмэгдүүлж ажилласан. Томуу, томуу төст өвчний урьдчилан сэргийлэх болон дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмж, эмч, эмнэлгийн мэргэжилтний илүү цагийн нэмэгдэлд нийт	100

						25,0 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн байна. 2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөл хорт хавдартай 213 иргэнд нийт 120,000.000 төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгосон байна. 2025 онд шинээр батлагдсан 238 хавдрын тохиолдлын 89,5 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээ /2024-2027/-ний хэрэгжилтийг хангахад салбар дундын оролцоог ханган ажиллаж, хэрэгжилт 90,8 %-тай байна. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний хүрээнд 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 12 удаагийн өдөрлөгт сэтгэцийн эрүүл мэнд, хорт зуршлыг бууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох чиглэлээр 31245 хүнийг хамруулсан. “Эрүүл шүд” арга хэмжээний хүрээнд Шүдний мэргэжилтнүүдийн холбоотой хамтран зорилтот бүлгийн хүн амын дунд явуулын үзлэг 4 удаа, шүд угаах 12 удаагийн сургалт, Шүдний олимпиадад давхардсан тоогоор 8400 гаруй хүнийг хамруулан шүд угаах цаг, буланг хүүхдийн байгууллагад бий болгоод байна. Арга хэмжээнүүдийн хүрээнд нийт 27 удаагийн өдөрлөг, аян, форум, 316 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 20098 иргэнийг хамруулж, 24 төрлийн сурталчилгааны материалыг 6068 иргэнд түгээсэн. Цахим хуудаст 789 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг байршуулан давхардсан тоогоор 101318 хандалттай байна	
7	1.1.7. Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж, үр дүнг тооцно. ⁵		Үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо	12000	18000	Хүн амын дундахь эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 6 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 37 аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус 6 байгууллагатай хамтран нийт 36801 иргэнийг эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалтад хамруулсан байна. Үүнд: -Амны хөндийн эрүүл мэндийг сахих, зөв дадлыг төлөвшүүлэх, эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг боловсролын байгууллагын 56 нэгжид зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиудад 7 хоногт 1 удаа ангидаа шүд угаах аяныг өрнүүлж 24 сургуулийн 25122 хүүхдийг хамруулсан байна -Сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” шүд, гараа зөв угааж сурах аяныг өрнүүлж, Шүдний олимпиадыг улсын хэмжээнд анх удаа Шүдний холбоотой хамтран орон нутагт зохион байгуулж, нийт 630 хүнийг хамруулсан. -Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, П.Н.Шестины нэрэмжит Улсын гуравдугаар төв эмнэлгийн санаачилга, ХААН Банк Сангийн санхүүжилттэй “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян-2025” нь 8 дахь жилдээ хэрэгжиж байгаа бөгөөд Орхон аймагт хоёр дахь удаагаа 5 хоногийн хугацаанд зохион байгуулж, цусны даралт ихсэхээс сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, зөвлөгөөг 1171 хүнд өгч, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.	100

					-Тогтвортой хөгжил ирээдүй ТББ-тай хамтран Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн “Амьдралын алтан 1000 хоног” сэдэвт 6 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг 388 жирэмсэн эх, ар гэрийг хамруулан 6 төрлийн видео постер мэдээллээр 7690 хандалт авсан байна. -Төрийн болон төрийн бус 16 байгууллагатай хамтран “Сэтгэцийн эрүүл мэндийн өдөрлөг”-ийг “Эрдэнэт үйлдвэр”ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборт зохион байгуулж давхардсан тоогоор 1800 иргэнийг хамруулан сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгосон. -Аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран “Иргэдийн оролцоо-Төлөөлөгчийн манлайлал-Төрийн үйлчилгээ” нэгдсэн өдөрлөг арга хэмжээнд ЭМГ, сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв,төрийн 35 байгууллагатай хамтран 10700 гаруй хүнд төрийн болон эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа бодлого шийдвэрийг сурталчлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан. -Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд түгээсэн байна.		
8	1.1.8.Алслагдсан сум,багт амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзлэг, оношилгоо Явуулын баг ажиллуулан урьдчилан сэргийлэх,эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. ⁵		Зохион байгуулсан үзлэгийн тоо	1	4	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Эрдэнэт клиник болон хувийн хэвшлийн 13 шүдний клиникт 120 эмч, эмнэлгийн мэргэжилтэн шүдний тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байгаагаас 61 буюу 50,8% нь их эмч ажиллаж байна. -Тайлант хугацаанд ЭМГ,сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлгийн явуулын үзлэгт 29 багийн 22 сургуулийн 2433 хүүхдээс 94,4%-ийг хамруулсан. Үзлэгээр 2405 /99%/ хүүхдэд фторт түрхлэг түрхэж, шүдний цооролтой 1991 /81,8%/, шүдний гажигтай 673 /27,6%/, шүдээ бүрэн угаадаггүй 1974 /81.1%/,шүдний эмчилгээнд хамрагдсан 707/ 47,6%/хүүхэд байна. -Алслагдсан сум Жаргалант сумын эрүүл мэндийн төвд Эрүүл мэндийн яамнаас Эрүүл шүд арга хэмжээний хүрээнд 51,0 сая төгрөгийн санхүүжилт бүхий шүдний кабинет байгуулагдсан бөгөөд Хаш шүдний эмнэлэгтэй гэрээ хийж, хамтран ажиллаж, Жаргалантын 3-р сургуулийн 1 дүгээр ангийн 35 хүүхдийг шүдний үзлэг, фторт түрхлэгт хамруулсан байна. -Тайлант хугацаанд Шүдний мэргэжилтний холбоо, Шүдний 5 эмнэлэгтэй хамтран малчдын үзлэгт 152 хүн, цэргийн насны 178 залуучууд, цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1500 нийт 1678 хүнд явуулаар амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, шүд угаах аргачлалыг таниулах сургалт нөлөөллийг ажлыг зохион байгуулсан.	100

9	1.1.9.Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах,илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнг улирал бүр хянана ⁵		Эмчилгээн д орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээн ий төгсгөлд эдгэрсэн хувь	23.8	22.5	Тайлант хугацаанд халдварт өвчний 593 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 2,1 промиллоор буурсан үзүүлэлттэй байна.Нийт халдварт өвчний 47,6%-ийг амьсгалын зам, 25,8% БЗДХ, гэдэсний халдвар 3%, бусад халдварт өвчин 26,6%-ийг эзлэж байна. -Аймгийн хэмжээнд бүртгэгдэж байгаа халдварт өвчний тохиолдлуудад тандалт судалгааг тогтмол хийж, илрүүлэг, хяналт, тандалт, эмчилгээ зэрэг хариу арга хэмжээг авч ажиллахад төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран ажилласан. -Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр батлуулсан үйл ажиллагааны нэгдсэн удирдамжийн биелэлтийг 88,5%-тай ханган ажиллалаа. Үүнд: -Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв сүрьеэгийн эрсдэлт бүлгийн 3790 хүний судалгааг гаргаж, 1872/49.4%/ хүнийг идэвхтэй илрүүлэгт хамруулж, 198 хүнд сорил, 15 хүнд цэрний шинжилгээ хийгдсэн байна. -Сорил эерэг гарсан 34 хүнийг урьдчилан сэргийлэх, 1 тохиолдлыг эмэнд мэдрэг сүрьеэгийн /ЭМС/ эмийн эмчилгээнд хамруулан хяналтад авсан байна. -Цэрэг татлагын 2 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгт 18-25 насны 499 залуучуудыг хамруулж, БЗДХ-ын 4, сүрьеэгийн сэжигтэй 8 тохиолдлыг илрүүлж бүртгэл, хяналтад хавьтлын хамт авсан. -Тайлант хугацаанд жирэмсний идэвхтэй хяналтад байгаа 914 жирэмсэн эхийг сүрьеэгийн тандалт асуумжид хамруулан жирэмсэн үеийн сүрьеэ өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. -Сүрьеэ өвчний илрүүлэг, мэдээллийн урсгал болон оношилгоо, хяналт, эмчилгээнд анхаарах асуудлаар салбар дундын уялдааг хангах хэлэлцүүлэг 1 удаа, чадавхжуулах сургалтад давхардсан тоогоор анхан болон лавлагаа шатлалын 124 эмч,эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулсан байна. -Хүүхдийн байгууллагын 56 эмч,нийгмийн ажилтнуудыг хүүхдийн дундах сүрьеэг илрүүлэх тандах,мэдээллийн урсгалыг сайжруулах сургалтад хамруулан чадавхжуулсан. -Сүрьеэгийн өвчлөлийн 70 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 6,6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,7 промиллоор буурч,эмчилгээнд орсон халдвартай хэлбэрийн сүрьеэтэй өвчтөнөөс эмчилгээний төгсгөлд эдгэрсэн хувь 63,6%-д хүрсэн нь суурь түвшнөөс 39,8%-иар нэмэгдсэн эерэг үр дүнд хүрсэн байна.	100
			Нийт халдварт өвчинд эзлэх БЗДХ-ын эзлэх хувь	19.6	19.0	-Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Бэлгийн замаар дамжих халдварын кабинет нь бүтэц орон тооны хувьд 1 эмч, 1 эмнэлгийн мэргэжилтэнтэй бөгөөд сум,өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран мэдээллийн урсгалын дагуу бүртгэл мэдээллийг хянаж, хариу арга хэмжээг авч ажилласан.БЗХӨ-ийг илрүүлэх түргэвчилсэн оношлуур, нян судлал, ийлдсийн аргаар батлах шинжилгээг хийж,хавьталын хамт эмчилгээ хяналтад авсан. -Тайлант хугацаанд сүрьеэ, БЗДХ-ын эрт илрүүлэгт хамрагдсан 118,	

					эрэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 300, цэрэг татлагаар 499, хорих ангийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 102 болон бусад идэвхтэй эрт илрүүлэг хийгдэж, нийт 4000 хүнд ДОХ/Тэмбүүг илрүүлэх түргэвчилсэн сорил хийсэн. Аж ахуйн нэгж байгууллага, МСҮТ, их дээд сургуулийн эрэгтэйчүүдийн дунд зохион байгуулсан эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 1459 иргэнд ДОХ/Тэмбүү илрүүлэх түргэвчилсэн сорил тависан байна. Шинээр хяналтад хамрагдсан 1338 жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээний үзүүлэлтэд трихомониаз 29 буюу 2.2 хувь, тэмбүү 9 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь тус тус эерэг гарсан байна. -ДОХ/ХДХВ-ийн халдвар эмнэлгийн нөхцөлд дамжих тархахаас сэргийлэх журмыг ЭМБ-ууд батлан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мөрдөн ажиллаж, журмын дагуу эрт илрүүлэг, жирэмсэн, яаралтай хагалгаанд орж байгаа үйлчлүүлэгчийг ДОХ/ХДХВ-ийн шинжилгээнд 100% хамруулж хэвшсэн байна. -Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн харьяа Эрдэнэт Медикал, хувийн хэвшлийн Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлэг нь ДОХ/БЗХӨ-нийг илрүүлэх шинжилгээнд Cobass-I14 бүрэн автомат аппарат, үтрээний шүүрлийг шинжлэх JNP-600 зэрэг орчин үеийн дэвшилтэт арга болох PCR шинжилгээгээр 14 төрлийн бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг оношилж байна. -Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлэг нь ДОХ/БЗХӨ-нийг илрүүлэх шинжилгээнд Cobass-I14 бүрэн автомат аппарат, үтрээний шүүрлийг шинжлэх JNP-600 зэрэг орчин үеийн дэвшилтэт арга болох PCR шинжилгээгээр 14 төрлийн бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг оношилж байна. -Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хүний папилома вирусн халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад Боловсролын газар, сум, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Амурлин тэнгис ТББ-уудтай хамтран 3 арга хэмжээг зохион байгуулж, 4750 сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийг хамруулаад байна. -Дэлхийн ДОХ-той тэмцэх өдрийг “Асуудлыг шийдье, ДОХ-ын эсрэг хариу арга хэмжээг сайжруулъя” уриан дор ЭМГ, БОЭТ, “Амурлин тэнгис” ТББ-тай хамтран “БЗДХ/ХДХВ/ДОХ гэж юу вэ?”, “Өсвөр үеийн сэтгэлзүйн онцлог ба сэтгэцийн эрүүл мэнд”, “БЗДХ-аас сэргийлэх арга замууд” сэдэвт сургалтад 1450 оюутан, сурагчдыг хамруулан танин мэдэхүйн АХА тэмцээн явуулж, сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлэн мэдлэгийг бататгасан. “Улаан тууз” сэдвээр ЕБС-ын сурагчдын дунд богино бичлэгийн уралдаан зарлаж, 150 гаруй хүүхдүүд хамрагдсан байна. -Эрүүл мэндийн 9 салбарын цахим хуудсанд 2 төрлийн зурган зурагт хуудас байршуулж нийт 12417 хүнд хүргэсэн. Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 промиллоор буурсан байна.Нийт халдварт	
--	--	--	--	--	--	--

						өвчний 51.5% амьсгалын зам, 23.7% БЗДХ, 4.7% гэдэсний, 20.2% бусад халдварт өвчин байна. 4 төрлийн 225 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, бүртгэл мэдээлэл, хавьтлын хяналт тандалт, эмчлэн зэрэг хариу арга хэмжээг авч ажилласан байна.	
10	1.1.10.Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах,урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ⁵		Нөлөөллийн арга хэмжээний тоо	2	3	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд сэтгэцийн өвчлөлийн 1371 тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 128.9 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.3 промиллоор буурсан байна. -Сэтгэц нөлөөт эмийн бодисын шалтгаант сэтгэцийн аягийн эмгэг 498 бүртгэгдэж 10 000 хүн амд 46.8 промил өмнөх оны мөн үеэс 2.0 промиллоор буурч, архины шалтгаант сэтгэцийн болон зан төрхийн эмгэг шалтгаант өвчлөлөөр 416 хүн хэвтэн эмчлүүлсэн ба 10 000 хүн амд 39.1 промил өмнөх оны мөн үеэс 0.2 промиллоор өссөн байна. -Тайлант хугацаанд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах арга хэмжээний хүрээнд 38 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан 12 удаагийн өдөрлөгт сэтгэцийн эрүүл мэнд,хорт зуршлыг бууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох чиглэлээр 6100 хүүхэд, өсвөр үе, насанд хүрэгчдэд зөвлөмж, зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн. -Мөн сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, 48 төрлийн сургалт, үйл ажиллагаанд төрийн байгууллагын албан хаагчид болон үйлдвэрийн ажилчид, эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, ерөнхий боловсролын сурагч нийт 31245 хүнийг хамруулан 18 төрлийн гарын авлага, зөвлөмжийг давхардсан тоогоор 4208 иргэнд түгээж мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. -“Дэлхийн сэтгэцийн эрүүл мэндийн өдөр”-ийг Төрийн болон төрийн бус 16 байгууллагатай хамтран “Сэтгэцийн эрүүл мэндийн өдөрлөг”-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборт зохион байгуулж, Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын 11 өртөө ажиллан, 247 иргэнд сэтгэл зүйн чиглэлийн мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч, оношилгоо хийж давхардсан тоогоор 1800 иргэнийг сургалт, мэдээлэлд хамруулан сэтгэл зүйн эрүүл мэндийн боловсрол олгосон. -Тайлант хугацаанд осол гэмтлийн өвчлөлийн 905 тохиолдол бүртгэгдэж, 10.000 хүн амд 85.1 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 45.6 промиллоор буурсан ч зам тээврийн ослын 208 тохиолдол буюу 23.0% бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9%-өөр буурсан дүнтэй байна.Осол гэмтлийн шалтгаант нас баралт 46 бүртгэгдсэнээс зам тээврийн ослын шалтгаант нас баралт 9 бүртгэгдэж,10.000 хүн амд 0.8 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс 7 тохиолдлоор өссөн байна. -“Аюулгүй байдлын төлөө үгээ хэлцгээе” аяны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд салбар дундын хэлэлцүүлгээс гарсан 18 үйл ажиллагааг 10 байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусган, төлөвлөгөөний хэрэгжилт 69.4 %-тай байна. -Аймгийн хэмжээнд“Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж-эрсдэлийг	100

						бууруулъя"уриатай иргэдэд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, зөвлөмжийг цаг алдалгүй хүргэх, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор 5 төрлийн үйл ажиллагааг төлөвлөн 95 хувьтай хэрэгжсэн байна. -Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын цахим хуудас, сум,8 өрхийн эрүүл мэндийн цахим хуудсаар 8 зурган мэдээлэл, 10 видео шторкийг бэлтгэж иргэд олон нийтэд түгээн ажиллаж, давхардсан тоогоор 12179 иргэн хандаж, 393 лайк, 75 шейртэй байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт медикал, Улаан загалмайн хороотой хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллага,хүүхдийн 45 байгууллагын 58 эмч, эмнэлгийн ажилтнуудад осол гэмтлийг бууруулах, арга хэмжээ авах чиглэлээр 6 сэдвээр сургалтад хамруулан чадавхжуулсан.Эдгээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд харьяалалын дагуу 15 сургуулийн 2412 хүүхдэд осол гэмтлээс сэргийлэх сургалт нөлөөллийг ажлаар эрүүл мэндийн боловсрол олгож, 5 төрлийн гарын авлага түгээн ажилласан -“Агшин бүрт анхаарал сэрэмжийг нэмж эрсдэлийг бууруулъя” уриатай осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, цаг үеийн мэдээллийг 3 эрүүл мэндийн байгууллагатай хамтран 6 төрлийн яриа мэдээлэл авч түгээн, цахим хуудаст 2 төрлийн уриалгыг байршуулж, давхардсан тоогоор 12,168 иргэнийг мэдээ, мэдээллээр хангасан. -Баян-Өндөр сумын 25 багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй 530 ААН 19555м2 явган зам, 5372м2 авто зам, 25090 м2 бусад талбай нийт 47917,274 м2 талбайн цас цэвэрлэгээг зохион байгуулж хальтаргаа гулгаанаас сэргийлэх арга хэмжээг авч ажилласан байна.	
Зорилт 2. Хог хаягдлын менежментийг сайжруулж, орчны сөрөөг нөлөөллийг бууруулах эрүүл мэндийн цогц арга хэмжээг бусад салбарын дэмжлэгтэй хэрэгжүүлэх							
11	1.2.1.Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлын менежментийг сайжруулах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах ⁴		Үйл ажиллагааны тайлан	86%	87%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь захирлын А/70 тушаалын дагуу 2024 оны 11 дүгээр сараас аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлыг төвлөрсөн журмаар боловсруулах үйл ажиллагааг 211м² талбай бүхий байранд 4 ажилтантайгаар зохион байгуулж, LAC-6505SP автоклав болон 2024.12.06-нд суурилуулсан Sterilwave 100 төхөөрөмжийг ашиглан тээвэрлэх, түр хадгалах, халдваргүйжүүлэх устгах үйл ажиллгааг явуулж байна. -ЭМБ-уудын хог хаягдлын менежментийн сайжруулах чиглэлээр хог хаягдлын сар бүрийн тайлан мэдээг нэгтгэн үнэлж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж,нэгдсэн мэдээллээр хангаж ажилласан. -Тайлант хугацаанд халдвартай 38,808 кг, хурц үзүүртэй 11,599 кг, эмгэгийн 2,744 кг, эсэд хортой 29.49 кг, химийн 408.4 кг хог хаягдлыг устгаж, эмийн гаралтай 302.7 кг хог хаягдлыг “Элемент Медикал” Дархан салбартай хамтран устгалд оруулсан нь аюултай хог хаягдлын эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.	100

						-31 эрүүл мэндийн байгууллагын 51 эмч, эмнэлгийн ажилтанд аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулж, 3 төрлийн 534 ширхэг гарын авлагыг хүргүүлэн мэдлэг, хөтлөх бичиг баримтын хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн байгууллагуудын аюултай хог хаягдлын менежментийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналтыг нийт 57 эрүүл мэндийн байгууллагад газар дээр нь үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн. Үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт 87 хувьтай байна.	
12	1.2.2.Цагаан тоосны нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэдэд сургалт,өдөрлөг зохион байгуулж, эрсдэл бүхий иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулна.		Үзлэгт хамрагдсан хүний тоо	500	500	Аймгийн ИТХ-ын 2024 оны 18/04 дугаар тогтоолоор батлагдсан “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах 2024–2031 оны хөтөлбөр” болон Засаг даргын 2025 оны А/205 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангах хүрээнд ажлын хэсэг 3 удаа, Эрүүл мэндийн газрын дэд баг 4 удаа хуралдаж, нөлөөллийн бүсэд амьдарч буй 1,866 иргэнээс эрсдэл өндөртэй 500 иргэнийг хяналтат үзлэгт хамруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж, цагаан тоосны нөлөөлөл болон түүнээс урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр хяналт, үзлэг, сургалт, мэдээлэл түгээх бүх төрлийн арга хэмжээнд нийт 400 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан байна. -Цагаан тоосны дэгдэлтийн бүс болох Жаргалант сум, Баянцагаан, Говил багийн иргэд болон хүүхдийн байгууллагуудад эрүүл мэндийг дэмжих 6 төрлийн өртөөт өдөрлөгийг 9 удаа зохион байгуулж, нийт 1510 иргэнийг хамруулсан. -Хяналтат үзлэгийн үр дүнгээр уушгины эмгэгтэй иргэдийн 86.8%-ийг эрт илрүүлж, 110 өндөр эрсдэлт иргэнийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хяналтад шилжүүлснээр өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлсэн. - Өдөрлөгт хамрагдсан 1510 иргэний дунд артерийн даралт ихсэх эрсдэл, бодисын солилцооны өөрчлөлт, амны хөндийн өвчлөл зэрэг гол эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлж, давтан хяналт болон амьдралын хэв маягийн зөвлөгөөг хүргэсэн. -Эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 28 төрлийн 42280 ширхэг зөвлөмжийг орон нутгийн телевиз болон цахим сувгаар түгээсний үр дүнд давхардсан тоогоор 154171 иргэний хандалт авч, эрүүл мэндийн мэдлэг,хандлагын түвшнийг сайжруулсан. -Гарын ариун цэвэр, усны эрүүл ахуй, амны хаалтны зөв хэрэглээ, агаарын чанарт үндэслэн зан үйл төлөвшүүлэх чиглэлийн мэдлэг, дадлын түвшин 49–100%-иар өссөн нь нөлөөллийн үйл ажиллагааны үр нөлөөг тодорхой харуулсан.	100
13	1.2.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд эрүүл		Тарьсан модны тоо	800	900	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ЭМГ-аас 1.100.0 төгрөгөөр 110 ширхэг бургас, 180 ширхэг шар хуайс, БОЭТ 5.000.0 төгрөгөөр 3000 ширхэг шар хуасыг төмөр замын өртөөний баруун задгай талбайд, 500 ширхэг агч модыг БОЭТ-ийн хашаанд тус тус тариж ургуулсан байна.	100

	мэндийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх						
14	1.2.4. Байгууллагын орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, өвлийн улиралд цас, мөсийг тухай бүрт нь арилган, халтиргаа гулгаа үүсэхээс урьчилан сэргийлж, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлж ажиллана.		Тайлан мэдээ	-	Тухай бүр	Эрүүл мэндийн дэмжих төвийн гадна талбайг өвлийн улиралд 45 удаа цас цэвэрлэж их цэвэрлэгээг 18 удаа хийлээ. -Хаврын улиралд өнжмөл шар өвсийг цэвэрлэж гадна талбайн модны тайралт хийж, гоёлын 3 мод тарьж, зүлэгжүүлэлт хийж, гадна талбайн өвсийг хадаж зөөж цэвэрлэсэн. -Эрүүл мэндийн дэмжих төвийн граж складанд ус орохоос сэргийлж, гадна талын шуудууг цементлэж шинээр хоолой татан, үерийн 3 даланд бөглөрсөн хогнуудыг цэвэрлэж хоолойн битүүмжийг арилган эрсдлийг бууруулж ажилласан. -Төрийн захиргааны 4 дүгээр байранд өвлийн улиралд 89 удаа цас цэвэрлэж, халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлж, эрүүл аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлсэн.	100
Зорилт 3. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.							
15	1.3.1. Шинээр сэргэж байгаа халдварт өвчин болон бүртгэгдсэн халдварт өвчний тохиолдол бүрт тандалт судалгаа хийж, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр хэрэгжиж буй тушаал шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээ авах чиглэлээр холбогдох салбарын байгууллагуудтай хамтран ажиллана ⁴		Хэрэгжил тийн хувь	92%	92.5%	Тайлант хугацаанд халдварт өвчний 684 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2.9 промиллоор буурсан байна. Нийт халдварт өвчний 51.5% амьсгалын зам, 23.7% БЗДХ, 4.7% гэдэсний, 20.2% бусад халдварт өвчин байна. 4 төрлийн 225 хам шинж, сэжигтэй тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 37 тохиолдлоор их байна. Цэврүүт тууралт 71,8%, халууралт тууралт 16,2%, бусад хам шинж 12% тус тус байна. -Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 4, Засаг даргын 2 албан даалгаврын хэрэгжилтийг хангахад АЗДТГ,БГ,ХГБХГ,ОБГ-тай хамтран ажилласан. Үүнд: ЭМС-ийн Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай 01 дугаар албан даалгаврын биелэлт 93,5%, Улаанбурхан өвчнөөс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах, дархлаажуулалтыг зохион байгуулах тухай 08 дугаар албан даалгаврын биелэлт 90,8%, Амьсгалын замын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн засаг даргын 01 дугаар албан даалгаврын биелэлт 91,3% тус тус байна. -Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн хурлыг 8 хийж, 17 асуудал хэлэлцэж, 14 шийдвэр гарган, хэрэгжилтийг 95,6%-тай ханган ажилласан. -Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээг аймгийн засгийн даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар Засаг даргын	100

						орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж, салбар дундын уялдаа холбоог хангаж, Аймгийн Онцгой Комисст танилцуулан, шийдвэрлүүлж хариу арга хэмжээг чадвахжуулж ажилласнаар 2025 оны 9 сараас хойш улаанбурхан өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээ, бэлэн байдал, хариу арга хэмжээ, тушаал шийдвэрийн хэрэгжилтийн чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагуудад 3 удаа, Хүүхдийн байгууллагуудад 2 удаа дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 92,9% байна.	
16	1.3.2. Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоог өргөжүүлэн, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, салбарын байгууллагуудтай хамтран ажиллана ⁴		Хэрэгжилтийн хувь	85%	85.5%	Тайлант хугацаанд Зоонозын шалтгаант болон дамжуулагчаар дамжих өвчний тандалтын тогтолцоо, хариу арга хэмжээний чадавхийг сайжруулахад салбар дундын оролцоог хангах үүднээс аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран “Зонхилон тохиолдох зоонозын халдварт өвчний тандалт, судалгаа, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион байгуулах хамтарсан удирдамж”-ийг батлуулан хэрэгжилтийг 80% ханган дараахь арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: -Орхон аймагт сүүлийн 10 жилд /2015-2024 он/ бүртгэгдсэн зоонозын шалтгаант хүний өвчлөлийн 67 тохиолдолд эргэмж судалгаа хийсэн. Тус өвчлөлийн 26.8%/18/ бруцеллөз, 40.3%/27/ хачигт энцефалит, 32.8%/22/ хачигт риккетсиоз тус тус эзэлж байна. -Сүүлийн 10 жилд хүний бруцеллөзын шинжилгээ 6376 хийснээс 12,1%/769/ халдвартай илэрсэн байна. Үүний 2,3%/18/ шинэ тохиолдол бөгөөд эдгээрийн 72,2%-ийг эмэгтэйчүүд эзэлж байна. Халдварыг 27,8% хүнсээр, 38,9% ахуйн хавьтлын замаар халдвар авсан бол 33,3% халдвар авсан зам тодорхойгүй байна. Насны хувьд 55,5% нь 10-29, 44,4% нь 35-49 хүртэл нас эзэлж, хөдөлмөрийн насны иргэд халдвар авч байна. -Мал эмнэлгийн лабораторид хийсэн сүүлийн 10 жилийн бруцеллөзын шинжилгээгээр 157 өрхийн 199 мал эерэг илэрсэн байна. Аймгийн хэмжээнд ажил эрхэлж буй 31 малын эмч нарыг бруцеллөз өвчний урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, 4 хүнийг идэвхтэй хяналтад аваад байна. Махны үйлдвэр болон махны худалдаа эрхэлдэг захын ажилчдын судалгааг шинэчлэн гаргаж, зоонозын халдвараас сэргийлэх сургалт, сурталчилгаанд 45 хүнийг хамруулсан. -Хачигт халдварын тохиолдлыг байршлаар авч үзэхэд Жаргалант сум, Эрдэнэ, Яргуйт багт өвчлөл өндөр/44,4%/ бүртгэгдсэн бөгөөд 26,5% Булган аймгийн иргэд байна. Хачгаар дамжих халдвараас сэргийлэх чиглэлээр 3 удаагийн мэдээлэл орон нутгийн хэвлэлээр өгч, 5400 хүнд хүргэсэн. Хачгаар дамжих халдвартай холбоотой байгууллагын цахим хуудсанд нийт 16 зурган болон видео шторк нийтлэгдсэн бөгөөд тус мэдээллийг давхардсан тоогоор 9773 хүн үзэж танилцсан байна. -“Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай” эрүүл мэндийн сайдын 03 албан даалгаврын хэрэгжилтийг хангах төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг 87,5% ханган	100

						ажилласан. Тарваган тахал өвчний сэжигтэй 1 тохиолдол бүртгэгдэж, хариу арга хэмжээг авч ажиллан, онош үгүйсгэгдсэн. -Эмч, эмнэлгийн ажилтнуудад 2 удаагийн сургалт зохион байгуулж, 32 хүн хамрагдсан. 23 төрлийн, 32 удаагийн шторк,сэрэмжлүүлэг контент бэлтгэн цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр түгээж, нийт 27,830 иргэнд хүргэсэн. байна. Хэвлэлээр 3 удаа мэдээлэл өгсөн. -Зоонозын халдварт өвчнөөс эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах 4 чиглэлээр 16 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг 85,7% ханган ажилласан нь өмнөх оны мөн үеэс 2,7%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар орон нутагтаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
17	2.1.1.Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинээр дэвшилтэт технологи нэвтрүүлэх, нэвтэрсэн технологийн ашиглалтыг сайжруулж, хүртээмж үр дүнг тооцож ажиллана.	60,2 сая ОНТ	Ашиглалт ын хувь	90,8%	91,0%	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн хангалт 96%-д хүрч, нийт 600 гаруй шаардлагатай ба нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан, үүнээс 20.1%нь дэвшилтэт технологийн төхөөрөмжүүд эзлэж байна. Орхон аймагт нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн ашиглалт хүртээмж, үр дүнг тооцон, тайлант хугацаанд хавдрын оношилгоог чадавх жуулах хүрээнд 602,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжруулсан бөгөөд доорхи дэвшилтэт технологиудыг тогтвортой нэвтрүүлэн лавлагаа шатлалд явах урсгалыг 30,0%-иар бууруулсан байна. Үүнд: -Харвалт шигдээсийн төвийг 2021 онд байгуулан 2025 онд 1000 дахь хүндээ хийснээс зүрхний титэм судасны ангиографийн оношилгоо, эмчилгээг тайлант хугацаанд 406 хүнд , элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээ 44, тархины судасны оношилгоо эмчилгээ 34, зүрхний хэм алдагдлын байнгын суулгац 1, хавдрын хими эмчилгээний үеийн венийн судасны порт 12 хийсэн байна. -БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад орон нутгийн төсвөөс 75 сая төгрөгийг шийдвэрлүүлэн,амбулатори,түргэн тусламжийн тасагт цахим бүртгэлийн системийг бүрэн нэвтрүүлж хүлээгдлийг бууруулж байна. -Мухар олгойг дурангаар авах мэс заслыг нэвтрүүлж 11 хүнд амжилттай хийгдсэн байна. -Шээлгүүрийн дурангаар 5 хүнд шээлгүүрт стент тавих, чулуу авах 2 үе шаттай хагалгааг хийсэн байна. -Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6%-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар нэмэгдсэн. Тайлант хугацаанд төрсөн 1435 нярайг нярайн тандалт скрининг 5 төрлийн шинжилгээнд 100% хамруулсан. -Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь 2024 онд	100

						үйлдвэрлэгдсэн GEE6 өндөр нягтралтай ургийн эхо аппаратаар жирэмсний 11 долоо хоногт ургийн гажгийг эрт илрүүлэх оношилгоо шинжилгээг 237 жирэмсэн эхэд хийсэн байна. Дэлхийд тэргүүлэх “General Electric” компанийн дүрс оношилгооны MRI болон СТ аппаратаар тайлант хугацаанд 1025 иргэнд үйлчилсэн байна.Тархины судасны доплерийн төрөлжсөн мэргэшлийн сургалтад 1 эмчийг хамруулан 76 хүнд оношилгоо хийгдсэн байна. -Өрхийн эрүүл мэндийн төвүүд 5 төрлийн шинэ лабораторийн шинжилгээг нэвтрүүлж, цусны дэлгэрэнгүй, шээсний ерөнхий шинжилгээ,биохимийн 14 төрлийн үзүүлэлт, иммунологийн түргэвчилсэн 6, тоон үзүүлэлтээр 5 төрлийн үзүүлэлтийг шинжилж, 55060 хүнд лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлсэний 99.8% нь төлбөргүй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. -Хувийн хэвшилд Баян-Өндөр Мед эмнэлэг хиймэл оюун ухаанд суурилсан “CerviCare AI” системийг нэвтрүүлж, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг 1452 хүнд хийж, 36 хүнийг онош тодруулан эмчилгээнд хамруулсан.RMC эмнэлэгтэй хамтарсан Үргүйдлийн оношилгооны кабинетаар 73 иргэнд үзлэг хийж, 32 хүнийг лавлагаа шатлалд илгээсэн байна.	
18	2.1.2.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж, үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана ⁵		Хэрэгжилтийн хувь	82.6	85.0	Тайлант хугацаанд төр, хувийн хэвшлийн 24 эрүүл мэндийн байгууллагын “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага”MNS7014:2023 стандартын үнэлгээг 2 удаа хийж, хэрэгжилт дунджаар 85,8%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,3%-иар нэмэгдсэн. Дүгнэлт,зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд доорхи ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: -Бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя”аяныг зохион байгуулж, чанарын өдөрлөг 2, хэлэлцүүлэг 3, дэмжлэгт хяналт, үнэлгээ 2, сургалт 6, туршлага солилцох уулзалт 4 удаа зохион байгуулсан. -Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт нэгдсэн чанарын өдөрлөг зохион байгуулж,ЭМБ-уудын 58 эмч, эмнэлгийн ажилтнууд хамрагдан чадавхжсан байна. -ЭМГ-ын дэргэдэх Сувилахуйн зөвлөлтэй хамтран зохион байгуулсан “Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал-Тарилга хийх арга техникийг сайжруулах нь” хэлэлцүүлэгт Эрүүл мэндийн байгууллагын 41 арга зүйч, ахлах сувилагчийг хамруулан чадавхжуулсан . -“Халдварын сэргийлэлт хяналт, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад анхаарах нь” сэдэвт салбарын дундын хэлэлцүүлэгт анхан, лавлагаа шатлал, хувийн хэвшлийн 40 эмч,мэргэжилтнүүдийг хамруулан чадавхжуулсан. -Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Дохионы хэлний дунд шатны сургалт, Тарилгын аюулгүй байдал, Халдвар дамжих эрсдэл ба урьдчилан сэргийлэлт зэрэг 4 сэдвээр 166 эмч, эмнэлгийн	100

						мэргэжилтнүүдийг сургалтад хамруулан мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. -Төр хувийн хэвшлийн 24 эрүүл мэндийн байгууллага аяны хүрээнд хийсэн ажлыг танилцуулж, Эмчилгээ чанарын алба,баг,Сувилахуй,Халдвар сэргийлэлтийн хяналтын баг, Дотоод хяналтын багууд туршлага солилцож, эхний 3 байранд Мэндцэцэн,Талын булаг, Мөнхийн үйлс эрүүл мэндийн байгууллагууд шалгарсан байна. -Аяны үр дүнд Эрүүл мэндийн байгууллагуудад дотоод болон гадаад орчны үнэлгээ хийгдэж, явган хүний налуу зам,замын бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүний автомашины зогсоол, зогсоолын тэмдэглэгээ зэргийг шинээр хийж, үйлчлүүлэгчдэд ээлтэй аюулгүй тав тухтай орчинг бүрдүүлж, мэдээллийн самбар, шатны зөөлөвч, таяг, харааны шил, дуугүй хөтөч, ханын бариул, дуслын хонх, дуут дохионы хангалтыг Эрүүл мэндийн байгууллагууд нэмэгдүүлсэн байна. -Орон нутгийн 535,2 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн бүх тасаг нэгжийн ариун цэврийн өрөөнүүдийг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцүүлэн зассанаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлээд байна.	
19	2.1.3.Эмнэлгийн тусламж үйлчилгээн дэх эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавина.		Эмнэлзүйн удирдамж, стандартын хэрэгжилтийн хувь	70%	70.5%	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудын нөхөн үржихүй, жирэмсэн, хүүхэд, хүн амд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээнд хэрэгжиж байгаа ЭМС-ын 2023 оны А/292,ХӨЦМХөтөлбөр,өрхийн эмнэлгийн MNS5292:2017 стандарт, эмнэлзүйн удирдамжуудын хэрэгжилтэд үнэлгээ хийж, дунджаар 77%-ын хэрэгжилттэй байна. Тус үнэлгээнд сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвийн 42 эмч хамрагдан, 4 өртөөгөөр онолын мэдлэг,ур чадварын үнэлгээ хийгдсэн. Үүнд: -Халдвараас сэргийлэлт хяналтын өртөөний дундаж -89%(гар угаалт 94%, эмнэлгийн хувцас өмсөж тайлах 90%,хамгаалах хувцас,хэрэглэл өмсөх, тайлах 85%) -Хүүхдийн үзлэгийн өртөөний дундаж 84%,ХӨЦМ-ийн үнэлгээ 86%, 9,18,36 сартай хүүхдийн үзлэг 82%) -Жирэмсний эрсдэлийн үнэлгээний өртөөний дундаж 70.6% (эх барихын гадуур үзлэг 79%, жирэмсэн эхийн аарцгийн хэмжилт 86%,манас таталтын урьдлын оношилгоо, урьдчилан сэргийлэлт 56%, гүний венийн бүлэнт бөглөрлийн эрсдлийн асуумж 58.8%, жирэмсний яаралтай тусламж, кейс 77%) -Зөвлөгөө өгөх өртөөний дундаж 64% (жирэмсний дотор муухайралтын үеийн хооллолт 65.2%, жирэмсний үеийн цус багадалтын зөвлөгөө 76.5%, гэр бүл төлөвлөлт 52.7%,хөхөөр хооллолт, зөв үмхүүлэх 61.5%,ахуйн осол гэмтлээс сэргийлэх, хүүхдийн хэл яриа хөгжүүлэх зөвлөмж 64.4% тус тус байв. - Үнэлгээнд суурилан 70 ба түүнээс бага үнэлгээтэй жирэмсний эрсдлийн үнэлгээ, жирэмсний манас таталт, зөвлөгөө өгөх өртөөний асуултад	100

						тулгуурласан мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн 16 удаагийн сургалтад давхардсан тоогоор 291 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. Анхан болон лавлагаа шатлалын 24 байгууллагын үйлчлүүлэгчийг танин тодруулах,эрэмбэлэн ангилах,амиллуулах яаралтай тусламж, дотор, халдварт, хүүхдийн чиглэлээр эмнэлзүйн 15 удирдамжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, дунджаар 81,5%-тай дүгнэгдсэн. Эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр салбарын хэмжээнд Эмчилгээ чанарын алба, багуудтай хамтран хэлэлцүүлэг 3, дадлагат орон нутгийн болон төвийн сургалт 6, ижил мэргэжилтний үнэлгээ 84 удаа, ажил мэргэжлийн уралдаан 1-ыг зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 256 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан.	
20	2.1.4.Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийг түшиглэн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлж “Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт-сэргийлэлтийн төв” байгуулна.²	ОНТ 390.0 сая	Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо	70	80	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийг түшиглэн орон нутгийн 350 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хавдрын оношилгоо,эмчилгээ,хяналт сэргийлэлтийн төвийг 2025 онд өргөжүүлэн нийт 223.4м2 талбайд үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэг,хавдрын амбулаторийн үзлэг,хавдрын бүртгэл,эхо оношлогоо,мэс заслын эмчийн үзлэг, хими бай эмчилгээний өрөөг байгуулж, үйлчлүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлсэн. -Тайлант хугацаанд тус төвөөр нийт 5083 иргэн хавдрын эрт илрүүлэгт хамрагдаж, шинээр 147 хавдар илэрч, идэвхтэй хяналтад 458 иргэнийг аваад байна. Нийт хавдрын 53.7 хувь нь эрт үедээ, 46.3 хувь нь хожуу үедээ оношлогдсон.Хими эмчилгээнд тайлант хугацаанд 505 хүн, бай эмчилгээнд 161 хүн хамрагдсан байна. -Эмгэг судлалын оношилгоо, гистологи, эсийн шинжилгээний үйл ажиллагааг сайжруулах зорилгоор улсын төсвөөс 800 сая төгрөгийн өртөг бүхий иж бүрэн багц тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлж, суурилуулагдан эд эсийн түвшний оношилгооны чадавхи нэмэгдсэн байна. 2025 оны Монгол Улсын Засгийн газрын 42 дүгээр тогтоолоор Эрдэнэт Медикал эмнэлгийг Хавдар Судлалын Үндэсний төвийн харьяа Хавдрын оношилгоо эмчилгээний дэд төв болгосон.Ингэснээр Хойд бүсийн хэмжээнд хавдрын төрөлжсөн тусламж үйлчилгээг үе шаттай үзүүлэхээр 2026-2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөө батлагдан, 98 ортой эмнэлгийн зураг төсөв хийгдээд байна. ХСҮТ-өөс элэг, улаан хоолой, хөх, зөөлөн эд, өндгөвч, бөөр, давсаг, нойр булчирхай, бүдүүн гэдэс, хүзүүний хавдрын оношилгоо, эмчилгээний чиглэлээр 3 эмч 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн ажиллаж, нийт 111 иргэнд үзлэг хийж, зөвлөгөө өгсөн байна. 2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөл хорт хавдартай 213 иргэнд нийт 120,000.000 төгрөгний буцалтгүй дэмжлэг олгосон байна. 2025 онд шинээр батлагдсан 238 хавдрын тохиолдлын 89,5 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна. Тайлант хугацаанд 284 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдож, 10000	100

						хүн амд 26.7 промилл байгаа нь өмнөх оны мөн үеэс тохиолдол буюу 3.9 промиллоор өссөн байна.Хорт хавдрын тохиолдлын 112 эрэгтэй, 172 эмэгтэй байна.	
21	2.1.5.Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний багийг орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэн ажиллана ⁵	ОНТ 50.0 сая	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо	70	150	Тайлант хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан Үндэсний баг Орхон аймагт 2 удаа ажиллан ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, зүрх судас, хими эмчилгээ, элэг цөс, тархи мэдрэлийн чиглэлээр нийт 534 иргэнд үзлэг хийж,орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах онол, дадлагат сургалтад давхардсан тоогоор 125 хүнийг хамруулан, хамтарсан үзлэг оношилгоо, хагалгаа хийж чадавхжуулсан байна.Үүнд:Үндэсний багийн эмч нартай хамтарч элэгний мэс засал 4,ангио мэдрэлийн ТАСЕ 11 мэс заслыг хийсэн бол бие дааж элэг тайрах мэс засал 1, нойр булчирхайн мэс засал 1, ходоод тайрах мэс заслын-2, хөхний хавдрын мэс заслын 3 тохиолдлыг амжилттай хийгээд байна. Үндэсний багийн эмч нартай хамтарч 14 тархины судасны ангиографийн оношилгоо хийгдсэнээс тархины судасны аневризмийн 6, гүрээний судасны бөглөрөл ба нарийслын 1 тохиолдол тус тус шинээр оношлогдсон. Үүнтэй холбоотойгоор орон нутагт нэвтрээгүй зарим мэс заслыг нэвтрүүлэх зорилгоор ШУГТЭ,УХТЭ-т хүсэлт хүргүүлэн хамтарч, гүрээний судасны бөглөрөл, нарийсалд стент тавих 1, судсан дотуур аневризм засах 1 мэс заслыг амжилттай хийсэн.Доод мөчдийн их өнгөц венийн судасыг суглаж авах мэс заслын 7 тохиолдлыг бие даан амжилттай хийж байна.Үүнд 2 хүнд элэгний хавдрын судас бөглөх эмчилгээ,3 хүнд элэгний хавдрын мэс засал, 30 хүнд хөхний үзлэг, оношилгоо хийж, 3 хүнд хөхний мэс засал хийгдсэн.Үндэсний багийн орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардалд орон нутгийн төсвөөс 50,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна. Хавдрын оношилгоо, эмчилгээ,хяналт сэргийлэлтийн төвийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх ажлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр БОЭТ-ийн хавдар болон мэс заслын чиглэлээр нийт 3 эмчийг ХСҮТ-д нарийн мэргэжлийн сургалтад хамруулан хүний нөөцийг чадавхжуулсан байна.	100

22	2.1.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлыг бүртгэх, тандан судлах, хариу арга хэмжээ болон халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах ажлыг зохион байгуулна. ⁵		Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой бүртгэгдсэн тохиолдлын тоо	275	245	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн байгууллагуудын Эмчилгээ чанарын алба, багууд хурал 86, дотоод хяналт 92, ижил мэргэжилтний үзлэг 24 чиглэлээр 148 удаа хийж, тусламж үйлчилгээтэй холбоотой 206 тохиолдол бүртгэн 82 хариу арга хэмжээг авч ажиллан, тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр төвийн болон дотоодын 24 сургалт, хэлэлцүүлэг 4, дотоод хяналт 56 чанарын өдөрлөг 3 удаа, туршлага солилцох уулзалт 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 342 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд http://eburtgel.moh.gov.mn цахим программд тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, эрсдэлийг бүртгэж хэвшсэн ба Эрүүл мэндийн газраас программын бүртгэл, хариу арга хэмжээний хэрэгжилтийн байдалд тогтмол хяналт тавьж зөвлөмжөөр хангаж ажилласан. Тайлант хугацаанд бүртгэгдсэн 245 тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлоос эмнэлзүйн шалтгаан 56,8%, эмнэлзүйн бус шалтгаан 43,1%, бусад 0,1% бүртгэгдэж, хариу арга хэмжээг 92,5%-д авч ажилласан байна. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагууд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол бүртгэлийн цахим программ (eburtgel.hdc.gov.mn)-д нийт 92 тохиолдлыг бүртгэсэн байна. Үүнд алдах дөхсөн тохиолдол (1А) - 23 буюу 25%, тохиолдол (1Б) - 17 буюу 23%, таагүй тохиолдол - 15 буюу 16%, ноцтой тохиолдол - 2 буюу 2%, эмнэлгийн алдаа - 14 буюу 15%, бүртгэсэн боловч ангилаагүй 21 тохиолдол буюу 23% байна. Тохиолдлын шийдвэрлэлт хүлээгдэж байгаа-42 (46%), шийдвэрлэгдсэн- 50 (54%), цуцлагдсан- 2 тохиолдол байна. Тохиолдол гарахад нөлөөлж буй хүчин зүйлст үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах, үр дүнтэй харилцааг сайжруулах, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, үйлчлүүлэгчийн болон баримт бичиг, цахим бүртгэлийн хүчин зүйлс голчлон тохиолдол гарахад нөлөөлж байна гэж дүгнэсэн. Эрүүл мэндийн байгууллагуудад тохиолдол бүртгэх, нөлөөлж буй хүчин зүйлсийг оновчтой дүгнэх, бүртгэсэн тохиолдлын хэрэгжилтийг цахим программд оруулах зэрэг зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМБ-уудын халдварын сэргийлэлт хяналтад 2 удаагийн дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж өгч, халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах чиглэлээр салбар дундын хэлэлцүүлэг 2 удаа, төвийн болон орон нутгийн сургалт 6 удаа хийж, давхардсан тоогоор 142 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан байна. Тайлант хугацаанд халдварын сэргийлэлт хяналтыг сайжруулах чиглэлээр ЭМС-ын А/539 тоот тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хяналт тавиж ажиллан 4 төрлөөр 18 эрүүл мэндийн байгууллага нийт 52000 орчим үйлчлүүлэгчдэд тандалт хийж, ЭТҮХХ-ын сэжигтэй 8 тохиолдлыг бүртгэн хариу арга хэмжээг авч ажилласан.	100
23	2.1.7. Иргэдийн дунд авлагагүй донорын эгнээг өргөжүүлж,	ОНТ 10.0	Цус цусан бүтээгдэх	100%	100%	БОЭТ-ийн Цусны салбар төв нь 10 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа бөгөөд цус цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өмнөх онтой хартцуулахад 17%-аар өссөн буюу 1504 нэгж цус цусан	100

	аюулгүй цус цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ. ^{1,2,3,5}	сая	үүний хангалтын хувь			бүтээгдэхүүн үйлдвэрлэж, цус цусан бүтээгдэхүүний хангалт 100%-тай байна. -Цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээнд 688 донор 100% баталгаажиж 3,7% хасагдсан нь өмнөх оны мөн үеэс 0,6 хувиар өссөн сийвэнгийн 6 сар, цусны О-16, А-3, В-11, АВ- бүлгийн цусны 2 сарын нөөцтэй байна.Тайлант хугацаанд бүхэл цусны 403 донороос 403 нэгж цус цуглуулснаас байнгын 280 донороос 280 нэгж цус, шинэ 123 донороос 123 нэгж цус цуглуулсан байна. Нийт цус цуглуулалтын 80.9%-ийг суурин хэлбэрээр, 19.1%-ийг явуулын хэлбэрээр цуглуулсан ба явуулын цус цуглуулалт 57,1%, нийт цус цуглуулалт өмнөх оноос 18.4% тус тус өссөн, шинэ донорын элсэлт өмнөх оноос 2,1%-иар буурсан үзүүлэлттэй байна - Цусны салбар төвд 2025 онд бүртгэлтэй байгаа 403 донорын цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамруулан баталгаажуулж, цус цусан бүтээгдэхүүн сэлбэлттэй холбоотой урвал хүндрэл бүртгэгдээгүй байна. Тайлант хугацаанд 1680 нэгж цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос 11.4%, хэрэглээний хувьд 1201 цус, цусан бүтээгдэхүүн хэрэглэсэн нь өмнөх оноос 15.4% тус тус өссөн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн цусны салбар төв нь 2025 онд бүртгэлтэй нийт 751 донорыг цусны АВО, Резус бүлэг, Келл бүлэг, халдвар илрүүлэх шинжилгээнд хамруулж 100% баталгаажуулсан. Мөн 30 донорын тохойн арчдас, хадгалалтын дуусах хугацаа ойртсон 10 нэгж улаан эсийн бүтээгдэхүүнд ариун чанарын шинжилгээ хийж баталгаажуулсан. -Орхон аймгийн Засаг даргын А/250 тоот захирамжийн хүрээнд 5 үйл ажиллагаа төлөвлөн биелэлт 97%-тай хэрэгжсэн бөгөөд “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх 3 зорилт, 13 үйл ажиллагааг төлөвлөн 100% гүйцэтгэж өдөрлөгт нийт 300-аад зочид төлөөлөгчид, хүндэт донор, идэвхтэн донор, байгууллага, иргэд оролцсон. -Орон нутгийн 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр “Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ бэлэглэе” уриан дор сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлэх, цусны аюулгүй байдлыг хангах, донор хадгалах идэвхи санаачилгыг өрнүүлэх аяныг зохион байгуулж, 8 байгууллагын 287 донор цус бэлэглэж, 7 байгууллагын 142 хүнд донорын ач холбогдлыг таниулах мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж, өмнөх оны мөн үеэс 37 донороор нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд 2025 онд 17 байгууллагын 355 иргэн сургалтад хамрагдаж 287 донор, бүртгэлтэй 3203 донороос 390 донор тус тус цусаа бэлэглэж донорын цусаа бэлэглэх үзүүлэлт өмнөх жилүүдтэй харьцуулахад 18,4% өссөн үзүүлэлттэй байна.	
24	2.1.8. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээний		Алба, багийн төлөвлөг	90%	92%	Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв, хувийн хэвшлийн ортой 13 клиникт чанарын баг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг,Баян-Өндөрмөд нэгдсэн эмнэлэг,	100

	чиглэл бүрээр алба, багуудыг чадавхжуулах, мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавина.		өөний хэрэгжилтийн хувь		Эрдэнэт сувилал цогцолборт нийт чанарын 5 алба ажиллаж байна. -Эрүүл мэндийн байгууллагуудын 92,5% нь үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийг танин тодруулах журмыг хэрэгжүүлж хэвшсэн бөгөөдхэрэгжилт 94.5%-тай байна. Эмчилгээ чанарын албад, багийн чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилт дунджаар 92,5%-тай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,5%-иар нэмэгдсэн байна. -Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж,"Чанар аюулгүй байдлыг сайжруулах төлөвлөгөө"-ний хэрэгжилт, Эмчилгээ чанарын алба, баг, Халдварын сэргийлэлт хяналт, Дотоод хяналтын багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 5 удаа,үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, тусламж үйлчилгээг дэмжих алба, багуудыг чадавхжуулах чиглэлээр аян 2, өдөрлөг 2, чадавхжуулах чиглэлээр сургалт мэдээлэл 9 удаа хийж,давхардсан тоогоор багийн 124 гишүүдийг хамруулан чадавхжуулж, холбогдох зөвлөмжөөр хангаж ажилласан Үүнд: -Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг "Бүх нярай, хүүхдэд аюулгүй тусламж", "Эхнээс нь аюулгүй тусламж" гэсэн уриан дор 19 байгууллага тэмдэглэн өнгөрүүлсэн. Уг аяны хүрээнд нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 462 нярай, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчид хамрагдсан. Өдөрлөгөөр нярай, хүүхдүүдэд үзлэг оношилгоог хийж, эцэг, эх асран хамгаалагч нарт нярайн асаргаа, сувилгаа сэдвээр сургалт, зөвлөгөөг өгч, гарын авлага тараасан. Анхан шатны 9 эрүүл мэндийн байгууллагын 24 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулан БОЭТ-ийн бүх тасгуудад унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх анхааруулга, хамгаалалтын хашлага,тусламж дуудах хонх суурилуулж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Үйлчилгээ үзүүлэгч болон үйлчлүүлэгийн аюулгүй байдлыг хангах өдөрлөгийг зохион байгуулж, аймгийн төр, хувийн хэвшлийн 24 байгууллагын 58 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдан мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн. --Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албыг чадавхжуулах 4 удаагийн сургалтад 71 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, Монгол-Япон эмнэлэгтэй хамтран "Сувилагчийн эмнэлзүйн ур чадварын шатлалыг нэвтрүүлж, тусламж үйлчилгээг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 26 байгууллагын 80 сувилагч,тусгай мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан. -Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, халдвараас сэргийлэлт хяналтын багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 2 удаа хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгсөн. -Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол их бүртгэгдсэн Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээний	
--	---	--	-------------------------	--	--	--

						чанар, аюулгүй байдлын багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийг ажлын байранд үнэлж зөвлөмж өгч ажилласан.	
Зорилт 2. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар иргэдийг нэг цэгээс тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх							
25	2.2.1.Өрхийн эрүүл мэндийн төвтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулан, гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж, гүйцэтгэлд хяналт тавиж, орон нутагт түр оршин суугч (отор), явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ. ^{4,5}		Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээний дундаж хувь	90%	91%	Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 8 өрхийн эрүүл мэндийн төвтэй Аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулан тайлант хугацаанд өрхийн гэрээний хэрэгжилтийг ажлын байранд болон цахимаар 2 удаа үнэлж, жилийн эцсийн гэрээний хэрэгжилтийн үнэлгээ 89.9%-тэй байгаа нь өмнөх оны мөн үеэс 6.8%-иар буурсан байна.ЭМЯ-аас баталсан удирдамжийн дагуу ЭМС-ын А/320 дугаар тушаал, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны стандарт MNS 5292:2017-ын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд 96.8%-тай байна.Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5092:2017 стандартын дагуу 8 багц 69 төрөл тоног төхөөрөмж байх шаардлагатайгаас хангалтын хувь 96,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9%-иар нэмэгдэж, ашиглалтын хувь 96%-д хүрсэн байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн байршил, үйлчлэх хүрээний саналыг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн 2025 оны 03/47 дугаар тогтоолоор шинээр 2 өрхийн эрүүл мэндийн төв байгуулах болсноор хүн амд хүргэх анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого зохицуулалт хийгдсэн байна. Тайлант хугацаанд өрхийн эрүүл мэндийн 5 төв шинээр ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлснээр өрхийн эрүүл мэндийн 8 төв 100% чанарын менежментийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн амжилттай ажилласан байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд 360,621 үзлэг хийгдэж, аймгийн хэмжээний нийт үзлэгийн 49.5 хувийг эзэлж байна.. Үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэг 185,773 (51.5%), гэрийн идэвхтэй хяналт - 109,869 (30.5%) байна.Артерийн гипертензи өвчний эрт илрүүлэг- 78.6%, чихрийн шижин 2 өвчний эрт илрүүлгийн хамрагдалт 100%, үүнээс шинээр оношлогдсон АГ - 333 (0.6%), чихрийн шижин - 159 (0.4%) байна. Оны эхэнд нийт 8058 хүн диспансерын хяналтад байсан ба эдгэрсэн - 680, шилжсэн - 549, нас барсан - 144, шинээр хяналтад авсан - 1846 хүн орж, тайлант хугацаанд 8531 хүн идэвхтэй хяналтад эмчлэгдэж байна. Явуулын, түр оршин суугч 4570 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлсэн. Мобайл технологиор тайлант хугацаанд 5 өрхийн эрүүл мэндийн төв 1500 гаруй хүнд явуулын ЗЦБ, эхо оношилгоо хийгдсэн байна. Тайлант хугацаанд 1313.mn сайтад 8 өрхийн эрүүл мэндийн төвд 6705 иргэн үнэлгээ өгсөн ба дунджаар 3.6 (2.9-4.5)-тай, талархал-116, хүсэлт-7 байна.Сэтгэл ханамжийн судалгааг 444 хүнээс авсан бөгөөд Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв 1111, аймгийн ЗДТГ-ын иргэдтэй харилцах 70353511-т өрхийн эрүүл мэндийн төвтэй холбоотой	100

						65 хүсэлт ирсэн нь өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан байна. Үүнээс талархал 51 (80%), гомдол 10 (15.3%), хүсэлт 3 (4.7%) эзэлж байна.	
26	2.2.2.Жаргалант сумын эрүүл мэндийн төвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.		Гэрээний хэрэгжилтийн хувь	92,8 %	93.0%	Жаргалант сумын эрүүл мэндийн төв 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилт, 66 арга хэмжээ төлөвлөж, төлөвлөгөөний хэрэгжилт 93.4% болж, өмнөх оны мөн үеэс 0.4%-аар нэмэгдсэн байна. Тайлант онд орон нутгийн 223.5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар эмнэлгийн граж, мооргийн барилга, тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн байна. Хүний нөөцийн хангалтын хувь 88.2%, зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн хангалтын хувь - 90%-тай байна. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд нийт 12,059 үзлэг хийгдэж, өмнөх оны мөн үеэс 2967 тохиолдлоор нэмэгдсэн. Урьдчилан сэргийлэх үзлэг 33.8%, гэрийн идэвхтэй үзлэг 22.2%, гэрийн дуудлага 691, үүнээс алсын дуудлага, бүртгэгдсэн өвчлөл 54 байна. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Эрүүл Жаргалантчууд хөтөлбөр, Төлөөлөгчдийн манлайлал – Төрийн үйлчилгээ, Цагаан тоосны нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор 1202 хүн хамруулсан байна. Эрт илрүүлэг: Артерийн гипертензийн эрт илрүүлгийн хамрагдалт - 1569 (69.3%), чихрийн шижин 2 өвчний хамрагдалт - 1095 (74%), хөхний үзлэг – 737 (90%), умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг – 113 (56.8%), элэгний хорт хавдрын эрт илрүүлэг – 90 (55.9%) байна. Хэт авиан шинжилгээнд 507 иргэн хамруулснаас 3 элэгний үүсгэвэр шинээр оношлогдож, ХСҮТ-д онош тодруулж шинээр 1 элэгний хавдар оношлогдож эмчилгээнд хамрагдсан. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ: Жирэмсний хяналтад шинээр 37 эмэгтэй хамрагдаж, эрт үеийн хяналт – 94.6%, 6 ба түүнээс дээш хамрагдалт – 92.5% байна. Нийт 40 эх төрсөн ба тайлант хугацаанд нярайн эндэгдэл – 2, эхийн ноцтой хүндрэл, төрөлхийн тэмбүү – 1 тохиолдол бүртгэгдсэн. Тав хүртэлх насны 229 хүүхдийг 976 удаа гэрийн эргэлт хийж, 9,18,36 сартай 71 хүүхдийг MORBAS үнэлгээнд хамруулсан байна. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр оношилгоо, шинжилгээ - 837, өдрийн эмчилгээ - 232, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ - 168, яаралтай тусламж - 514, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ – 321, түргэн тусламжийн дуудлага – 691 хүнд үзүүлсэн. Уламжлалт сэргээн засах тусламж үйлчилгээг 655 хүнд 3062 удаа үзүүлсэн. Явуулын болон түр оршин суугч 700 гаруй иргэн, хөдөө малчдын эргэлтээр жилд 2 удаа 483 өрхийн 851 хүнийг үзлэгт хамруулан ажилласан байна.	100
27	2.2.3.Анхан шатлалын эрүүл мэндийн	ОНТ	Тоног төхөөрөм	95,5 %	95,6%	Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалт, мобайл технологи ашиглан тусламж үйлчилгээ	100

	байгууллагыг тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар ханган,мобайл технологи ашиглан тусламж үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана. ^{2,5}	133.5 сая	жийн хангалтын хувь		үзүүлж байгаа байдалд тогтмол хяналт тавьж, дэмжлэгт хяналт, зөвлөмжөөр хангаж ажилласан.2025 онд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж, лабораторийн тусламж үйлчилгээний нэр төрлийг сайжруулах чиглэлээр нийт улс, орон нутгийн 173.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, машин олгосон байна. Орон нутгийн 141.5 сая төгрөгийн санхүүжилтээр: -Шарлагын аппарат-Мөнхсүндрэл, Анхны оч -Цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппарат-Анхны оч -Мобайл технологи-Нийцэл -Жаргалант суманд иммунологийн аппарат, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний иж бүрдэл, поток, искра аппаратууд нийлүүлэгдсэн байна. -Улсын төсвийн 31.5 сая төгрөгийн өртөг бүхий ECG S120 эрт илрүүлэг хийх зүрхний цахилгаан бичлэгийн аппарат 9 сум, өрхийн эрүүл мэндийн төвд олгосон байна. -Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5092:2017 стандартын дагуу 8 багц 69 төрөл тоног төхөөрөмж байх шаардлагатайгаас хангалтын хувь 96,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9%-ар нэмэгдэж, ашиглалтын хувь 96%-д хүрсэн байна. - Өрхийн эрүүл мэндийн төвийн лабораторийн шинжилгээнд бамбайн даавар, витамин Д, глюкозын гурван сарын дундаж үзэж, сэргээн засах тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. -2019-2025 онд анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад мобайл технологийг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна. Орон нутгийн төсвөөр 2024 онд 3 өрхийн эрүүл мэндийн төвд, 2025 онд Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд олгож, Орхон аймгийн 7 (77.8%) анхан шатны эрүүл мэндийн байгууллагад мобайл технологийг нэвтрүүлж, өмнөх оны мөн үеэс мобайл технологийн хангалт 11.1 хувиар нэмэгдсэн байна. -Мобайл технологийн зөөврийн эхо,зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийг гэрийн эргэлт болон урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд ашиглаж байна. Тайлант хугацаанд мобайл технологиор 2025 онд 2360 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.Үүнд:Эхо-204, ЭКГ- 2156 хүнд хэвтрийн, байнгын асаргаа шаардлагатай 51 ахмадад давхардсан тоогоор 204 удаа зөөврийн эхо оношилгоо хийсэн.Зөөврийн ЭКГ-ээр 2156 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс ахмад-291 (13.5%), ХБИ-35 (1.6%), залуучууд-1830 (84.8%) байна. -Тайлант хугацаанд Баян-Өндөр сумын ИТХ-ын санхүүжилтээр Нийцэл өрхийн эрүүл мэндийн төвд гэрийн эргэлтэд шаардлагатай 30 сая төгрөгний үнэлгээ бүхий prius 30 автомашиныг ОНӨГ хүлээлгэн өгсөн. -Баян-Өндөр сумын ИТХ-ын 40 сая төгрөгний санхүүжилтээр хавдарын маркер үзэх, урвалж оношлуураар хангаснаас ӨЭМТ-д хавдрын маркер, триглицерид,липид,иммунологийн шинжилгээ /CRP, TSH,витамин Д, глюкозжсон гемоглобин/ зэрэг шинжилгээний үзүүлэлтээр тусламж үйлчилгээний нэр төрөл нэмэгдсэн.	
--	---	--------------	---------------------------	--	--	--

						-Өрхийн эрүүл мэндийн төвүүд тамхинаас гаргах чихний зүү эмчилгээ, парафин, шавар эмчилгээ, хүчилтөрөгчийн коктейль, бүтэн биеийн массажны сандал,битрон гэрлийн аппаратыг нэмэгдүүлэн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	
Зорилт 3. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, тусламж, үйлчилгээнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах							
28	2.3.1. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэх, жирэмсний хяналтын чанарыг сайжруулан, жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В,С вирусийн илрүүлэг шинжилгээний хамралт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн, эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, хавьтлын илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд хяналт тавин төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана. ⁵		Жирэмсний эрт хяналтын хувь	98,3%	98,4%	Тайлант хугацаанд жирэмсний хяналтад шинээр 1453 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдан эхний 3 сартайд 1439 буюу 99.0 хувь нь хяналтад орж, өмнөх оны мөн үеэс 0,3%-иар буурсан.Жирэмсний хяналтад 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдалт 94.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс 17.7 хувиар нэмэгдсэн бөгөөд жирэмсэн үеийн гурвалсан халдварын илрүүлэг шинжилгээнд хяналтад байгаа жирэмсэн эхчүүдийг 100% хамруулснаас БЗДХ-ын шинжилгээнд трихомониаз 33 буюу 2.3 хувь, тэмбүү 10 буюу 0.7 хувь, заг хүйтэн 1 буюу 0.07 хувь тус тус эерэг гарч төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдол бүртгэгдсэн байна. -Жирэмсний хяналтыг сайжруулах чиглэлээр салбар дундын хэлэлцүүлэг 1,дэмжлэгт хяналт 3,эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварын үнэлгээ1, чадавхжуулах сургалт 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор анхан болон лавлагаа шатлалын 98 эмч, эх баригч нарыг хамруулан чадавхжуулсан. -Анхан болон лавлагаа шатлалын 46 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг ЭХЭМҮТ,БОЭТ-ийн төрөх тасагт ажлын байранд сэлгэн ажиллуулж чадавхжуулсан. -Эхээс урагт дамжих халдвар дамжих эрсдлийг бууруулах чиглэлээр тайлант хугацаанд бүртгэгдсэн төрөлхийн тэмбүүгийн 2 тохиолдлыг ЭМС-ын 2019 оны А/614 дугаар тушаалын дагуу хэлэлцэж,шийдвэрийн хэрэгжилтийг хангах хүрээнд сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 16-49 насны түр оршин суугч, явуулын эмэгтэйчүүдийн судалгаанд улирал бүр тулгалт хийж,жирэмсний нэрийн хяналт, ЭМС-ын А/292 дугаар тушаалын дагуу жирэмсний хяналтын мэдээг сум,өрхийн эрүүл мэндийн төвийн эх баригч нараас авч, ЭМГ-аас сар бүр хяналт тавиж ажиллан, жирэмсэн эмэгтэйг хяналтад шилжүүлэхдээ гараас гарт зарчмын дагуу мэдээллийн урсгалыг сайжруулах арга хэмжээг авч ажилласан. Амурлин Тэнгис ТББ,Мишээл МНЦО, хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн клиникүүдтэй хамтран зорилтот бүлгийн 1496 эмэгтэйг үзлэг шинжилгээнд хамруулж, трихомониаз, тэмбүү, заг хүйтэн эерэг илэрсэн 25 тохиолдлын хавьтлын судалгааг гаргаж,хавьтлын хамт 100% эмчлэн эрүүлжүүлээд байна.Мөн эхо шинжилгээнд 711 охидыг хамруулж,192 өвчлөлийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлсэн.Жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэлд 139 эмэгтэйг хамруулж, 5 сургуулийн 439 охидод эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна.	50

29	2.3.2.Сэргийлж болох эх, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг зохион байгуулж, эх хүүхдийн эндэгдэлд судалгаа тогтмол хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллана. ^{2,5}		Эхийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд) 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1000 амьд төрөлтөд)	10.2	10.1	ЭМС-ын 2025 оны А/219 дугаар тушаалаар батлагдсан “Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний 2025-2028 төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Орхон аймагт хэрэгжүүлэх төлөвлөгөөнд салбар байгууллагуудаас өгсөн саналыг тусган батлуулж, хэрэгжилт 91,2%-тай, аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийг бууруулах 3 бүлэг, 13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан 90.2%-тай хэрэгжсэн байна. Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт, эмнэлзүйн удирдамж, тушаал зааврын хэрэгжилт, цаг үеийн болон хариу арга хэмжээ, зохицуулалтын талаар сум, өрхийн эмч нарт 9 удаа мэдээлэл, чиглэл өгч, эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд 4 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Тайлант хугацаанд төрсөн 1435 нярайд эрт үеийн нэн шаардлагатай тусламжийг 100 хувь үзүүлсэн. Түнхний үений эхо оношилгоонд 1435, сонсголын скринингт 392, нүдний угийн улаан рефлексийг 1435, бодисын солилцооны скринингэд 1016 нярайд хамруулсан. Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6%-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар нэмэгдсэн. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд орон нутгийн 10 сая төгрөгийн санхүүжилтээр 535 эмэгтэйд төмрийн бэлдмэл олгож, жирэмсэн, хөхүүл үеийн цус багадалтыг эмчлэн гарах эрсдэл хүндрэлийг бууруулсан байна. ЭМС-ын 2022 оны А/263 дугаар тушаалын дагуу 2025 онд бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13, амьгүй төрөлт 9, гэрийн төрөлт 3, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдлыг судлан магадлан хэлэлцэх зөвлөлөөр 3 удаа хэлэлцүүлж, гарсан 11 шийдвэрийн хэрэгжилт 85.3%, зөвлөмжийн хэрэгжилт 86,5%-тай байгаа бөгөөд хариу арга хэмжээний хүрээнд доорхи ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: 2025 онд бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 13, амьгүй төрөлт 9, гэрийн төрөлт 3, эхийн ноцтой хүндрэлийн 2 тохиолдолд дэлгэрэнгүй судалгааг хийж, эмнэлгийн тусламж үйлчилгээний хожимдол үүсэхэд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлийг тооцон дүгнэлт, зөвлөмж боловсруулан ЭМБ-уудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавиж ажилласан. Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв нь 16-49 насны түр оршин суугч, явуулын эмэгтэйчүүдийн судалгаанд улирал бүр тулгалт хийж, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх баригч нараас жирэмсний нэрийн хяналт, ЭМС-ын А/292 дугаар тушаалын дагуу жирэмсний хяналтын мэдээг сар бүр авч, ЭМГ-аас хяналт тавин мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн. Жирэмсэн, эрт үеийн нярайн эндэгдлийг бууруулах чиглэлээр зохион байгуулсан салбар дундын 2 удаагийн хэлэлцүүлэг 71 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. ЭМЯ, ЭХЭМҮТ-өөс ЭМС-ын 2025 оны А/419, А/420 дугаар тушаалын хүрээнд “Эхийн болон перинатал эндэгдлийн тандалт, хариу арга хэмжээ” сургалтыг Орхон аймагт 3 өдөр зохион байгуулан БОЭТ-ийн эх	100
----	---	--	---	------	------	---	-----

						барих, эмэгтэйчүүдийн эмч, нярайн тасгийн эмч, эрчимт эмчилгээний эмч, мэргэжилтэн 15 хүн, АШУҮИС-ын Дархан-Уул салбарын Эмнэлзүйн тэнхимтэй хамтран эх барихын яаралтай тусламж чиглэлээр 1 өдрийн онол, дадлага хосолсон сургалтад БОЭТ-ийн төрөх тасаг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн 30 эх баригчийг хамруулан чадавхжуулсан. ЭХЭМҮТ, ЭМХТ, ЭМГ-аас эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чиглэлээр зохион байгуулсан 10 удаагийн цахим, танхимын 16 удаагийн сургалтад давхардсан тоогоор нийт 530 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан байна. Тайлант хугацаанд өсвөр насны хүүхдийн нөхөн үржихүйн боловсролын чиглэлээр 2, ургийн оношилгоо, ховор тохиолдлоор 2, төрөх, төрсний дараах тусламж үйлчилгээний чиглэлээр 2, эмэгтэйчүүдийн чиглэлээр 2 практик ач холбогдол бүхий 8 судалгаа хийгдэж, аймгийн эмч нарын эрдэм шинжилгээний хурал, өрхийн анагаах ухааны холбооны эрдэм шинжилгээний хурлуудад тэргүүн байр эзэлж, олон улсын хуралд ханан илтгэлийн хэлбэрээр судалгааны үр дүнг амжилттай танилцуулсан байна. Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр орон нутгийн 5,0 сая төгрөгийн санхүүжилтээр иргэд, олон нийтэд чиглэсэн “Амьдралын алтан 1000 хоног” сургалт, нөлөөллийг ажлыг “Тогтвортой хөгжил ирээдүй” ТББ-тай хамтран 4 удаа зохион байгуулж, нийт 354 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. ЭМГ-ын цахим хуудсаар эх хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр 7 постер, 3 видео шторк, нийт 10 мэдээллийг байршуулж, давхардсан тоогоор 18379 хүн үзсэн байна. Тайлант хугацаанд эхийн эндэгдэл бүртгэгдээгүй, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 13 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.3 ногдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдлоор буюу 3.0 промиллоор буурсан ба аймгийн дундаж (16.5) болон улсын дундаж (16.8)-аас бага байна.	
30	2.3.3. Суурь өвчтэй хүүхдүүдийг улирлын чанартай гэр сувилалд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлнэ. ²	ОНТ 30.0 сая	Суурь өвчтэй хүүхдийн эрүүлжсэн хувь	89%	90%	Тайлант хугацаанд зорилтот бүлгийн суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар, ус, агаар, эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. -Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 5 хүртэл насны суурь өвчтэй хүүхдийн судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн 272 хүүхдийн судалгааг гаргасан байна. -Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарлагдаж, сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж хүүхдийн сувилалд хийсэн үнэлгээний дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн. Тус сонгон шалгаруулалтад Бүжинлхам хүүхдийн чийрэгжүүлэх гэр сувилалд 0-5	100

						хүртэх насны суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар,ус,агаараар чийрэгжүүлэн зорилтот бүлгийн хүүхдийн 92,0% нь эрүүлжсэн байна. Жин,өсөлтийн 1-р зэргийн хоцрогдолтой 65 хүүхэд, 2-р зэргийн 34 хүүхэд, 3-р зэргийн 4 хүүхдийн жингийн үзүүлэлт 200-500 гр нэмэгдэж, 82,4 хувь нь жин, өсөлтийн үзүүлэлт дээшилсэн үр дүнтэй байна. -Тайлант хугацаанд тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 39661 хүүхэд хамрагдсанаас 0.14 хувь нь туранхай, 0.15 хувь нь тураалтай, 0.28 хувь нь өсөлтийн хоцрогдолтой байна.	
31	2.3.4. Хүүхэд, өсвөр үе болон нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. ⁴		Өсвөр үе болон нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн үзлэгт хамруулсан хувь	22%	22,5%	Тайлант хугацаанд өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 4 албан тоот, 3 мэдээлэл, 4 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 84,6%-тай байна. -ТТӨ-ний дэгдэлтийн үеийн хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хариу арга хэмжээний хүрээнд БОЭТөвд нэмэлтээр 150 хүртэлх орыг дэлгэн, хүүхдийн хүлээн авахад өрхийн 39 эмчийг хуваарийн дагуу нэмэлтээр сэлгэн ажиллуулж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 10 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 329 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулсан. -БГ-тай хамтран өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, анхаарах асуудлуудын талаар 2 удаагийн сургалтыг ЕБ-ын 24 сургуулийн дунд ангийн 70 багшид зохион байгуулж тэдний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. -Сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагч хамруулахаас 2554 буюу 99,1 хувь нь хамрагдаж, 1773 буюу 68,8%-д өвчлөл илэрсэнийг хяналтад авч, 720 буюу 28,1%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн. -Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд эрүүл мэндийн олон талт боловсрол олгох сургалтыг 1-12 дугаар ангийн 150 хүүхдэд зохион байгуулж, хүүхдийн аюулгүй тусламжийг дэмжих, тусламж үйлчилгээ авах үед аюулгүй байдлыг хангах постер мэдээлэл зөвлөмжийг 17 сургуулийн 586 сурган хүмүүжүүлэгч, 2909 сурагч, эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн. -Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ,ХГБХГ,ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсьё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг,	100

						ойлголтыг нэмэгдүүлж ажилласан. -Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгуулж, 552 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан. -Өсвөр үеийнхэнд “Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн” чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх сургалтыг зохион байгуулж, 21 сургуулийн идэвхтэн 25 хүүхдийг хамруулсан. -“Өсвөр насны охид хөвгүүдийн нөхөн үржихүйн онцлог, эрүүл ахуй, хорт зуршил ба эрүүл мэнд сэдвүүдийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв харьяа ерөнхий боловсролын 13 сургуулийн 7-12 дугаар ангийн 3369 хүүхдэд 19 удаагийн сургалтаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгож, 2322 гарын авлага түгээж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. ЭМГ-ын цахим хуудсаар 11 постер, 1 рийл нийт 12 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 22787 иргэнд түгээсэн. -Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн насны 24.027 эмэгтэй байгаа ба тайлант хугацаанд гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэлд 16,297 буюу 67.8%-д хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1,2%-иар нэмэгдсэн байна.Нөхөн үржихүйн насны 25,030 эмэгтэйчүүдийн 14,626 буюу 58.4%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,1%-иар нэмэгдсэн байна.	
Зорилт 4. Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж үйлчилгээг цогц, нэгдмэл байдлаар хөгжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх							
32	2.4.1.Уламжлалт анагаах ухаан,сэргээн засах тусламж, үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, тусламж үйлчилгээ шаардлагатай иргэдийг сэргээн засах тусламж үйлчилгээнд хамруулна. ^{2,4}	2,0 сая ОНТ	Үйл ажиллагааны тайлан, хэрэгжилтийн хувь	90.0	90.5	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг аймгийн хэмжээнд төр болон хувийн хэвшлийн нийт 26 эрүүл мэндийн байгууллага үзүүлж байгаа бөгөөд тусламж үйлчилгээний хүртээмжийг үнэлж үзэхэд сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд 12587 буюу 14,1%,БООТ 1212 буюу 1,3%, Эрдэнэт сувиллын цогцолбор 4978 буюу 7,3%, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд 61490 буюу 68,8%-д уламжлалт анагаах ухааны тусламжийг үзүүлсэн байна. -Тайлант хугацаанд ЭМБ-ууд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг 89267 иргэнд, сэргээн засах эмчилгээг 45321 иргэнд үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,2%-иар нэмэгдсэн байна. -Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/749 дүгээр тушаалын дагуу сэргээн засах тусламж үйлчилгээг 2 зорилтын 12 заалтаар хийх төлөвлөгөө гарган, хэрэгжилт 98 %-тай байна. -“МУАУ-ны хувь хүний өвөрмөц чанарыг хэрхэн тодорхойлох вэ, идээ ундаа явдал мөрийн аргаар өвчнөөс сэргийлэх арга”, “Нурууны өвдөлт үүсэхэд нөлөөлж буй буруу дадал хэвшлүүд” “Уламжлалт анагаах ухааны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах эмнэл зүйн сургалт” “Косметик зүү эмчилгээ хийх ур чадвар эзэмшүүлэх” сэдэвт 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 189 эмч,эмнэлгийн	100

						мэргэжилтэн хамрагдан мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлсэн байна. -Аймгийн хэмжээнд тусламж үйлчилгээ шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 3897 иргэнд 19485 удаагийн урт болон богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. -“Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн болон ахмад настнуудыг үзлэг, оношилгоо, сэргээн засах дасгал хөдөлгөөн эмчилгээнд хамруулах”, “Ахмадын сэргээн засах засах тусламж үйлчилгээг дэмжих” удирдамжтай ажлыг зохион байгуулж сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлсэнээр үйл ажиллагааны хэргэжилт 98%-тай байна. -АШУҮИС, АУС-ийн Сэргээн засах анагаах ухааны тэнхим, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ийн Эрдэнэт сувиалалтай хамтран “Мэдрэл яс, булчингийн хэт авиан оношилгоо” сургалтад 12 Эрүүл мэндийн байгууллагын 25 эмч, мэргэжилтэн хамрагдаж, хэт авиан шинжилгээг сэргээн засах оношилгоо, эмчилгээнд хэрэглэх арга, булчин чангарлын менежмент, ботулин токсин А тарилгын талаар мэдлэг олгож чадавхжуулсан. -Тэжээхүй ухаан ТББ-тай хамтран зохион байгуулсан “АЛТАН ТУН-2025” өдөрлөгт 200 гаруй иргэн хамрагдаж, УАУ-ны эмчийн үзлэгт 120, нурууны үзлэгт 85, 3 наснаас дээш хүүхдийн хөлийн нумны үзлэгт 15 иргэн хамрагдан өөрийн эрүүл мэндийн байдлаа үнэлүүлж, мэргэжлийн зөвлөгөө авлаа. Мөн 22 эрүүл мэндийн байгууллага оролцож эмнэлгийн танилцуулга, бүтээгдэхүүн үйлчилгээ сурталчилснаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа сайжирч, эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх иргэдийн мэдлэг, хандлагыг нэмэгдүүлсэн байна.	
33	2.4.2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. ⁴		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95%	97%	Эрүүл мэндийн 160 гаруй байгууллагад 8 алба, 51 тасагт 512 сувилагч, 300 тусгай мэргэжилтэн, 10000 хүн амд сувилагч 49 ноогдож, эмч сувилагчийн харьцаа 1:1,8 ажиллаж байна. Мэргэжлийн зэрэгтэй сувилагч 38.3% буюу өмнөх оноос 1.5%-иар нэмэгдсэн байна. -Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр 4 зорилтын хүрээнд 12 ажил төлөвлөж, гүйцэтгэл 100%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 5%-иар нэмэгдсэн байна. Дэмжлэгт хяналтыг 4 удаа хийж, арга зүйн зөвлөгөө зөвлөмж өгч, хэрэгжилт 82%-тай байна. Сувилахуйн тусламж үйлчилгээний тайланг 2 удаа, 45 тасаг нэгжийн ахлах сувилагч нарын дунд хэлэлцүүлж, үр дүнг тооцож ажилласан. -Тайлант хугацаанд давхардсан тоогоор 427803 хүнд сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 40%-иар нэмэгдсэн. -Шинэ сувилагчийг дадлагажуулах сургалтад 9, гадаад улсад богино хугацааны сургалтад 1, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтыг 2018 оноос эхлүүлж, 2025 онд “Эрчимт эмчилгээний сувилахуй” 3, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр 13 сувилагч суралцан, өмнөх оноос 40%-иар нэмэгдсэн. -Орон нутгаас БОЭТ-ийн сувилахуйн тусламж үйлчилгээний	100

					хүртээмжийг нэмэгдүүлэхэд 12 туслах сувилагчийн цалин 78.0 сая төгрөгийг шийдвэрлэсэн байна. -Сувилахуйн тусламж үйлчилгээтэй холбоотой бүртгэгдсэн 24 тохиолдлоос 1а–16, 1б–5, 2-3 бүртгэгдэж доорхи хариу хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Аймгийн хэмжээнд “Тарилгын аюулгүй байдлыг хангах нь” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, 93 сувилагч хамрагдан, аюулгүй ажиллагааны стандарт мөрдөлт сайжирсан.Монгол–Японы эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан эмнэлзүйн сургалтад 577 буюу нийт сувилагчийн 71%-ийг хамруулан ур чадварыг нэмэгдүүлсэн. -Байгууллагын түвшинд хийсэн дэмжлэгт хяналт 2 удаа зохион байгуулж, хэрэгжилт 82% байна. Ахлах сувилагчдын дунд тайлан хэлэлцүүлж, санал туршлага солилцож чадавхжуулсан байна. -Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр Монголын оюуны өмчийн газраас 2021 онд №13020 патент авч “Зөгийн лавтай парафин ба дан парафины эмчилгээ”-г 2025 оны 1 сараас эхлэн орон нутагт амжилттай нэвтрүүлж, нийт 253 иргэнд үйлчилсэн байна. -Сувилахуйн сургуультай хамтран “Судалгааны арга зүйд суралцах нь” сургалтад 141 сувилагч хамруулж, эрдэм шинжилгээний бага хуралд 65 судлаачийн 15,“Олон улсын эх баригчдын судалгааны эмхтгэл ном”-д 1, улсад 14 илтгэл амжилттай хэлэлцүүлсэн.Төрөлжсөн мэргэшлийн сургалтад 13, гадаад улсад 1 сувилагч богино хугацааны сургалтад хамрагдан ур чадвараа нэмэгдүүлсэн. -“Өвчнөөс урьдчилан сэргийлэх” сэдвийн хүрээнд Цахим хичээл 60 бэлтгэн, хандалт 46479, 87 сэдвийн хүрээнд 67881 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгосон байна.		
34	2.4.3. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. ⁴		Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	116	200	Аймгийн хэмжээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвд 4-р бүлэг 2044, 5-р бүлэг 183 буюу нийт 2227 иргэн идэвхтэй хяналтад хянагдаж, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг гэрээр авч байна. -Сум, өрхийн эрүүл мэндийн төв нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, улмажлалт, сэргээн засах, хөнгөвчлөхийн эмч,сувилагч нарын олон мэргэжлийн баг бүрдүүлэн хөнгөвчлөх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна.Гэрийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд нийт 523 иргэн хамрагдаж, уламжлалт эмчилгээ, сэтгэл зүйн эмчилгээтэй хавсран үзүүлснээр эмчилгээний үр дүн 0.9%-иар нэмэгдсэн. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдар, хөнгөвчлөхийн тасагт 15, хими эмчилгээний 4, нийт 19 ортой, их эмч 3, ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 4, хими эмчилгээний сувилагч 2, дүн бүртгэгч сувилагч 1, туслах сувилагч 4 гэсэн орон тоогоор хөнгөвчлөх тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлж байна. -Тайлант хугацаанд 558 иргэнийг хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамруулсан. Үүнээс: хорт хавдар 458, хоргүй хавдар 100 иргэн байна. Мөн хими эмчилгээнд 657 иргэн үйлчлүүлсэн. -Хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хэрэгжиж буй тушаал шийдвэр,	100

						стандартын хэрэгжилтэд дэмжлэгт хяналт 2 удаа хийж, зөвлөмж хүргүүлэн хэрэгжилт 81%-тай байна. -“Хавдар өвчний тухай ерөнхий ойлголт, Хавдрын хяналт бүртгэл, оношилгоо эмчилгээ”, “Хавдрын өвчний үеийн төрөлжсөн сувилахуй, асаргаа сувилгаа”, “Сувилгааны түүх хөтлөхөд анхаарах нь” сэдвээр онол, дадлага хосолсон эмнэл зүйн чадавхжуулах 4 удаагийн сургалт зохион байгуулж, 43 эмч, сувилагч хамруулан ур чадварыг нэмэгдүүлсэн. -Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран өрхийн эрүүл мэндийн төвийн 3 сувилагчийг дадлага, онол хосолсон “Хавдрын төрөлжсөн сувилахуйн тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтад хамруулж чадавхжуулсан. -Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 80 удаа зохион байгуулж, эрүүл мэндийн боловсролыг 582 асран хамгаалагчид олгосон.	
35	2.4.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг сайжруулан, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор шат, баррель үсэг, зам, дуут санамжийн нэвтрүүлэлтэд хяналт тавьж ажиллана. ⁵	535,2 мянга ОНТ	Дэд бүтэц, хүр тээмжээр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын хувь	87%	90%	Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” аяныг зохион байгуулж нийт 24 эрүүл мэндийн байгууллага оролцсон: Тус аяны хүрээнд: -32 эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд “Дохионы хэлний дунд шатны сургалт”-д хамрагдаж, ур чадвараа нэмэгдүүлсэн байна. -“Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны үндсэн шаардлага” MNS6055:2009 “Явган хүний зам, талбай төлөвлөлт техникийн шаардлага” MNS6808:52019 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд өөрийн эрүүл мэндийн байгууллагуудад дотоод болон гадаад үнэлгээг хийж, явган хүний налуу зам, замын бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүний авто машины зогсоол, зогсоолын тэмдэглэгээ зэргийг шинээр хийж, ээлтэй орчныг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээллийн самбар, шатны зөөлөвч, таяг, харааны шил, дуугүй хөтөч, ханын бариул, дуслын хонх, дуут дохио зэргийг нэмэгдүүлсэн байна. -АЗДТГ-ын 535.200 төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн бүх тасаг нэгжийн ариун цэврийн өрөөнүүдийг эрүүл ахуйн болон барилгын стандартын шаардлагад нийцүүлэн засварлаж, гадна орчныг сайжруулах хүрээнд явган хүний зам, авто зогсоол зэргийг шинэчлэн сайжруулсан. -Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудын 90 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, хүртээмжтэй орчныг бүрдүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,0%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.	100
36	2.4.5. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай		Цогц үзлэгт хамрагдс	2100	2284	Тайлант хугацаанд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдэд бага насны хүүхдийн хөгжлийн цогц үзлэгийг 2284 хүүхдэд хийж 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээсэн.	100

	хүүхдийн эрүүл мэндийн хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллана. ⁵		ан 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн тоо			Аймгийн Засаг даргын 2025 оны А/347 дугаар захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тайлант хугацаанд 21 удаа хуралдаж нийт 391 хүүхдэд комиссын хурлаар орсон байна. Үүнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 168, боловсролд 55, сунгалт 89, цуцлагдсан 38, шинээр орсон 69, буцаагдсан 28, бусад 112 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна. -Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн цахим сургалтад бүх гишүүд хамрагдсан байна. -АШУҮИС-ийн Сэргээн засах анагаах ухааны тэнхимтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих сургалт зохион байгуулж, хүүхдийн хөгжлийн онцлог, аутизмын хүрээний эмгэг, хөдөлмөр засал, зөв байрлал, хооллолт, булчин чангарлын менежментийн талаар 35 эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлэл өгсөн. -Эрдэнэт сувиллын цогцолбор "Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл" өдөрлөг зохион байгуулж, 15 хүүхдэд сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлэн, эцэг эхчүүдэд гэрийн нөхцөлд хийх аргууд, СӨЭМТ-үүдийн эмч нарт анхан шатны түвшний сэргээн засалт хөгжүүлэх зөвлөмж өгсөн. -2025 оноос АЗДТГ-тай хамтран "Солонгон ертөнц" сэргээн засах клиник дэмжлэгт төсөл хэрэгжиж эхэлсэн. 17 сая төгрөгийн санхүүжилттэй, СӨБ-ын 27, 7 дугаар цэцэрлэгийн тархины саа, саажилт, эпилепси оноштой 15 хүүхдэд 3 сарын хугацаанд урт хугацааны сэргээн засах үйлчилгээ үзүүлсэн. БОЭТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасагт 32 хүүхэд нийт 160 удаагийн богино хугацааны сэргээн засах үйлчилгээ авч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5% нэмэгдсэн байна.	
Зорилт 5. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн чадавхыг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээний тасралтгүй шуурхай байдлыг ханган хамтран ажиллах							
37	2.5.1.Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, оношилгооны чадавхи, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлнэ.		Оношилг ооны чадавх	90%	90,5%	Эрүүл мэндийн газраас Хувийн хэвшлийн ор бүхий 11 клиник, 1 нэгдсэн эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. Уг гэрээнд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, мэдээллийн шуурхай байдлыг хангах, нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулах 5 заалтыг нэмэлтээр тусган, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, хэрэгжилт 92,5%-тай үнэлэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,0%-иар нэмэгдсэн байна. Гэрээний хэрэгжилтийг газар дээр нь үнэлэхээр газрын даргын тойрон үзлэгийг 11 ор бүхий клиникт хийж, зөвлөмж өгч ажиллалаа. -Хувийн хэвшлийн ор бүхий 11 клиник, 1 нэгдсэн эмнэлгийн 83,5% нь стандарт хангасан эмнэлгийн зориулалтын барилга	100

					байгууламжтай,мэргэшсэн хүний нөөцийн хангалт 85,0%-тай, аймгийн нийт хэвтэх орны 48,7% буюу 459 оронд тайлант хугацаанд 13608 хүн мэдрэл, уламжлалт, сэргээн засах, чих хамар хоолой, дотоод шүүрэл,зүрх судас,дотрын чиглэлээр хэвтэн эмчлүүлж, тусламж үйлчилгээний ачааллыг бууруулан 87874 хүнийг лабораторийн шинжилгээнд хамруулж, дүрс оношилгоо, хиймэл оюун ухааны оношилгоог нэвтрүүлэн оношилгооны чадавхи 91,2%-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,7%-иар нэмэгдсэн байна. Хувийн хэвшлийн Баянөндөрмөд нэгдсэн эмнэлэгт үтрээний шүүрлийг 17 үзүүлэлтээр GMD 600 бүрэн автомат үтрээний шүүрлийн шинжилгээг 2025 онд 1500 хүнд, AI(хиймэл оюун ухаан) оношилгооны аппарат, рентген оношилгоонд уушгины өвчнийг оношлох AI технологи,хүний хөхөнцөр вируст өндөр эрсдэлтэй 16,18,45,53 типүүдийг илрүүлэх шинжилгээг 1100 хүнд,ходоодны салст хуулах хагалгааг нэвтрүүлэн 12 хүнд хийсэн байна. Ор бүхий 2 клиник 24 цагийн зүрхний холтер, 24 цаг артерийн даралт хэмжигчийг 2-3 ээлжээр ажиллуулж байна. -Дотрын эмнэлгүүдэд тархины судасны доплерийг шинээр авч 184 хүнд оношилгоо хийсэн байна. -Зүрхний дутагдал,шигдээс илрүүлэх шинжилгээг хийж эхэлсэн бөгөөд урьдчилан сэргийлэх үзлэгийг 5 төрлийн багцаар нэмэгдүүлсэн байна. Үүнд:зүрх, бөөр, үе мөч, эрсдэс үзэх, элэг цөсний багцад 550 хүнийг хамруулсан. -Чих хамар хоолойн клиник сонсгол бичлэгийн аудиометр, infrared шарлагын аппаратуудыг тусламж үйлчилгээнд нэмсэн. -Үе, судасны ЭХО нэвтэрч орон нутгаас 300 гаруй хүнд тусламж үзүүлсэн байна -Яаралтай тусламжийн эмнэлзүйн өрөөг шинээр сургалтын хэрэгслийн хамт тохижуулж, эмч,эмнэлгийн мэргэжилтнүүдийг гардан үйлдлийн дадлага сургуулилтад хамруулан чадавхжуулсан.		
38	2.5.2.Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлнэ. ³		Гэрээт үйлчилгэ эний тоо	2	2	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг бүх талаар дэмжиж, зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх хүрээнд : - Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/20 тушаалаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй хувийн эмнэлгүүдийн өдрийн эмчилгээний орыг нийт 218-аар баталж, 2025 онд 9562 иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэн хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний ачааллыг бууруулсан байна. -Хувийн хэвшлийн төрөлжсөн эмнэлэг 1, хүүхдийн 2 клиник томуу томуу төст өвчний үеийн тусламж үйлчилгээний ачаалал, хүлээгдлийг бууруулах чиглэлээр уртасгасан цагийн зохицуулалт хийж хамтран ажилласан. -ЭМГ,сум,өрхийн эрүүл мэндийн 8 төв, шүдний 13 клиниктэй гэрээ байгуулан сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх шүдний илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2433 хүүхдээс 94,4% -ийг хамруулсан. Шүдний мэргэжилтний холбоо, Шүдний 5 эмнэлэгтэй хамтран малчдын үзлэгт	100

						152 хүн, цэргийн насны 178 залуучууд, цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1500 нийт 1678 хүнд явуулаар амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, шүд угаах аргачлалыг таниулах сургалт нөлөөллийг ажлыг зохион байгуулсан. -Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулахад 6 хувийн хэвшлийн нөхөн үржихүйн клиниктэй гэрээ байгуулан 16-49 насны 1662 эмэгтэйг үзлэгт хамруулан лавлагаа шатлалд 152 эмэгтэйг илгээсэн байна. -“Зорилтот бүлгийн хүн амд хүргэх тусламж үйлчилгээг сайжруулая” төслийн хүрээнд иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг явуулаар хүргэхэд хувийн хэвшлийн 6 байгууллагатай хамтран ажилласан. -Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарлагдаж, сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж хүүхдийн сувилалд хийсэн үнэлгээний дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.Тус сонгон шалгаруулалтад Бүжинлхам хүүхдийн чийрэгжүүлэх гэр сувилалд 0-5 хүртэх насны суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар,ус,агаараар чийрэгжүүлсэн байна.	
39	2.5.3. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагуудад хяналт хийнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	100%	100%	Тусгай зөвшөөрөл олгох хурлыг нийт 10 удаа хуралдуулж 49 байгууллагын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд сунгалт 7, эрх сэргээлгэсэн 2, түдгэлзүүлсэн 7, хүчингүй болгосон 8, хаягийн шилжилт 5, төсөл 12, шинээр 11 байгууллагад зөвшөөрөл олгосон. -Ажлын байранд 3-5 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй баг батлагдсан удирдамжийн дагуу 11 удаагийн үнэлгээг хийж, тусгай зөвшөөрлийн хурлаар дүгнэлтийг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. -Тусгай зөвшөөрөлийн хүрээнд нийт 72 эмийн санд мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналт, 13 эрсдэл өндөртэй эмийн санд тусгай зөвшөөрлийн хүрээнд хяналт үнэлгээг хийж, эм, биобэлдмэлийн улсын байцаагчид 5 зөрчил шалгуулахаар шилжүүлж, 2 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. -Дээрх эмийн сангуудад 2 удаагийн сургалт , мэдээллийг 70 эмч зүйч, эм найруулагч нарт зохион байгуулсан. Цахим хөгжлийн яамнаас ирүүлсэн мэдээллийн дагуу ЗДТГ-ын ХЭЗХ-т тусгай зөвшөөрлийн талаарх 3 чиглэлийн мэдээлллийг гарган хүргүүлж,мэдээллийн нэгдсэн цахим програм(license)-ын цахим сургалтыг зохион байгуулж, ЭМЯ-нд тусгай зөвшөөрөлтэй 167 байгууллагын мэдээллийг хүргүүлэв. -ЭМЯ-нд тусгай зөвшөөрөл олгох, Зөвшөөрлийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбоотой 11 саналыг нэгтгэж хугацаанд нь хүргүүлсэн. -Тусгай зөвшөөрлийн хүрээнд хаягийн шилжилттэй холбоотой 2 иргэний гомдлыг эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчийн хамт ажлын байранд 4 удаагийн хяналтыг хийж шийдвэрлэсэн.	100%

Зорилт 6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэлзүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж,

Зорилт 6. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, эмнэлзүй, эм зүйн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, нянгийн тэсвэржилтийг судалж,

антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн хяналтыг сайжруулна. ^{1,2}							
40	2.6.1. Эм зүйн салбарын ил тод хариуцлагатай байдлын бэхжүүлж, стандартын хэрэгжилтийг хангуулан тогтвортой үйл ажиллагааг дэмжинэ. ^{2,3}		Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангуудын стандартын хэрэгжилт	95%	95.2%	Аймгийн хэмжээнд нийтийн үйлчилгээтэй 72 эмийн сан, 10 эм ханган нийлүүлэх байгууллага иргэдэд үйлчлэн ажиллаж байгаагаас 4 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон цуцалж, 1 эмийн сан шинээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна. -Эм ханган нийлүүлэх байгууллагуудаас эмийн сан бөөний үнээр эм авч иргэдэд борлуулдаг бөгөөд ЭХНБ-ын үнэ өмнөх онтой харьцуулахад 10-30% нэмэгдсэн бөгөөд эмийн сангууд ЭХНБ-ын үнэ дээр дундажаар 18-30% нэмж, иргэдэд жижиглэнгийн үнээр борлуулахдаа дундажаар 20-45% нэмж борлуулж байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад ЭХНБ-ын үнэ дээр 5-10% нэмж борлуулж байгаа бол жижиглэнгийн үнээр борлуулж буй үнэ нь 10-25%-аар нэмэгдсэн байна. -Эмийн хадгалалт, түгээлтэд тавих нийтлэг шаардлага MNS5530:2014 болон эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандартын дагуу эм ханган нийлүүлэх байгууллага болон эмийн сангуудын стандартын хэрэгжилт дунджаар 96,8% байгаа нь өнгөрсөн онтой харьцуулахад 0,6% нэмэгдсэн байна. Үүнд: -“Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS5260:2015 стандарт”-аар хяналт хийхэд 97,8%-тай үнэлгээтэй гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,9%-аар сайжирсан байна. -Эм ханган нийлүүлэх байгууллагын стандартын шаардлага 95,8%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад стандартын хэрэгжилт 0,3%-аар сайжирсан байна.	100
41	2.6.2. Эмнэл зүйн эм зүйн тусламжийг эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалд тохируулан нэвтрүүлнэ. ^{2,4}		Хэрэгжилтийн хувь	42.0	55.0%	Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 134 эм зүйч, 120 эм найруулагч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм зүйч 1.5 хувь, эм найруулагч 3.1 хувиар тус тус нэмэгдсэн байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 6 клиник эм зүйч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад 11 клиник эм зүйч ажиллаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдөөгүй байна. Эмнэл зүйн эм зүйн тусламж үйлчилгээнд хяналт хийхэд нийт өвчтөний 49.8-59.5 хувьд тарилгыг хийж, 40.5-50.2 хувьд уухаар эмийг өгсөн байгаа нь өмнөх онтой харьцуулахад эмийг тарилгын хэлбэрээр хэрэглэх явдал 1.6 хувиар буурч, ууж хэрэглэх эмийн хувь 7.0-10.2 хувиар нэмэгдсэн, зонхилон тохиолдох эмгэгийн оношилгоо, эмчилгээний удирдамжийн хэрэгжилт 88.1 хувь болж 0.9 хувиар нэмэгдсэн, эмийн зохистой хэрэглээ алдагдал өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувиар буурсан байна. Эмнэл зүйн тусламж үйлчилгээний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 85.6 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 3,1%-аар нэмэгдсэн байна.	100
42	2.6.3. Нянгийн тэсвэржилтийг судалж,		Хяналтын дүн,	1	1	Нийтийн үйлчилгээтэй эмийн сангуудын эрхлэгч нарт нийт 61 хүнд эм зүйн мөрдөгдөж буй хууль тогтоомж, жор бичилтийн стандарт, эмийн	100

	антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, антибиотекийг жоргүй олгох үйл ажиллагааг таслан зогсоох, энэ чиглэлээр байнгын хяналт тавина.		хийгдсэн судалгааны тоо			санд тавих стандарт, зөрчлийн арга хэмжээний талаар мэдээлэл хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажилласан. Эрүүл мэндийн салбарын нээлттэй хаалганы 2 удаагийн өдөрлөгт эмийн зохистой хэрэглээний талаар сурталчилгааг 850 гаруй хүнд мэдээлэл өгч, брошур тараан мэдээлэл хүргэсэн. -Эмийн сангуудад жорын маягт, жор бичилтийн MNS5376:2016 стандартын мэдээллийг 74 эмийн санд хүргүүлсэн. Нийт эмийн сангуудад Анзаар#2 аяны хүрээнд Жор бичилт, жорын маягт MNS5376:2016 стандартын хэрэгжилтэд хяналт хийхэд 89,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2%-аар сайжирсан байна. -Аймгийн хэмжээнд Аксис программ ашиглаж эмийн нэр, тун хэмжээ, хэрэглэх аргыг бичиж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцон ажилласан. Ингэснээр Аксис программд шинжилгээ хийлгэсэн болон мэдрэг чанар заавал оруулах тохиргоотой болсноор нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах боломжийг бүрдүүлсэн. -hdc.gov.mn цахим хаягт Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээтэй 2,830 эмийн сангийн хаяг байршлын мэдээлэл, зайлшгүй шаардлагатай эмийн 30 бүлгийн 120 нэр төрлийн 480 нэрийн эмийн үнэ эмийн сангуудад худалдаалж буй үнийн мэдээллийг ил тод байршуулсан байна. 2025 онд антибиотик мэдрэг шинжилгээний хариунд анализ хийж үзэхэд макролидын бүлгийн антибиотикт 85-100% мэдрэг, цифалоспорины бүлгийн антибиотикт 45-55% мэдрэг гарсан нь макролидын бүлгийн антибиотикууд нь эмчилгээнд илүү үр дүнтэй байгаа мэдээллээр ЭМБ-уудын эмч нарыг хангаж ажилласан.	
43	2.6.4.Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналтыг сайжруулна. ²		Хяналтын дүн, хэрэгжилтийн хувь	97,3%	97,5%	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилдэг 12 эмийн сан, 2 эм ханган нийлүүлэх байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд эмийн сангуудаар 1 удаагийн хяналт хийж, хяналтаар хэрэгжилт дунджаар 97,8%-тай гарсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,3-иар нэмэгдсэн байна. -Аймгийн Цагдаагийн газрын даргын удирдамжтайгаар Цагдаагийн газар, Тагнуулын газар, Эрүүл мэндийн газрын хамтарсан нийт 7 хүний бүрэлдэхүүнтэй 3 баг 4 хоногийн хугацаанд нийт 72 эмийн сангаар үзлэг зохион байгуулсан. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмээр үйлчилдэг эмийн сангуудаас гадна мансуурах зорилгоор хэрэглэж болзошгүй 4 нэрийн эм /лидокайн, габапентин, прегабалин, вүүдс/ орлого зарлага, зарцуулалтад үзлэг хийсэн. Тус үзлэгээр нийт 26 эмийн санд зөвлөмж өгч, ЭМГ-ын даргын 01 тоот албан даалгаврыг эмийн сангуудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. -Тайлант хугацаанд мансууруулах эмийн жорыг 3 байгууллагад 657ш, сэтгэцэд нөлөөт эмийн жорыг 12 байгууллагуудад 4,085 ширхэгийг тус тус шифрлэж олгон хяналт тавин ажиллаж байна.	70

44	2.6.5.“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо,судалгааг гарган Эм,эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ. ⁵		Хэрэгжилтийн хувь	-	100%	Худалдан авах ажиллагааг tender.gov.mn сайтаар ажил үйлчилгээ, барааг худалдан авч төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо,судалгааг гарган tender.go.mn –д тогтмол бүртгэж хэрэгжилт 100,0 %-тай байна. -Тус цахим сайтад тендерийн худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. -Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 70 багцад 3,265 тэрбум төгрөгийн төсөвтэй худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 4 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 66 багцад 27 компани шалгаран гэрээ байгуулж, сар тутам тогтмол, тасалдалгүй нийлүүлэн ажиллаж байна. -Тайлант хугацаанд 2,82/86,37%/ тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл бусад шаардлагатай барааг авч ажилласан. Ерөнхий гэрээгээр 18 компанитай 102 нэрийн эм, 4 нэрийн эмнэлгийн хэрэгслийг нийт төсөвт өртөг 1,235.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд жилийн эцсийн байдлаар 885,2 /71,6%/ сая төгрөгийн эм, 68,2 /5,5%/ сая төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл буюу нийт 953,4 /77,2%/ сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл авсан байна. -Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг төрийн өмчид шилжсэнээр худалдан авах ажиллагаа зохион байгуулж ажилласан. 2025 онд нээлттэй тендер шалгаруулалт 211 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн нээлттэй тендер зарласан бөгөөд ерөнхий гэрээгээр буюу цахим дэлгүүрээс нийт 103 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл авахаар батлагдсан бөгөөд нийт төсөв 325,4 сая.төгрөг байснаас эм 303,2сая.төгрөг, эмнэлгийн хэрэгсэлд 1,65 сая.төгрөг, нэг удаагийн хувийн хамгаалах хэрэгсэлд 20,5сая.төгрөг зарцуулсан байна. -Гэрээ байгуулсан нийт төсөвт өртөг 228,2сая.төгрөг /70,1%/ бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар 138,5 /60,7%/ сая.төгрөг эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл авч эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байна.	100
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. ^{1, 2,5}							
Зорилт 1. Эмнэлгийн мэргэжилтний нийгмийн асуудлыг дэмжих, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах.							
45	3.1.1.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. ^{2,4}	ОНТ 50.0 сая	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	96.5%	96.8%	Тайлант хугацаанд Орхон аймгийн эрүүл мэндийн салбарт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна.Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 96,9 %-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,9%-иар	100

						нэмэгдсэн байна. Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS5095:2017,Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа MNS6330:2017 стандартын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн хүний нөөцийн хангалт 91.4%, эмч сувилагчийн харьцаа 1:1,4 байна. Сум,өрхийн эрүүл мэндийн 9 төвд 181 хүн ажиллаж байгаагаас эмч 50, эмнэлгийн мэргэжилтэн 50 ажиллаж, хүний нөөцийн хангалт хүртээмж 100%-тай байна. <i>Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажилчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд:</i> Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд орон нутгийн 40,5 сая төгрөгийн санхүүжилтээр эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг урт болон богино хугацааны сургалтад хамруулсан байна. Солонгос улсын Бусаны Их сургуулийн эмнэлэгт зүрх судас, цээжний хөндийн мэс заслын чиглэлээр 2 эмч, “Эрүүл мэндийн аялал жуулчлалын экспо”-д 1 эмч, Киргизстан улсын Бишкек хотноо зохион байгуулагдсан “Хөнгөвчлөх эмчилгээний олон улсын удирдлагын сургалтад 1 эмч, АНУ-ын Харвардын сургалтын хөтөлбөрт 1 эмчийг тус тус оролцуулж, орон нутгаас 8 сая төгрөгний санхүүжилтийг олгож дэмжлэг үзүүлсэн байна. Төрөлжсөн болон мэргэшүүлэх сургалт,нийгэмлэгийн хуралд давтагдсан тоогоор 1956 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдаж ур чадвараа нэмэгдүүлсэн. -ЭМЯ-наас зохион байгуулсан Эрүүл мэндийн байгууллагуудын 5 төрлийн спортын тэмцээнд амжилттай оролцсон 2 мэргэжилтэнд тус бүр 150,0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Жаргалант сумын ЭМТ-ийн 2 их эмчийг орон сууцаар хангаж, орон сууцны урьдчилгаа 30%-ийг Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн жолоочид, олон жил ажилласан 1 ажилтанд 13,8 сая, Талын булаг эмнэлэг 2 ажилтандаа тус бүр 10 сая, Эрдэнэт Медикал 3 ажилтанд тус бүр 13 сая, Ачит” эмнэлэг 20.4 сая төгрөгийг байгууллагаас олгосон байна.Мөн ажилтны ар гэрийн гишүүдийн эрүүл мэнд болон хүүхдийн сургалтын төлбөр бусад урамшуулалд нийт 25,200,000 төгрөгний дэмжлэг үзүүлж, гадаад улсруу аялах эрхийн бичгээр Эрдэнэт “Медикал” эмнэлэг 3, Очир Увидас эмнэлэг 13 эмч, эмнэлгийн ажилтнуудыг тус тус шагнаж урамшуулсан байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт эрүүл мэндийн салбар байгууллагуудын 78,4% буюу 1639 эмч эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан, 13,7 сая төгрөгийн аминдэмжүүлэлтэд хамруулан дэмжлэг үзүүлсэн байна.	
46	3.1.2.Үр бүтээлтэй ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудад олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн		Шагнал урамшуулалд хамрагдсан	10,5%	10,5%	Үр бүтээлтэй ажилласан эрүүл мэндийн салбарын ажилтнуудыг Төрийн болон Эрүүл мэндийн яам, орон нутгийн шагналд 206, Монголын сувилагч нарын нийгэмлэгийн шагналд 27 хүнийг тодорхойлж, нийт 233 ажилтныг шагнаж урамшуулсан байна. Ингэснээр тайлант хугацаанд шагнал урамшуулалд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь 11,2%-	100

	ажиллана.		эмнэлгийн мэргэжил тний тоо			тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,7 %-иар нэмэгдсэн байна. Дэлхийн эмч болон олон улсын сувилагч нарын өдрийг тохиолдуулан “Эрдэнийн чагнуур-Шилдэг эмч”1, “Эрдэнийн дэнлүү-Шилдэг сувилагч”1-ийг шалгуурын дагуу бүх шатлалын Эрүүл мэндийн байгууллагаас дэвшүүлэн шалгаруулж, тус бүр 1,0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. -ЭМЯ-наас зохион байгуулсан Эрүүл мэндийн байгууллагуудын 5 төрлийн спортын тэмцээнд амжилттай оролцсон 2 мэргэжилтэнд тус бүр 150,0 мянган төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. -Монголын Яаралтай тусламжийн нийгэмлэг, УНТЭ-тэй хамтран Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит “Миний мэргэжил–Миний бахархал”сэдэвт яаралтай амиллуулах суурь тусламжийн ажил мэргэжлийн уралдаанд Эрдэнэт медиал, ХХЭМБ, Мөнхсүндрэл ӨЭМТ, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн "AVENGERS" нэгдсэн баг шилдгээр шалгарч, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, жолооч нийт 11 хүн 4,0 сая төгрөгийн шагнал, өргөмжлөлөөр шагнагдсан.	
47	3.1.3.Бүсийн оношилгоо эмчилгээний төвд туслах сувилагчийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх	78,0 сая ОНТ	Зардал шийдвэрлэгдсэн байна.	100,0 %	100,0%	Аймгийн хэмжээнд сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, сувилагч нарын ажлын ачааллыг бууруулах, хүний нөөцийн хүрэлцээг сайжруулах зорилгоор Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 23, Хойд бүсийн хавдрын оношилгоо, эмчилгээний дэд төвд 5, нийт 28 туслах сувилагч ажиллаж байна. -Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сувилахуйн алба нь нийт 255 сувилагч, тусгай мэргэжилтний орон тоотойгоор ажиллах ёстой боловч одоогийн байдлаар 196 сувилагч, 23 туслах сувилагчтай ажиллаж байгаа нь 18 сувилагчийн орон тооны дутагдалтай байна. - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны хуралдаанаар анх туслах сувилагч ажиллуулах үйл ажиллагааны зардлыг дэмжсэнээс хойш жил бүр орон нутгийн төсөвт Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 12 туслах сувилагчийн цалинг санхүүжүүлж сувилахуйн тусламж үйлчилгээний ачааллыг бууруулж, хүртээмжийг нэмэгдүүлсэн бодлого зохицуулалт хийгдсэн. 2025 онд 78.0 сая төгрөгийг орон нутгийнт төсвөөс шийдвэрлэсэнээр 8,829 иргэнд асаргаа, сувилгаа, 67 удаагийн сургалтаар 1,758 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. Туслах сувилагчийн тоо жилээс жилд тогтмол өсөж, өмнөх оноос 12 сувилагчаар нэмэгдсэн байна. -Туслах сувилагч нар эрчимт эмчилгээ, төрөх, эмэгтэйчүүд, гэмтэл, хүлээн авах яаралтай тусламж, хүүхэд, хавдар, хөнгөвчлөх тусламжийн тасаг зэрэг тусламж үйлчилгээний ачаалал өндөртэй тасаг, нэгжүүдэд ажиллаж байна.Туслах сувилагч нарыг ажиллуулснаар сувилахуйн тусламж үйлчилгээний ачаалал буурч, үйлчлүүлэгчдэд үзүүлэх асаргаа, сувилгааны чанар, хүртээмж нэмэгдсэн байна. Үүний үр дүнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж, сувилагчийн хүний нөөцийн дутагдлыг тодорхой хэмжээнд нөхөж чадсан зэрэг бодит үр дүн гарсан	100

						байна.	
Зорилт 2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
48	3.2.1.Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлнэ.		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	89,9%	90,6%	2025 онд нийт эрүүл мэндийн салбарт 2069 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс 452 их эмч, 507 сувилагч ажиллаж байна. -Орхон аймгийн Эрүүл мэндийн салбарын 2025-2030 оны хүний нөөцийн төлөвлөлтийг 2 арга хэмжээ 8 шалгуур үзүүлэлт бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90,6 %-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,7%-иар нэмэгдсэн байна. -Тайлант хугацаанд ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 1785 мэргэжилтэн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. -Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 72,5%,нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч 47,9%,хүний нөөцийн бүрдүүлэлт 81%-тай байна. -Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарт Улаанбаатар хот болон бусад аймгаас шилжин ирсэн 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байраар хангасан.	100
49	3.2.2. Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажиллангаа суралцан мэргэшил дээшлүүлэх,үндсэн болон төрөлжсөн мэргэжил эзэмших, мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ^{4,5}		Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь	13,2%	13,3%	2025 онд улсын төсвийн санхүүжилтээр 60 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж, 1 эмч БНСУ-д өвдөгний үений мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн бөгөөд тайлант хугацаанд төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь 6,0%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7,3%-иар буурсан. -Ажлын байрны болон алсын зайн 112 удаагийн сургалтад нийт 1785 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж 85,4%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.7%-иар өссөн үзүүлэлттэй байна.Магистр, докторын сургалтад 14 мэргэжилтэн суралцаж байгаа бөгөөд үүнээс 5 нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр шинээр элссэн. -Тайлант хугацаанд Япон, БНХАУ, Филиппин, Узбекистан, БНСУ зэрэг оронд эх барих, нярайн эмчилгээ, мэс засал, удирдлага, хараа зүй, бөөр, мэдрэл зэрэг чиглэлээр 11 эмч олон улсын сургалт, семинарт хамрагдан онол, дадлага хослуулан ур чадвараа дээшлүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна. -ХПВ-ийн дархлаажуулалтын бүсийн сургалтын үр дүнд ХПВ-ийн дархлаажуулалтын хувь 25%-иар өсөж 53.2%-д хүрч, нярайн цогц скринингийн сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн мэдлэг 17%-иар нэмэгдсэн байна. -Дэлхийн эмч, сувилагчдын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан бага хуралд 199 судлаач оролцож, 49 илтгэл хэлэлцүүлсэн. -БНСУ-д болсон Ази, Номхон далайн өрхийн эмч нарын чуулганд 8 төвийн 11 эмч оролцож, Энэтхэгийн “Мах Хийлткэйр” группийн хамт 13 өвчтөнд зөвлөгөө өгч, 15 эмчид хавдрын менежментийн сургалт зохион байгуулсан. Мөн Австри, БНСУ-д нийт 5 мэргэжилтэн туршлага судалсан байна.	100

						-Орон нутагт нэн шаардлагатай 6 мэргэшлээр 9 эмч, сувилагчийг сургасан. Үүнд: Өвдөгний үений мэс засал судлал, Эмэгтэйчүүдийн хавдар судлал, ходоод, нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал, хөх, улаан хоолойн хавдрын мэс засал судлал, эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал судлал, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал судлал, хавдрын сувилагч,хөнгөвчлөх эмчилгээний сувилагч -World standart consulting академитэй хамтран удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, Орхон аймгийн ЭМБ-уудын 70 удирдлагуудыг оролцуулан чадавхжуулсан байна.	
50	3.2.3. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төгсөлтийн дараахь сургалтын чадавхийг бэхжүүлж, эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж дэмжлэг үзүүлнэ. ⁵	ОНТ 50,0сая	Хамрагдсан эмч,эмнэлгийн мэргэжилтний тоо	11	12	Жайка ОУБ-тай хамтран БОЭТ-ийн төгсөлтийн дараах сургалт 7 дахь жилдээ тасралтгүй явагдаж байгаа бөгөөд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай байгаа хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх сургалтыг жил бүр зохион байгуулж байна. -Тайлант хугацаанд яаралтай тусламжийн сувилахуй 12, эрчимт эмчилгээний сувилахуй 4 нийт 11 эрүүл мэндийн байгууллагын 16 сувилагч суралцаж, амжилттай төгссөн. -Ингэснээр дээрх чиглэлээр өрхийн эрүүл мэндийн төв-3,Хувийн хэвшлийн ор бүхий клиник -5, Эрдэнэт сувиллын цогцолбор-1, Хойд бүсийн хавдрын эмчилгээ оношилгооны дэд төв-1, Бүсийн оношилгоо эмчилгээний төв-6 төрөлжсөн мэргэжлийн сувилагч бэлтгэгдсэн байна.	100
51	3.2.4.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан,орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээг авч ажиллан, Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заалтын дагуу ахмад настныг ажлын байраар хангаж,хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллана ⁵		Хамрагдсан эмч,эмнэлгийн мэргэжилтний тоо	10	20	Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төвийн ажилтнуудын үндсэн цалинг 8%-иар нэмж 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн.Улаанбаатар хотоос гэр бүлээрээ шилжин ирж Жаргалант сумын эрүүл мэндийн төвд ажиллаж буй 2 эмчийг дотор болон хүүхэд судлал чиглэлээр үндсэн мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр сургаж, орон сууцаар ханган дэмжсэн. -Шилжин ирсэн 2 шинэ сувилагчийг “Шинэ сувилагчийг дадлагажуулах хөтөлбөр”-т хамруулж,ажлын байранд дадлагажуулсан.50 ба түүнээс дээш ажилтантай байгууллагууд нийт 66 ажиллаж байгаа бөгөөд Ахмад настны тухай хуульд заасны дагуу 60-аас дээш насны эрэгтэй 8, 55-аас дээш насны 55 эмэгтэйг ажлын байраар хангаж, хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллаж байна. Үүнээс сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 12, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 35 ажиллаж байна.	100
Стратегийн зорилго 4. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							
Зорилт 1. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан үйлчилгээ үзүүлэх орчин бүрдүүлэхэд орон нутгаас төсөв хөрөнгө шийдвэрлэж ажиллана. ⁵							
52	4.1.1. БОЭТ-ийг орчин	ОНТ	Тоног	95,5%	95,7%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь стандартын дагуу нэн	

	үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломж бүрдүүлнэ. ^{2,4}	825,0	төхөөрөмжийн хангалтын хувь			шаардлагатай болон шаардлагатай 600 гаруй буюу багаж тоног төхөөрөмжийн хангалт 96%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0,5%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.Тус төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлсэн дэвшилтэт технологийн багаж тоног төхөөрөмжийн эзлэх хувь 20,1%-тай байна. Тайлант хугацаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 825,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нээлттэй тендер зарлагдан ариутгалын газ плазма аппарат,эрчимт эмчилгээний тасагт мэдээгүйжүүлгийн аппарат, Компьютер техник хэрэгслээр хангахаар Медстар ХХК, Биомед трейд ХХК, Медстар эрдэнэ ХХК-д тус тус шалгарч 100 хувь нийлүүлэгдэн тусламж үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлсэн байна.Үүнд: -Хавдрын төвд 602 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан. Зүрхний титэм судасны ангиографийн оношилгоо, эмчилгээ 406, элэгний хавдрын тэжээгч судас бөглөх эмчилгээ 44, тархины судасны оношилгоо эмчилгээ 34, зүрхний хэм алдагдлын байнгын суулгац 1, хавдрын хими эмчилгээний үеийн венийн судасны порт 12 хийсэн байна. -БОЭТ-ийн түргэн тусламжийн дуудлага, цаг товлолын үйл ажиллагааг цахимжуулахад аймгийн төсвөөс 75 сая төгрөгийг зарцуулж, амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн систем бүрэн нэвтэрсэн. -Харвалт шигдээсийн төв нь зүрхний титэм судсан дотуурхи мэс засал 406, тархины судасны оношилгоо эмчилгээ 24 хүнд, -Элэгний хавдар бөглөх ажилбар 44 хүнд тус тус хийгдсэн байна. -Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 23 нярайд хийж, 82.6 %-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 0.3 хувиар нэмэгдсэн. -Мухар олгойг дурангаар авах мэс заслыг нэвтрүүлж 11 хүнд амжилттай хийгдсэн байна. -Шээлгүүрийн дурангаар 5 хүнд шээлгүүрт стент тавих, чулуу авах 2 үе шаттай хагалгааг хийсэн байна.	100
53	4.1.2.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тогтмол зардлын санхүүжилтийг шийдвэрлэх	ОНТ 1,040,0	Тогтмол зардал шийдвэрлэгдсэн байна.	-	100,0%	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03/13 тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2025 онд нийт 1,125.7 сая төгрөгийн санхүүжилт авснаас байр ашиглалттай холбоотой санхүүжилт 1,033.4 сая төгрөг, урсгал засварын санхүүжилт 92,3 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус орон нутгийн төсвөөс шийдвэрлэж, дэмжлэг үзүүлсэн байна.	100

54	4.1.3.Өрхийн эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтийг шийдвэрлэх	ОНТ 327,8 сая	Тогтмол зардал шийдвэрлэгдсэн байна	-	100,0%	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 03/13 тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд Аймгийн Засаг Даргын гурвалсан гэрээний дагуу тогтмол зардлыг хариуцан орон нутаг олгохоор шийдвэрлэсэн. Уг тогтмол зардалд 327,8 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэн 100 хувь олгосон.	100
55	4.1.4.Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн шугамыг засварлах	ОНТ 196,7 сая	Засвар хийгдсэн байна.	-	100,0%	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Мэндцэцэн өрхийн эрүүл мэндийн төвийн гадна шугамыг хэсэгчлэн шинэчлэх ажлыг “Билэг Хайрхан” ХХК ажлыг гүйцэтгэж 100 хувь хийж гүйцэтгэсэн байна.	100
56	4.1.5. Анхны оч өрхийн эмнэлгийн дээврийн болон дотор засварын ажил хийх	ОНТ 253,0 сая	Засвар хийгдсэн байна.	-	100,0%	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Анхны-Оч өрхийн эрүүл мэндийн төвийн дээврийн засварт 253,0 сая төгрөг батлагдаж, “Вила Проект” ХХК ажлыг гүйцэтгэн 100 хувь ашиглалтад оруулсан байна.	100
57	4.1.6.БОЭТ-ийн төрөх тасгийн засварыг хийж, стандартын шаардлага хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ	ОНТ 1,291,2	Засвар хийгдсэн байна.	-	100,0%	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар БОЭТ-ийн төрөх тасгийн 1-3 давхар болон шугам хоолойн их засварын ажлын нээлттэй тендер 2 удаа зарлагдан хуулийн хугацаанд амжилтгүй болж ирэх оны төсөвт тусган шийдвэрлэсэн.	0
58	4.1.7.Уртбулаг багт шинээр баригдах өрхийн эрүүл төвийн газрын асуудлыг шийдвэрлэнэ.	ОНТ	Захирамж гарсан байна.	-	100,0%	Аймгийн Засаг даргын 2025 оны 04-р сарын 23-ны өдрийн А/324 тоот захирамжаар Уртбулаг багт шинээр өрхийн эрүүл мэндийн төвийн барилга барихаар А/211 тоот захирамжаар 1250 м2 талбайн хэмжээтэй 6103343616 нэгж талбарын дугаартай газрыг шийдвэрлэсэн байна.	50
Зорилт 2. Санхүүгийн зарцуулалтад хяналт тавин, санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллах							
59	4.2.1. Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг хугацаанд нь төсвийн ерөнхийлөн		Хугацаан даа хүргэгдсэн тайлан	100%	100%	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд хамаарах орон нутгийн төсвийн байгууллагуудын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг төрийн аудитаар хянан баталгаажуулж, Эрүүл мэндийн салбарын санхүүгийн нэгдсэн тайланг гарган Эрүүл мэндийн Сайдаас ирсэн албан хуваарийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 17-21-ны өдрүүдэд төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэл тайланд бүрэн нэгтгүүлж ажилласан. Нэгтгэл тайланд байгууллага тус бүрээр холбогдох анхан шатны баримт материалуудыг авч хадгаламжийн нэгж хэлбэрээр хүлээлгэн өгсөн.	100

	захирагчид хүргүүлнэ. ⁵						
60	4.2.2.Худалдан авах ажиллагааг төлөвлөх тайлагнахдаа Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалыг дагаж мөрдөх, цахим системд хуульд заасан хугацаанд оруулах, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллана.		Хуульд заасан хугацаанд цахим системд оруулсан хувь	100%	100%	Тайлант хугацаанд худалдан авах ажиллагааг tender.gov.mn сайтаар ажил үйлчилгээ, барааг худалдан авч төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо,судалгааг гарган tender.go.mn –д тогтмол бүртгэж хэрэгжилт 100,0 %-тай байна. -Тус цахим сайтад тендерийн худалдан авах үйл ажиллагааны бүх мэдээллийг хуульд заасан хугацааны дагуу байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. -Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 70 багцад 3,265 тэрбум төгрөгийн төсөвтэй худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд 4 багцын худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 66 багцад 27 компани шалгаран гэрээ байгуулж, сар тутам тогтмол, тасалдалгүй нийлүүлэн ажиллаж байна. -БОЭТ-ийн гемодиализийн тусламж үйлчилгээг гэрээгээр үзүүлэх хувийн хэвшлийн ЭМБ-ыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг АЗДТГ-тай хамтран зохион байгуулсан.	100
61	4.2.3.Эрүүл мэндийн даатгалын сангаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг нэг иргэнээр болон тусламж үйлчилгээний чанар үр дүнд суурилсан гүйцэтгэлээр , лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг тусламж үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлээр санхүүжүүлнэ ^{2,5}		Гүйцэтгэлийн санхүүжилтийн хувь	100%	100%	.Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 оны 3-р улирлын байдлаарх авсан нийт гүйцтгэлийн санхүүжилт 27,582,517.7 мянган төгрөг байна. Үүнээс: Бүсийн оношилгоо эмчилгээний төв нийт 20,495,669.2 мянган төгрөг - Тусламж үйлчилгээ 19,242,604.7 мянган төгрөг - Эрт илрүүлэг 614,859.0 мянган төгрөг - Төр хариуцах эм 638,205.5 мянган төгрөг Өрхийн эрүүл мэндийн төвүүд нийт 6,081,909.5 мянган төгрөг - Тусламж үйлчилгээ 1,882,047.5 мянган төгрөг - Нэг иргэн 4,128,700.8 мянган төгрөг - Шүд амны хөндий 71,161.2 мянган төгрөг Сумын эрүүл мэндийн төв нийт 1,004,939.1 мянган төгрөг - Нэг иргэн 758,550.7 мянган төгрөг - Тусламж үйлчилгээ 245,348.9 мянган төгрөг Шүд амны хөндий 1,039.5 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна. 2024 оны жилийн эцэст үүссэн байсан 2,7 тэрбумын даатгалын санхүүжилтын авлага бүрэн барагдсан байна.	100
Стратегийн зорилго 5. Эрүүл мэндийн салбарт мэдээлэл, технологийн удирдлагыг хөгжүүлнэ.							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ							
62	5.1.1.Алсын зайн анагаах		Алсын зайн	6	8	Тайлант хугацаанд телемедициний хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: -Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд	100

	ухаан, телемедицинский техник тоног төхөөрөмжийг сайжруулан, цахим эрт илрүүлэг, алсын зайн оношилгоо хийх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. ^{2,4,5}		оношилгоо отелемедицинский техник тоног төхөөрөмж бүхий байгууллагын тоо			215 хүний мэдээллийг оруулсан. -БНСУ-ын Бусан хотын Үндэсний их сургуулийн эмнэлгийн алсын зайн оношилгоо, эмчилгээний төв Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 2023 онд байгуулагдсан бөгөөд 2025 онд нийт 21 өвчтөнд зөвлөгөө авсан байна. -Жаргалант сумын эрүүл мэндийн төв болон 5 өрхийн эрүүл мэндийн төвд Мобайл технологи хэрэгжиж тайлант хугацаанд мобайл технологиор гэрийн эргэлтийн IV, V-р бүлгийн эргэлт, алслагдсан багийн малчдын эргэлт, явуулын үзлэг, байгууллагын урьдчилан сэргийлэх үзлэг зэрэгт ашиглаж давхардсан тоогоор 10,000 гаруй хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн байна -Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай, хэвтэрт байдаг иргэдэд Эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын телемедицинээр гэрээсээ өрхийн эмчийн хамт орон хөнгөвчлөх ажлыг зохион байгуулсан нь нийт групп сунгуулагдагсдын 2%-ийг эзлэж байна. -Хувийн хэвшилд Баян-Өндөрмөд нэгдсэн эмнэлэг нь умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт хиймэл оюун ухааныг ашиглаж байгаа бөгөөд тайлант хугацаанд нийт 476 хүнийг хамруулан, эрүүл 329, хавдрын урьдал үе оношилогдсон 83, эмчилгээнд хамруулсан 64, лавлагаа шатлалд илгээсэн 35 байна. -Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмж бүхий Эрүүл мэндийн 11 байгууллага байгаа ба техник тоног төхөөрөмжийн хангалт 35%-тай байна. Алсын зайн оношилгоо, телемедицинский техник тоног төхөөрөмжийн хангалт 33.2%-тай болж өмнөх оноос 0,2%-аар нэмэгдсэн.	
63	5.1.2. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг интернет сүлжээнд холбогдсон байна. ⁵		Мэдээлэл, сүлжээ программ д холбогдсон байгууллагын тоо	10	15	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн 161 Эрүүл мэндийн байгууллага интернэтийн сүлжээнд 100% холбогдсоноос 13 эрүүл мэндийн байгууллага Юнивишн, Мобинет ХХК-ийн dedicated 20mb хурдтай өндөр хурдны шилэн кабелийн интернэтийн сүлжээнд холбогдсон. Интернэтийн хурд сайжирснаар өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн цахим программуудыг өндөр хурдны интернетийн сүлжээгээр ашиглаж, иргэдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэн, мэдээ мэдээллийн тасралтгүй байдлыг ханган ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ашиглаж буй E-Health цахим системийн хөгжүүлэлт тогтмол хийгдэж, эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг тус системд холбосон. Мөн байгууллагын интернет хурдыг 100мб хурдтай байсныг 1гб болгон хурдыг 10 дахин нэмсэн. Тайлант хугацаанд мэдээлэл солилцооны нэгдсэн платформ ННЕР-д E-Health системд холбогдсон. Мөн дүрс оношилгооны PACS систем ННЕР системтэй холбогдон мэдээлэл солилцох боломжтой болсон. Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ E-Mongolia системээс эрүүл мэндийн чиглэлээр 19 үйлчилгээг авч байна. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн 8 төв, Жаргалант сумын эрүүл	100

						мэндийн төвүүд нь 2 mb/ps хурдтай интернетэд холбогдсон.	
64	5.1.3.Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана. ⁵		Үнэлгээ хийлгэсэн байгууллагын тоо	-	1	Тайлант хугацаанд Тагнуулын газартай хамтран эрүүл мэндийн салбар 25 байгууллагуудад кибер аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийж, зөвлөмжийн хэрэгжилт 81,8%-тай байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төв үнэлгээнд хамрагдан зөвлөмжийн хэрэгжилт 84,5%-тай байна. -Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийн мэргэжилтэн, бүртгэл статистикийн ажилтнуудыг хамруулсан “Кибер аюулгүй байдал, мэдээллийн ил тод байдлын тухай хууль” сургалтыг 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 35 хүнийг хамруулсан байна.	85
65	5.1.4. Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эруул мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна ⁵		Хамрагдсан ажилтны тоо	10	50	Тайлант хугацаанд ЭМГ-аас зохион байгуулсан “Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулая” сэдэвт 1 сарын аяны хүрээнд Цагдаагийн газартай хамтран кибер аюулгүй байдлын сургалт зохион байгуулж, 65 ЭМБ-ын удирдлага, чанарын албаны дарга, эмч,эмнэлгийн мэргэжилтэнг хамруулсан. Төрийн цахим үйлчилгээний төвөөс зохион байгуулсан кибер аюулгүй байдлын сургалтад хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл статистик хариуцсан ажилтан 11 хүнийг хамруулсан.	80
66	5.1.5.Бүсийн оношилгоо эмчилгээний төвд цаг товлол болон түргэн тусламжийн 103 дуудлагыг цахимжуулалтын программ хангамжийн зардлыг шийдвэрлэх	ОНТ 75,0 сая	Программ хангамжийн зардал шийдвэрлэгдсэн байна.	-	100,0%	Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн 75,0 сая төгрөгийн санхүүжилтээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн 103 дуудлагын үйлчилгээний программ хангамжийг шинэчлэх ажлыг гүйцэтгүүлэхээр 2025.02.14-нд зарласан сонгон шалгаруулалтад “Эгософт” ХХК шалгарч,гүйцэтгэл хугацаандаа 100% хийгдсэнээр Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн сайтын танилцуулга ба үйлчилгээний заавар бүхий нийтлэлийн хандалт 2 дахин нэмэгдэж, иргэдийн эмнэлгийн мэдээлэл авах хүртээмж нэмэгдсэн байна. -Жирэмслэлт, 3 нас хүртэл хүүхдийн эрүүл мэндийн хяналтын гар утасны аппликейшн,Нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ,цаг захиалга,түргэн тусламжийн дуудлагын 2 төрлийн гар утасны аппликейшныг бүтээн, одоогоор хөгжүүлэлтийн шатанд явагдаж байгаа ба эмчийн цаг захиалах системийн туршилтаар хүлээгдэл 30 хувиар буурч, жирэмсэн эхчүүдийн дунд мэдээлэл авах хүртээмж өссөн үзүүлэлттэй байна.	100
67	5.1.6.Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ		Мэдээний чанар	95,6%	95,8%	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй 154 байгууллагаас үйл ажиллагааны чиглэлээр сар бүр албан ёсны мэдээ тайланг батлагдсан маягтын дагуу 141 үзүүлэлтээр хүлээн авч нэгтгэн, мэдээлсэн. -Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тушаалын дагуу бүртгэл тайлангийн маягтын загвар хөтлөх зааврыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж анхан шатны маягтуудыг шинэчилсэн. -Хувийн хэвшлийн ортой болон амбулаторийн тусламж үйлчилгээний	100

	мэдээллийн үнэн, зөв, шуурхай байдлыг ханган ажиллана. ⁴					клиник нийт 68 байгууллагын мэдээний чанар, мэдээ өгөлтийг цахим хэлбэрээр авч эхэлснээр мэдээ өгөлт 93.8 хувьд хүрсэн. -Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 73 эмийн сангийн мэдээ өгөлт 72.1% болж өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн. Мэдээний үнэн зөв байдлыг хангуулах зорилгоор танхимын 3 удаагийн сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын бүртгэл статистик хариуцсан ажилтан, байгууллагын удирдлага давхардсан тоогоор 38 хүн, цахим уулзалт хэлэлцүүлэгт 13 хамруулсан. -Тайлант хугацаанд мэдээ өгөлт 89.1%, мэдээний чанар 96% байна.	
ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.							
Зорилт 1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, олон нийтийн оролцоо, салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрүүл мэндийг дэмжих орчин бий болгох							
68	1.1.1. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих “Эрүүл хамт олон” хөдөлгөөн өрнүүлж, сайн туршлагыг нийтийн хүртээл болгон урамшуулна. ^{3,4}	ОНТ 10.0 сая	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо	5	5	Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хүрээнд 7 арга хэмжээг салбар дундын оролцоотой хамтран зохион байгууллаа. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомж, Оффисын ажилтны хөдөлмөрийн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг байгууллагын 34 албан хаагчдад зохион байгуулж үр дүнг тооцож ажилласан. ХАБЭА-н сарын аяны хүрээнд төрийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан “Байгууллагын үйлчилгээний ажилчдын чадварыг нэмэгдүүлэх” харуул хамгааллын бэлэн байдлыг хангая” уралдаанд эрүүл мэндийн салбараас төлөөлөл болон 11 хүн амжилттай оролцож, ур чадвараа нэмэгдүүлсэн. Аймгийн Нийгмийн даатгалын газрын 21 албан хаагчдад "Сэтгэцийн эрүүл мэнд", "Ажлаас халшрах хам шинж" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сэтгэл түгшилтээ хэрхэн зөв удирдах, шийдвэрлэх талаар зөвлөгөө өгч ажилласан. Эрдэнэт үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй зөвлөлтэй хамтран “Эрүүл мэндийн дэмжигч байгууллага” шалгуурын талаар 27 цехийн 54 хүн, 33 цехийн дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан 66 хүнд “Эрүүл мэндийн дэмжигч” байгууллага хөдөлгөөний талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг тус тус зохион байгуулсан. Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих аяны хүрээнд Орхон аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран харьяа 16 байгууллагын 800 албан хаагчдын дунд “Шүд угаах цаг” аяныг өрнүүлж цайны цагийн дараа шүд угааж хэвшсэн байгууллагыг шалгаруулж олон нийтэд сурталчилж ажилласан. Тайлант хугацаанд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор	100

						орон нутгийн төсвөөс 9,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусгуулан 2025 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох хүсэлт ирүүлсэн 13 байгууллагаас зэрэглэл ахиулахаар 9 байгууллага, шинээр 4 байгууллагад Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын шалгуур үзүүлэлтийн дагуу ажлын хэсгээс ажлын байранд дээр очиж үнэлгээ хийж, сонгон шалгарууллаа. Комиссын хурлын шийдвэрээр 4 байгууллага шинээр, 5 байгууллагыг зэрэглэл ахиулж, 4 байгууллага шалгуур үзүүлэлтийн оноонд хүрэлгүй хасагдаж үнэлэгдсэн. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 92 байгууллагатай болсон байгаа нь өмнөх оноос 4-өөр нэмэгдсэн байна.	
69	1.1.2.Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, салбар дундын уялдааг ханган хамтарч ажиллана.⁵	13,5 сая ОНТ	Хэрэгжилтийн хувь	85,0	88,0	-Тайлант хугацаанд сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх илрүүлэг үзлэгт 22 сургуулийн 2576 суралцагчаас 2554 буюу 99,1 хувь нь хамрагдаж,1773 буюу 68,8 хувьд өвчлөлийн сэжигтэй тохиолдол илэрч, 720 буюу 28,1 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. -Шүд угаах 24/3 аяны хүрээнд 12766 хүнд сургалт зохион байгуулж,боловсролын байгууллагын 56, сургуулийн өмнөх боловсролын 32 байгууллагад “Зөвийг дадал болгоё” аянд 248 хүүхэд 248 эцэг эх асран хамгаалагч 64 багшийн оролцуулан,39 цэцэрлэг, 24 сургууль, политехникийн 1 их дээд сургууль 1 нийт 65 байгууллагын 1214 ажилчдад шүд угаах онол дадлага хосолсон сургалт зохион байгуулсан. -ЭМЯ, ЭХЭМҮТ-ээс ирүүлсэн төлөвлөгөөний дагуу салбар дундын байгууллагуудын оролцоотой зохион байгуулсан өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих сарын аяны нээлтэд 120 ахлах ангийн сурагч, эцэг эх, асран хамгаалагчдын төлөөлөл оролцож, 63 удаагийн сургалт,хэлэлцүүлэгт ЕБС-ийн ахлах ангийн 2582 сурагчид хамрагдаж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон байна. -Хүний папиллома вирусын эсрэг вакцины хамралтыг нэмэгдүүлэх аяныг сум, өрхийн эрүүл мэндийн төв, ерөнхий боловсролын сургуулиудын дунд БГ-тай хамтран зохион байгууллаа.Энэ хүрээнд дархлаажуулалтын цэгүүдэд 2 удаа дэмжлэгт хяналт хийн,зөвлөмж өгч ажиллан Дэлхийн дархлаажуулалтын 10 хоногоор “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрт хүртээе” өдөрлөгийг Эрүүл мэндийн газар, сум, өрхийн эрүүл мэндийн төв 9, ерөнхий боловсролын сургууль 23 хамтран дараах арга хэмжээг зохион байгуулж, 4500 гаруй сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан.Мөн нөлөөллийн уулзалтад орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн салбарын төлөөлөл 100, сургагч багш бэлтгэх сургалтад сурагчид болон эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллөөс 200 багш бэлтгэн сургууль бүр тус арга хэмжээг хамтран зохион байгуулж ажилласан. Хүний папиллома вирусын эсрэг вакцины хамралт 52%-д хүрсэн байна. -Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд,	100

						нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан. -Аймгийн ИТХ, ЗДТГ-тай хамтран "Иргэдийн оролцоо-Төлөөлөгчийн манлайлал-Төрийн үйлчилгээ нэгдсэн өдөрлөг" арга хэмжээнд ЭМГ, сум, 8 өрхийн эрүүл мэндийн төв оролцон 10700 гаруй хүнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа бодлого шийдвэрийг сурталчлан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажилласан.	
Зорилт 2. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхыг бэхжүүлж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, салбар хоорондын оролцоо, халдварт өвчнийг хамтын ажиллагаанд тулгуурлан бууруулах.							
70	1.2.1. Заавал хийх товллын дархлаажуулалтад хүүхэд бүрийг бүрэн хамруулах, тархвар судлалын заалтаар хийх дархлаажуулалтыг зохион байгуулж, дархлаажуулалтын дараах урвал хүндрэл, тарилгатай халдварт өвчний бүртгэл, мэдээлэл, тандалтыг эрчимжүүлнэ.^{1,2,4}		Дархлаа жуулалтын хамралтын хувь	99,0	99,01%	Тайлант хугацаанд халдварт өвчний 593 тохиолдол бүртгэгдэж, өнгөрсөн оны мөн үеэс 2,1 промиллоор буурсан байна. -Товлолын дархлаажуулалтад хамрагдвал зохих 5973 хүүхдээс 5967 хүүхэд хамрагдаж, бүрэн тунгийн хамралт 99,8% буюу өмнөх оны мөн үеэс 0,8 -%-иар нэмэгдсэн байна. -Дархлаажуулалтын хамралтыг нэмэгдүүлэх, халдварт өвчний хариу арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр Засаг даргын захирамжаар 2 ажлын хэсэг байгуулж, 23,7 сая төгрөгийг шийдвэрлэн,хэрэгжилтийг 100% хангаж ажиллалаа. -Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 4758 хүүхдээс 2543 хүүхэд хамрагдаж, хамралт 53,6% буюу 23,4%, Улаанбуруханы нөхөн дархлаажуулалтд 745 хүүхдийн хамруулж, 1774 хүүхдийн мэдээллийг цахим бүртгэлд нөхөж оруулан, нөхөн дархлаажуулалтад хамрагдвал зохих 3717 хүүхдээс 2519 хүүхэд нөхөн дархлаажуулалт болон цахимд нөхөн бүртгэж, хамралт 70% буюу 38% тус тус нэмэгдсэн байна. Дархлаажуулалтын талаар иргэдэд мэдээлэл түгээх 4 удаагийн аян, 2 өдөрлөг зохион байгуулж, 1 төсөл хэрэгжүүлэн ажилласан. Дээрх арга хэмжээнд 70 гаруй байгууллага хамтран ажиллаж, давхардсан тоогоор 7000 гаруй сурагч, 6000 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл хамрагдсан. -Мөн нөлөөллийн уулзалт 1, багш бэлтгэх сургалт 3 удаа зохион байгуулж, орон нутгийн удирдлагууд, төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагч, сурагчид, эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөлөл 260 хүн хамрагдсан. -2872 хүүхдийн дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийн тандалт хийж, хэсэг газрын урвал 1, 37,5 хэмээс дээш халуурсан 9, ерөнхий урвалын1 тохиолдлыг бүртгэж, сар бүр ХӨСҮТ-д мэдээлж байна. - Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс нийт 2 удаагийн татан авалтаар 20 нэр төрлийн 39350 хүн тун вакцин,14100 дагалдах	100

						хэрэгслийг татан авч дархлаажуулалтын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. -Халууралт тууралтат халдварын сэжигтэй 24 тохиолдлын шинжилгээг Халдварт өвчин судлалын үндэсний төвд улаанбурхан, улаануудын лабораторид хүргүүлж, 5 тохиолдол батлагдсан. Гахайн хавдар өвчний 15 тохиолдлын судалгааг хийж, хариу арга хэмжээг авч ажилласан. Дархлаажуулалтын сувилагч нарт мэдлэг сэргээх, чадавхжуулах 10 удаагийн 10 нэгжийн 170 хүн давхардсан тоогоор хамрагдсан.	
Зорилт 3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх							
71	1.3.2.Тохиолдол удирдлагын тогтолцоог бэхжүүлж хариу арга хэмжээний чадавх, гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын нөөц хангалтыг нэмэгдүүлнэ 2.4	ОНТ 55,0 сая	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн хангалтын хувь	80%	85%	Эрүүл мэндийн газрын даргын А/88 дугаар тушаалаар батлагдсан томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх Тохиолдлын удирдлагын баг нь тохиолдол удирдлагын тогтолцоонд шилжин салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж, эрсдлийн үеийн мэдээллийг шуурхай солилцон, өвчлөл, тархалт, нөхцөл байдалд эрсдлийн үнэлгээг 4 удаа хийж,хариу арга хэмжээний хэрэгжилт 95,6% байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,2%-иар нэмэгдсэн байна. Аймгийн онцгой комиссын шийдвэрээр батлагдсан 131 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2000 ширхэг түргэвчилсэн оношлуур, 7 төрлийн багаж тоног төхөөрөмж, Н95 амны хаалт 1000 ширхэгийг ЭМБ-уудад хуваарилан томуугийн тусламж үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлсэн. Орон нутгийн 2025 оны төсөвт нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын хариу арга хэмжээг чадавхжуулах зорилгоор 55 сая төгрөгийг төсөвт тусгуулан хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлсэн. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг хангах хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны А/586 дугаар захирамжаар батлагдсан салбар дундын ажлын хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/49 дугаар тушаалаар байгуулагдсан шуурхай удирдлагын 5 баг 28 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, эрсдлийн үнэлгээ 3 удаа хийж, тандалт судлагаа сэжигтэй тохиолдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, эрсдэлийн үеийн мэдээллийг идэвхжүүлж, ажиллалаа.Улаанбурхан өвчний сэжигтэй 24 тохиолдол бүртгэгдэж, 9 тохиолдол батлагдаж, хариу арга хэмжээг авч ажилласан. -Орхон аймгийн Засаг даргын 2025 оны А/449 дүгээр захирамжийн дагуу “Хотын гамшгийг тэсвэрлэх чадавхыг онооны аргаар үнэлэх” ажлын хэсгийн хурлаар 110/141 оноогоор үнэлэгдэж 78%-ын бэлэн байдлыг хангасан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2,0%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. -ЭМГ-ын гамшгийн нөөцөд 1 нэр төрлийн 4,81 сая төгрөгийн эм, 5 төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгслийн 4,6 сая төгрөгийн яаралтай тусламжийн багц, 3 нэр төрлийн 27 сая төгрөгийн хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байна. Эрүүл мэндийн	100

						байгууллагуудын гамшгийн үеийн нөөцийн хангалт дунджаар 91%-тай байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 94%-тай байна.	
Зорилт 4. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллах ⁵							
72	1.4.1. Эрүүл мэндийн салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана. ⁵		Объектын хамрагдал т Эрсдэлийн түвшин Хууль тогтоомжийн хэрэгжилт	100% Их-20% Дунд-80% 83,0%	100% Их-20% Дунд-80% 84,0%	Төлөвлөгөөт шалгалтад хамрагдах 98 объектоос 98 буюу 100 хувийг хамруулж, 4 объект буюу 4 хувь нь их эрсдэлтэй 34 объект 33,3 хувь нь дунд эрсдэлтэй, 60 объект 61,6 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдэж, хууль сахин мөрдөлтийн дундаж 86 хувь байгаа нь өмнөх оны дүнгээс 3 хувиар нэмэгдэж, зорилтот түвшинг хангасан үр дүнд хүрсэн. - Нийт 1514 зөрчлийг илрүүлэн 501 буюу 33 хувийг газар дээр нь арилгуулан, улсын байцаагчдын хамтарсан 1388 заалттай 93 албан шаардлагаар 90 объектод хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулан хэрэгжилт 86,4 хувьд хүрсэн нь өмнөх оныхоос 3,4 хувиар нэмэгдэж зорилтот түвшинг хангасан. -Улсын байцаагчийн 133 дүгнэлт, 2 акт үйлдэж 2 объектын үйл ажиллагааг зогсоож зөрчлийг бүрэн арилгуулан, 17 объектод 18.505,000 төгрөгний торгууль, хохирол нөхөн төлбөрийг барагдуулах арга хэмжээ авч, улсын төсөвт 100 хувь төвлөрүүлсэн. - Хими, хор, нян судлалын 8 төрлийн шинжилгээний 557 дээж авч, шинжлүүлэн, 24 сорилын дүн шаардлага хангаагүй зөрчлийг халдваргүйтгэл, ариутгалыг хийлгэж бүрэн арилгуулсан. -Хяналт шалгалтын дүнг Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар 4 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. -Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын хүрээнд хяналт шалгалтад шаардлагатай 98 объектын болон нутаг дэвсгэрийн 5 байршлын хөрсний 6 төрлийн шинжилгээний 557 дээжийг лабораторийн шинжилгээнд хамруулах 6000 000 төгрөгний зардлыг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Хөрөнгө гаргах тухай А/316 захирамж гарч шийдвэрлэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар нотолгоонд суурилсан дүгнэлт, эрсдэлийн үнэлгээг хийж, эрсдэлээс сэргийлэх, бууруулах арга хэмжээ авч ажилласан үр дүнтэй байна. - Дотоод хяналтыг сайжруулах салбарын сургалтад 98 объектыг 100 хувийг хамруулж, шилэн хяналтын цахим системд мэдээллийн санг бүрдүүлсэн.	100
73	1.4.2. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ.		Объектын хамралтын хувь, Албан шаардлагы	100% 80%	100% 80%	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 8 удирдамжийн дагуу хяналт шалгалтад 444 объектыг 100 хувь хамруулж, нийт 631 зөрчлийг илрүүлэн 395 буюу 54,6 хувийг газар дээр нь арилгуулан 36 албан шаардлагаар 11 объектод хугацаатай үүрэг өгч биелэлт 84,8 хувьд байгаа нь өмнөх оныхоос 4,8 хувиар нэмэгдэж зорилтот түвшинд хүрсэн үр дүнтэй байна.	100

			Н хэрэгжилт йн хувь			-Илэрсэн зөрчилтэй холбоотойгоор 5 аж ахуйн нэгж, 9 иргэнд 7.1 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдуулан, 6 дүгнэлт гаргаж, 261 заалттай хамтарсан 9 актаар хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 21 төрлийн 878 000 төгрөгний 285 ширхэг эрсдэлтэй хүнсний бүтээгдэхүүнд акт үйлдэж хураан авч, 223200 төгрөгний хүүхдийн бэлэгт багцлахад хэрэглэх хүчинтэй хугацаа дуусахад 2-10 хоног үлдсэн болон болон бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал алдагдсан барааг газар дээр нь устгуулсан. -Наадмын талбай, нийтийн үйлчилгээг явуулах зам талбайн хөрсний халдваргүйтгэлийг 3 давтамжтай хийлгүүлж, хог хаягдлыг цэвэрлүүлж ачуулсан. Хими, хор, нян судлалын 8 төрлийн шинжилгээний 250 дээж авч, шинжлүүлэн, 18 сорилын дүн шаардлага хангаагүй зөрчлийг халдваргүйтгэл, ариутгалыг хийлгэж арилгуулж, Хяналт шалгалтын дүнг Эрүүл мэндийн газрын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж эрсдэлийг бууруулах бодлого чиглэлийн 4 шийдвэрийг бүрэн хэрэгжүүлсэн. Дотоод хяналтыг сайжруулах салбарын сургалтад 342 объектыг буюу 77 хувийг хамруулж, шилэн хяналтын цахим системд мэдээллийн санг бүрдүүлсэн.	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
74	2.1.1. Эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд хамруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.		Батлагдсан хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт	90%	90-95%	Тайлант хугацаанд магадлан итгэмжлэлд хамрагдсан 25 байгууллага байгаагаас анхан шатлалд 9 байгууллага 100%, 2 дахь шатлалд 4 байгууллага 100%, ор бүхий клиникийн 11 буюу 91,6%, оргүй клиник 1 буюу 1,8%-ийг эзэлж байна. Тайлант хугацаанд 7 ЭМБ-ын магадлан итгэмжлэлийн 36 шалгуур материалыг bakend.acc.hdc.gov.mn програмд 2 үе шаттай оруулж, ЭМХТөвийн шалгуурт тэнцэн 2 дахь шатны магадлангийн шинжээчдийн 3 баг орон нутагт 2 удаа газар дээр нь ирж, магадлангийн шалгуурын дагуу үнэлэн өрхийн эрүүл мэндийн төв 1, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Эрдэнэт клиник, Эрдэнэт Медикал төрөлжсөн эмнэлэг, хувийн хэвшлийн 4 ортой клиникүүд 100% магадлан итгэмжлэлээ сунгуулсан байна. -Магадлан итгэмжлэлд хамрагдсан улс болон хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагууд чанар аюулгүй байдлыг сайжруулах хөгжлийн хөтөлбөрийг 7 зорилтын хүрээнд батлуулан хэрэгжүүлж, хэрэгжилт дунджаар 93,4 %-тай үнэлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3,4%-иар нэмэгдсэн байна. -Эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, Чанар аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, Эмчилгээ чанарын албад, багийн үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт 3 удаа, сургалт мэдээлэл 5 удаа хийж, “Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах” 2 сарын аяныг зарлан үйлчлүүлэгчдэд ээлтэй аюулгүй	100

						орчинг бүрдүүлэх,эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг сайжруулах сургалт, туршлага солилцох уулзалт, өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, ЭМХТөвтэй хамтран эмнэлгийн тусламжийн чанар аюулгүй байдал, магадлан итгэмжлэл, халдварын сэргийлэлт хяналтын чиглэлээр чадавхжуулах төвийн 1 багц цагийн сургалтад ЭМБ-уудын 185 эмч,эмнэлгийн мэргэжилтэнг хамруулан чадавхжуулсан. -2026 онд магадлан итгэмжлэлд хамрагдах 18 байгууллагын дэлгэрэнгүй судалгааг ЭМХТөвд хүргүүлсэн.	
75	2.1.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат,Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт,аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана. ⁵		Багаж тоног төхөөрөмжийн ашиглалт ад хийсэн үнэлгээн ий хувь	90%	92%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн Ангиографикийн тоног төхөөрөмжийн сэлбэгт 41,666,500,Ариутгалын плазм аппаратны сэлбэг хэрэгсэлд 10,098,0,Ариутгалын аппаратны сэлбэг хэрэгсэл 3,436,8,Line sensor 4,500,0 Дурангийн сэлбэг засвар үйлчилгээ 12,300,0 төгрөг буюу нийт 72,001,364 төгрөгийг улс, орон нутаг,БООТ-ийн төсвөөс шийдвэрлэн ашиглалт сайжирсан. -БООТ-ийн ИТТ-ын 3 ажилтан 4 удаа мэргэжлийн чадавхжуулах сургалтад хамрагдан дээрхи багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллаж байна.Багаж тоног төхөөрөмжийн ашиглалтад хийсэн үнэлгээний хувь 92,3%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,3%-иар нэмэгдсэн байна.	100
76	2.1.3. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж, дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх		Цахилгааны эх үүсвэрээр хангагдсан байгууллагын тоо	10	15	Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 110 кватт-ын чадалтай 2 нөөц цахилгаан үүсгүүртэй бөгөөд 3 блокийн 13 тасаг нэгжийг аваарын үед цахилгаан тэжээлээр ханган ажиллах бөгөөд тайлант хугацаанд 22 удаа цахилгаан тэжээл тасарсан үед нөөц цахилгаан үүсгэвэр нийт 425 минут ажилласан байна. Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлэх хүрээнд мэргэжлийн байгууллагаар 3 удаа шалгалт тохируулга хийлгэж 3 удаа ажиллагааны шалгалт хийсэн.Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны чиглэлээр тасаг нэгжийн 26 ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр хагалгаа, мэс заслын тоног төхөөрөмжүүдэд өдөр бүр шалгалт тохируулга хийж тэмдэглэл хөтөлсөн.Эрсдэлээс сэргийлэх чиглэлээр цахилгааны ил утсыг далд монтажтай болгох,өвчтөнүүдийн	100

	үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана ⁵					байнга харьцаж болох цахилгаан хэрэгслүүдэд өдөр тутмын хяналт хийж ажилласан.Учралтбаяр ӨЭМТ 220 кВ цахилгааны эх үүсгэвэр шинээр нэвтрүүлж байгаа ба тохируулга хийлгэхээр ажиллаж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв 10 /хонда мотор/ цахилгааны эх үүсгэвэртэй бөгөөд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй гэрээ байгуулж инженер техник ашиглалтын аюулгүй ажиллагааны заавраар хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг, урсгал засвар, техникийн завсар үйлчилгээ хийж, газардуулга, хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжид хяналт хийж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан ажилласан. -Эрдэнэт медиал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөр мед нэгдсэн эмнэлгүүд 110 кВ цахилгааны эх үүсгэвэртэй, цахилгаан саатлын үед 24-48 цаг ажиллах боломжтой ба шатахуунаар цэнэглэн хэвийн ажиллах хүчин боломж бүрдсэн. Хувийн хэвшлийн ортой 11 клиникийн цахилгааны нөөц эх үүсвэр 95,0%,эрүүл мэндийн салбарын цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдал 90% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 5,2%-иар нэмэгдсэн байна.	
77	2.1.4.Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлын хэрэгжилтийг хэлэлцэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн санал санаачилгатай ажиллана.Үүнд: Эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүн,цахимжилт, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал,Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ,Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ ⁵	465,0 сая ОНТ	Хэлэлцүүлсэн арга хэмжээний тоо	2	4	Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн Хүн амын бүлэг,нийгмийн салбарын хүний нөөцийн 2024-2028 хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүнг сайжруулах, БОЭТ-ийн цаг товллол, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд БОЭТ-ийн чадавхыг сайжруулах,Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр заалтуудыг тусган орон нутгаас төсөв батлан хэрэгжилт дундажаар 85,5%-тай байна.Үүнд: -Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааг дэмжих, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд 25,0 сая төгрөгийг шийдвэрлэж, дэмжлэг үзүүлсэн. -БОЭТ-ийн дэргэдэх Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төвийн засварт орон нутгийн төсвөөс 350.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, тендэр зарлагдан 100% гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна. -2025 онд Үндэсний багтай хамтарч ажиллахад орон нутгаас 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж,хавдрын тусламж үйлчилгээн дэх чирэгдэл хожимдолыг бууруулан,Орхон аймгийн хавдрын тусламж үйлчилгээнд үнэлгээ зөвлөмж өгч чадавхжуулсан. -Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн оношлуурт Баян-өндөр сумын ИТХ-аас 40,0 сая төгрөг шийдвэрлэн анхан шатны байгууллагын тусламж үйлчилгээний чадавхи,хүртээмж нэмэгдсэн байна. -Аймгийн ИТХ-аар өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээ, байршлыг хэлэлцүүлэн, шинээр 2 өрхийн эрүүл мэндийн төвийг байгуулах, үйлчлэх хүрээг 2025 оны 10 сарын 01-ны 03/47 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулснаар анхан шатлалын тусламж үйлчилгээний ачаалал тэнцвэржиж,хүртээмж нэмэгдсэн байна.	100

						-Гемодиализийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр АЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан гемодиализийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувийн хэвшлийн байгууллагыг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, “Их шүүдэргэнэ” ХХК шалгарсан байна.	
Зорилт 2. БОЭТ-ийн менежментийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлж, иргэд орон нутагтаа эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн шинэ дэвшилтэт технологийг нутагшуулна ¹							
78	2.2.1.Олон Улсын чанарын менежментийн тогтолцоо ISO:2015 стандартыг 5 өрхийн эрүүл мэндийн төв, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд нэвтрүүлэх зардлыг шийдвэрлэх	ОНТ 20,0 сая	Чанарын ISO 9001-2015 стандарт нэвтэрсэн байгууллагын тоо	3	3	Эрүүл мэндийн газраас 2025 онд олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартыг 5 ӨЭМТ, БОЭТ-д нэвтрүүлэхээр зөвлөх үйлчилгээнд 20 сая төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр шийдвэрлүүлж, World standart consulting компанитай гэрээ байгуулан 5 өрхийн эрүүл мэндийн төвд уг стандартыг нэвтрүүлээд байна. Ингэснээр өрхийн эрүүл мэндийн 8 төв буюу анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог 100 % нэвтрүүлсэн нь өмнөх оноос 62.5%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна. -БОЭТ,хувийн хэвшлийн эмийн сангийн 40 эмч,эмнэлгийн мэргэжилтэн, эм зүйчдэд ISO9001:2015 стандартыг танилцуулах сургалтыг хийсэн байна. -Дотоод аудитор бэлтгэх сургалтад ӨЭМТ-өөс 10 эмч, сувилагч, БОЭТ-оос 2 чанарын багийн ажилтан, хувийн хэвшлийн эмнэлгээс 1 ажилтан нийт 13 албан хаагч дотоод аудиторын гэрчилгээг гардан авлаа. -Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газар нь ISO9001:2015 стандартын давтан баталгаажуулалтын аудит хийлгэж,гэрчилгээгээ сунгуулсан байна.	100
Стратегийн зорилго 3. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, харилцаа, хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг сайжруулна. ^{1, 2}							
Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлт, хөгжлийг хангах							
79	3.1.1.Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, боловсролын болон мэргэжлийн зэрэг ахиулах үйл ажиллагааг зохион байгуулна. ⁴		Мэргэжлийн зэрэг ахиулсан эмч мэргэжилтний хувь	18,8%	20%	-Тайлант хугацаанд зөвлөх зэргийг 2 сувилагч, тэргүүлэх зэргийг 13 эмч,11 сувилагч ахлах зэргийг 15 эмч, 24 сувилагч хамгаалж, аймгийн хэмжээнд нийт зөвлөх зэрэгтэй 21,тэргүүлэх зэрэгтэй 125, ахлах зэрэгтэй 217 эмч, эмнэлгийн мэргэжилтэн байгаа нь нийт эмч, мэргэжилтний 32 хувийг эзлэж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 13,2 хувиар нэмэгдсэн байна. -Магистр болон докторын сургалтад 14 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байгаагаас 5 мэргэжилтэн нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр магистрын сургалтад шинээр элсэн суралцаж байна.	100
Зорилт 2. Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх							

80	3.2.1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, хэсгийн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, ёс зүйн алдаа зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, алдаа, зөрчлийг бүртгэн мэдээлэх, эмнэлгийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулна.		Хэрэгжилтийн хувь	95,8%	96%	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны тогтоолын хүрээнд ЭМГ-ын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, эрүүл мэндийн байгууллагуудын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороод, СӨЭМТ-үүдэд ёс зүйн багууд байгуулагдаж эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ёс зүйн алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогмол зохион байгуулан ажиллаж байна. -Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга, нарийн бичгийг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс шинээр томилсон.Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо 4 удаа хуралдаж, 3 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 96,5%-тай байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,7%-иар нэмэгдсэн байна. -АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуультай хамтран “Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй” сэдэвт кредиттэй сургалтад 18 эрүүл мэндийн байгууллагуудын 186 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж ёс зүйн хууль тогтоомжийн мэдлэг 18%-иар нэмэгдсэн. Ёс зүйн академитай хамтарсан “Ёс зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх багц” сургалтад ЭМГ-ын 24 албан хаагч, БОЭТ-ийн 75 эмч, эмнэлгийн мэргэжилтэн,Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлага” үндэсний хэлэлцүүлэгт ёс зүйн салбар хорооны 4 гишүүд хамрагдаж чадавхжсан. -Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан нээлттэй хаалганы өдрөөр Эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрэм, эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн анхаарах зүйлс зэрэг 200 ширхэг тараах материалыг эмнэлгийн мэргэжилтэн болон иргэдэд 500 ширхэгийг түгээсэн. -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг, “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн”-д ёс зүйн хорооны гишүүд болон албан хаагчид хамрагдан чадавхжсан байна.	100
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
Нийтлэг чиг үүрэг №1. Төрийн захиргааны удирдлага							
81	1.1.Төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх, эрүүл мэндийн ажилтны харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг		Сургалтад хамрагдсан албан хаагчийн	75%	75,1%	Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулагдсан. Тайлант хугацаанд тус дэд хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж, 2	100

	тасралтгүй байгуулна.	зохион		тоо		зорилтын хүрээнд нийт 23 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлснээс 21 нь бүрэн хэрэгжиж, үйл ажиллагааны гүйцэтгэл 98%-тай байна. -Албан хаагчдын ёс зүйн төлөвшил, ажлын байрны сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын албан тушаалтан бүрийн ажлын байранд тавигдах шаардлагыг тодорхой болгон, холбогдох журмыг батлуулж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна. - Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгын хүрээнд улирал тутам соён гэгээрүүлэх сургалт, төлөвлөгөөт арга хэмжээг зохион байгуулсан. Үүнтэй уялдуулан 2025 онд ёс зүйн зөрчлийн эрсдэлийн үнэлгээг хийж, нийт эрсдэлийг 25.1% гэж дүгнэсэн. Уг үнэлгээнд үндэслэн төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Эрүүл мэндийн газрын ажлын байрны шаардлагын талаарх сургалтыг танхимын бус хэлбэрээр зохион байгуулж, үр дүнд нь албан хаагчдын хууль, эрх зүйн мэдлэг 25%-иар нэмэгдсэн байна. -Тайланд хугацаанд 5 удаагийн танхим 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 225 албан хаагч хамрагдсан байна. - Ёс зүйн дэд хороонд албан хаагчдаас ёс зүйн зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй бөгөөд ямар нэгэн ёс зүйн алдаа, зөрчил илрээгүй. - Аймгийн Эрүүл мэндийн газар,Бүсийн оношилгоо эмчилгээний төвд Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хороо байгуулагдан тайлант хугацаанд 5 удаа хуралдаж,2025 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 2 зорилтын хүрээнд 23 үйл ажиллагаа бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 82,5%-тай байна. -Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажлын байранд тавигдах журмыг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. -“Еннеаграм ба Урлагийн сэтгэл засал”,хувь хүний хөгжил,сэтгэл зүйн сургалт,“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль” болон ЭМГ-ын албан хаагчдын ажлын байранд тавигдах шаардлагаар нийт 32 албан хаагч дунд асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан. ЭМГ-ын 32 албан хаагчдаас “Төрийн албан хаагчийн ёс зүйн тодорхойлох” асуулгыг цахимаар авч эрсдэлийг тодорхойлсон. -Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэглээ хэлэлцүүлэг, “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал бүсийн зөвлөгөөн”-д ёс зүйн хорооны гишүүд болон албан хаагчид хамрагдан чадавхжсан байна. -Тайлант хугацаанд ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн дэд хороонд төрийн албан хаагчтай холбоотой өргөдөл, гомдол ирээгүй бөгөөд ёс зүйн алдаа зөрчил илрээгүй байна.	
82	1.2.Авилга,ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, чиглэлээр үйл ажиллагааг		Төлөвлөг өөний хэрэгжил	98%	98%	Эрүүл мэндийн газрын Авлигын эсрэг 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилт, 8 арга хэмжээний хүрээнд батлуулан хэрэгжилт 98,5% хувьтай байгаа нь өмнөх оноос 0,5%-иар нэмэгдсэн байна.	100

	төлөвлөн хэрэгжүүлнэ.		т			-Авлигатай тэмцэх газрын цахим системд олон нийтэд ил тод болгохоор заасан мэдээллээс эрүүл мэндийн салбарын ажилчид болон эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлж буй иргэдэд хамаарагдах 5 зурган постер, 2 богино хэмжээний бичлэгийг Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим системд нээлттэй байршуулж нийт 8512 хүн үзсэн байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 201, Жаргалант сумын өрхийн эрүүл мэндийн төвийн 24, 8 өрхийн эрүүл мэндийн төвийн 84, нийт 309 эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудад Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг таниулах, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг хамтран зохион байгуулсан. -Тайлант хугацаанд Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг 6 эрх бүхий албан тушаалтан хуулийн хугацаанд мэдүүлсэн.Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй албан хаагч бүртгэгдээгүй байна.	
83	1.3.Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлнэ. ⁴		Шийдвэр лэлтийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа үйлчилгээтэй холбоотой нийт 180 үүнээс цахимаар 49, бичгээр 11, утсаар 82, биечлэн 3-ийг хүлээн авч,4-ийг холбогдох байгууллагууд руу шилжүүлж, хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр 100% шийдвэрлэсэн.Үүнээс талархал 53 буюу 36,5%, хүсэлт 86 буюу 59,3%, гомдол 6 буюу 5,1%-ийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад талархал 0,5%-иар нэмэгдэж, хүсэлт 2,0%-иар буурч,гомдол нэмэгдээгүй, өмнөх онтой харьцуулахад ижил түвшинд байна. -Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирүүлсэн 6 иргэний хүсэлтийг цахимаар хүлээн авч хуулийн дагуу шийдвэрлэн аймгийн Засаг даргын тамгын газрын холбогдох албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлсэн. -Өргөдөл,гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл нь аймгийн ЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэн мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mkhs.gov.mn цахим хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна. -Тайлант хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд 1 удаа үнэлгээ хийж, тайланг ЭМЯ болон аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан.	100
84	1.4.Салбарт албан бичиг,өргөдөл гомдлын мэдээллийг бүрэн цахимжуулах бодлого хэрэгжүүлж албан бичиг, өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэлтийн явцын хяналтыг тухай бүрт цахимаар (Able)		Шийдвэр лэлтийн хувь	100%	100%	Тайлант хугацаанд 460 албан бичиг хүлээн авч 405 албан бичгийг хүргүүлж, цахим хэлбэрээр солилцон, хяналтад авч хэрэгжилтийг хангасан эсэх, шийдвэрлэлтийн явц байдалд тухай бүрт цахимаар (Able) хянаж ажилласан бөгөөд өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд И-оффис системийн ашиглалт 100% байна. -Өргөдөл гомдол хариуцсан албан хаагчийг томилон ажиллуулж мэдээлэл болон холбоо барих утасны дугаар, өрөөний дугаар болон иргэдээс мэдээлэл, санал, хүсэлт, талархал, гомдол авах цагийн хуваарийг байгууллагын or.mohs.gov.mn цахим хуудасны “Санал гомдол” цэс болон байгууллагын мэдээллийн самбарт ил тод байршуулан	100

	хянан ажиллана ⁵					мэдээлэл өгч ажилласан.	
85	1.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Шилэн дансны тухай болон Жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.		Хэрэгжилтийн хувь	90,6%	90,8%	Эрүүл мэндийн газрын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 91,5%-тай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0,5%-иар нэмэгдсэн байна. Эрүүл мэндийн газрын Ёс зүйн зөвлөлд ажлын байран дахь сахилга бат, зөрчил хариуцлагын талаарх гомдол санал ирээгүй байна. -Гэмт хэрэг, халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор анхан шатлалын Эрүүл мэндийн байгууллагууд 100,0% хяналтын камер сууриллуулсан, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь нийт 112 хяналтын камер суурилуулан ашиглаж байна. Нийтээр тэмдэглэх сар шинийн баярын өдрүүдэд эрүүл мэндийн салбарын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хариуцлагатай жижүүрийг тушаалаар томилон ажиллуулж, тойрон эргэлт, хяналтыг тавьж ажилласан. -Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын нэгдсэн шилэн дансны цахим хуудсанд нийт 22 талбар болон ил тод байдлын самбарт 109 мэдээлийг байршуулахаас 109 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, олон нийтэд мэдээллийг ил тод хүргэсэн бөгөөд хуулийн хэрэгжилт 100%-тай байна. Жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах хүрээнд ЭМБ-уудын хөдөлмөрийн дотоод журамд 100% нэмэлт өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийг ЭМБ-уудын удирдлагууд өгч ажилласнаар тайлант хугацаанд гэмт хэргийн зөрчил, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, хүний эрхийг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100
86	1.6. Хариуцлагын тогтолцоог үйл ажиллагаандаа мөрдүүлэн албан хаагчдын цаг ашиглалт, хариуцлагыг дээшлүүлж хууль, тогтоомжийг сахин биелүүлэх, сахилга бат, хариуцлагын чиглэлээр гарсан тогтоол шийдвэрийн хүрээнд тайлангийн хугацаанд төлөвлөгөөг гарган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн мөрдүүлэх		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	85,8	86%	Эрүүл мэндийн газрын албан хаагчдын цаг ашиглалтын хяналтыг сайжруулж, тогтмол цагаа бүртгүүлж и-оффисоор тогтмол хяналт тавьж байгаа бөгөөд үнэлгээ хийхэд ажлын цаг ашиглалт 65,5 %-тай байна. Тайлант хугацаанд хууль, тогтоомж зөрчсөн, сахилга бат, ажлын хариуцлага алдсан, сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагч байхгүй байна. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбар байгууллагуудын удирдлагуудын шуурхай танхимаар 12, Эрүүл мэндийн газрын албан хаагчдын шуурхай танхимаар 32 удаа хуралдаж, мэдээллээр ханган, үүрэг даалгавар өгч хариуцлагажуулан ажилласан. Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагууд албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавин улирал тутам үр дүнгийн урамшуулалд нэг үзүүлэлт болгон оруулж, цаг ашиглалтыг сайжруулан ажилласан. Төрийн албаны тухай хууль болон хөдөлмөрийн хууль бусад хууль тогтоомж зөрчсөн сахилгын арга хэмжээ авагдсан тохиолдол гараагүй байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналтыг Жаргалант сумын эрүүл мэндийн төв, төрийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй өрхийн эрүүл	70

	арга хэмжээг авч ажиллана.					мэндийн төвүүд,Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд тус бүр 1 удаа хийж, хяналтын дүнг ЭМГ-ын Удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн тогтоол шийдвэрийн биелэлт, ажлын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр зөвлөмжөөр ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоол 6, Эрүүл мэндийн сайдын тушаал 15, аймгийн Засаг даргын захирамж-15,Эрүүл мэндийн газрын даргын А тушаал 58, Б тушаал 27 батлагдсаныг Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудаст байршуулж, салбар байгууллагуудад хүргүүлж, сурталчлан хэрэгжилтэд хяналт тавин ажилласан.	
87	1.7.Байгууллагын хэмжээнд И-оффис системийг бүрэн ашиглана.		Системийн ашиглалт	90%	90-100%	Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох И оффис системийг ашиглаж байна. Тайлант хугацаанд, Эрүүл мэндийн газарт шинээр орсон 4 албан хаагчид систем ашиглалтын гарын авлагыг нэг бүрчлэн хүргүүлж ашиглалтыг хянах ажлыг зохион байгуулсан. -Тус программаар нийт 460 албан бичиг хүлээн авч, 405 албан бичгийн хариуг хүргүүлж, иргэдээс 180 санал хүсэлт, талархал хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. -Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn хуудаст байршуулж ил тод байдлыг ханган ажилласан. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн И-оффис системийн ашиглалт 100% байна.	100
Нийтлэг чиг үүрэг №2. Хэвлэл мэдээлэл							
88	2.1.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах		Мэдээлэл сурвалжилгын тоо	107	108	Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 133 төрлийн видео зөвлөмж, мэдээлэл, сурвалжилга, мэдээлэл, 55 төрлийн анонс, өргөмжлөл, сертификат, гарын авлага, 81 удаагийн фото зурган мэдээг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. Мөн орон нутгийн 4 телевизэд 22 удаагийн мэдээ, 4 удаагийн мэдээ сурвалжилгыг FM радиод, 8 удаа шинэ мэдээ сонинтой хамтран иргэд олон нийтэд цаг үеийн мэдээ, мэдээллийг түгээж ажилласан.	100
89	2.2. Аймаг, орон нутгийн батлан хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, дэд хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд хүргэх, зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэд олон сурталчлана. ^{4,5}		Сурталчилсан тоо	15	20	Аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүд болон байгууллагын зохион байгуулсан ажлын мэдээ мэдээллийг цаг тухай бүр иргэд олон нийт, эрүүл салбарын нийт ажилтнуудад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран түгээсэн. Байгууллагын цахим хуудсаар дамжуулан 789 удаагийн зурган болон видео шторк бэлтгэн хүргэсэн ба давхардсан тоогоор 1013184 иргэнийг мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Тайлант хугацаанд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Засаг даргын үйл ажиллагааны 2024-2028 оны төлөвлөгөө,Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд иргэдийн эрүүл мэнд болон эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудлыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн үйл ажиллагаануудыг цахим	100

						хуудсанд нийтэлж, олон нийтэд түгээж ажилласан. Нийт 9 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 4 телевизээр, 55 төрлийн гарын авлага, урилга, эх бэлтгэлийг нийгмийн эрүүл мэндийн төвийн студид бэлтгэн иргэдийг мэдээллээр ханган ажилласан. Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаал болон эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого шийдвэр, тусламж үйлчилгээг сурталчлах, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөг 27 удаа, “Эрдэнэт-Үйлдвэр” ТӨҮГ-н FM радиагоор үйлдвэрийн нийт албан хаагчдад 6 удаагийн шууд нэвтрүүлэг, Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд талархлын аянаар 30 контент видео, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал буюу улаанбурхан, томуугийн дэгдэлт, тарваган тахал, хачгийн халдвараас сэргийлэх, цагаан тоосны дэгдэлтийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн үйл ажиллагаанд идэвхтэй хамруулах мэдээлэл түгээх зорилгоор 42 видео бичлэг, ХПВ-ийн дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор "Вакциндаа идэвхтэй хамрагдацгаая" 6 удаагийн цуврал контент видео бэлтгэн ORKHON_EMG инстаграм хаяг, youtube сувгаар дамжуулан иргэд олон нийтэд түгээн сурталчилсан байна.	
Нийтлэг чиг үүрэг №3. Төсөв, санхүү, эдийн засаг							
90	3.1. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон ажиллана. ⁵		Өр авлага үүсээгүй байна	-	-	Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн салбар байгууллагын хувьд 2024 оны жилийн эцэст нийт 4,3 тэрбум төгрөгийн өр төлбөрийг тайлагнаснаас ажилтан, албан хаагчидтай холбоотой 332,2 сая төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн өр төлбөр 2,8 тэрбум, бараа ажил үйлчилгээний бусад өглөг, байгууллагад төлөх өглөг нийт 425,5 сая төгрөг байгаагаас 2025 онд нийт авлагыг 2,8 тэрбум буюу 100%-иар бууруулан 28,1 сая төгрөгний авлагын үлдэгдэлтэй байна. Өр төлбөрийн хувьд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2025 оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал нийт өр төлбөр 2 дахин буюу 4,1 тэрбум төгрөгөөр өсч нийт өр 8,4 тэрбум төгрөг байна. Нийт өр төлбөрийг бүтцээр нь задалбал: -Ажилчин, албан хаагчидтай холбоотой өр төлбөр 2,6 тэрбум буюу оны эхнээс 7,8 дахин их -Эм, эмнэлгийн хэрэгсэлийн өр төлбөр өмнөх оноос үлдэгдлээс 1,5 тэрбум 60,7%-иар өссөн -Бусад бараа ажил үйлчилгээ, байгууллагад төлөх өглөг өмнөх оноос 0,9 тэрбум буюу 3,3 дахин тус тус өссөн байна. Үүссэн нийт өр төлбөрийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт улсын хэмжээнд тасарснаас шалтгаалан өр төлбөр хуримтлагдаж үүсээд байна. -Байгууллагын хувьд 2024 оны жилийн эцэст 3.042,5 мянга төгрөгний авлагыг аймгийн Нийгмийн даатгалын газартай хоорондын тооцоогоор нийлэн баталгуужуулж уг авлагыг 2025 оны 01 сарын байдлаар бүрэн	0

						барагдуулж ажилласан. 2025 онд байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн 10,5 сая төгрөгний өр төлбөрийг Сангийн Сайдын 73-р журмын дагуу зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг Эрүүл мэндийн яаманд 7 сард саналаа хүргүүлж, 8 дугаар сарын батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулж 10,5 сая төгрөгний өр төлбөрийг шийдвэрлүүлсэн. Мөн 2025 оны 12 сарын байдлаар үүссэн өр төлбөрийг шийдвэрлүүлэхээр Эрүүл мэндийн яаманд 12 сарын төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах, зардлын бүлэг хооронд шилжүүлэх саналыг албан бичгээр хүргүүлээд байна.	
91	3.2. Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, хөдөлгөөн, ашиглалт хамгаалалт, эзэмшигчийн хариуцлагыг дээшлүүлэх ажлыг байгууллагуудын хэмжээнд сайжруулах арга хэмжээг авч ажиллана.		Арга хэмжээний тоо	2	2	Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/16 дугаар тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 2025 оны ажлын төлөвлөгөөг 5 арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан. -Тайлан хугацаанд өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, хөдөлгөөн, ашиглалт хамгаалалт, эзэмшигчийн хариуцлагыг дээшлүүлэх ажлыг байгууллагуудын хэмжээнд сайжруулах арга хэмжээний хүрээнд 4 удаа хуралдаж, 4 асуудлыг шийдвэрлэсэн. -Эрүүл мэндийн газрын 2025 онд өмч хөрөнгийн тооллогыг 2 удаа хийж, хувь картыг шинэчилж, албан хаагчдад хүлээлгэн өгсөн. Өмч хамгаалах зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 82,5%-тай хэрэгжсэн байна.	100
Нийтлэг чиг үүрэг №4. Тайлагналт, хяналт-шинжилгээ, үнэлгээ							
92	4.1. Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2025 оны улсын болон аймгийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлж тайлагнана.		Хэрэгжилтийн хувь	90%-94%	92-94%	Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад салбар дундын оролцоог ханган ажиллаж, биелэлтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Удирдлагын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн биелэлтийг хугацаанд нь Эрүүл мэндийн яам, аймгийн Засаг даргын тамгын газарт албан тоотой хүргүүлэн ажилласан. Үүнд: -Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд 2 зорилтын хүрээнд хэрэгжилтийг хангуулж хэрэгжилтийн тайлан, үнэлгээг хагас, бүтэн жилээр нотлох баримтын хамт гаргаж, хугацаанд нь И-оффисоор хүргүүлсэн. -Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 26 арга хэмжээ болон аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийгдэн хугацаанд нь АЗДТГ-т хүргүүлсэн. -Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнг Эрүүл мэндийн газрын Удирдлагын зөвлөлийн 2 удаа хурлаар хэлэлцүүлэн, тайланг Эрүүл мэндийн яам болон аймгийн Засаг даргын	100

						тамгын газарт албан тоотоор хугацаанд нь хүргүүлсэн.Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт дунджаар 96.4 хувьтай байна.	
93	4.2.Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тогтоосон хугацаанд тайлагнана.		Хэрэгжилтийн хувь	92,5%	92,8%	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ,үнэлгээ хийх журам”-ын дагуу Эрүүл мэндийн газраас нэгтгэгдэн гарч буй хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх явцад албан хаагчдыг зөвлөмжөөр ханган тайланд тухай бүр сайжруулалт хийж, илтгэх хуудсыг албан хаагчдад хүргүүлэн ажилласан. -ЗГҮАХ,Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Орхон аймгийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг 15 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг хугацаанд нь нотлох баримтын хамт И-оффист тайлагнасан. -2025 онд 5 бодлого шийдвэрийн төлөвлөгөө, шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх ажлын саналыг боловсруулж, хугацаанд нь хүргүүлсэн. -Тайлант хугацаанд шинээр 23 нийт 58 тогтоол шийдвэрийн 72 заалтыг хяналтад авч хэрэгжилтийг тооцож үзэхэд хэрэгжилт дунджаар 93,4%-тай үнэлэгдэж өмнөх оны мөн үеэс хэрэгжилт 1,1 %-иар нэмэгдсэн байна.	100
94	4.3.Байгууллагад хийгдэх дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, төлөвлөгөөний дагуу хяналт хийж, зөвлөмж өгнө.		Дотоод хяналт хийгдсэн тоо	10	10	Байгууллагын Дотоод хяналтын баг, ажиллах журмыг шинэчлэн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар батлуулсан. Дотоод хяналтын баг 5 удаа хуралдаж тус багийн 2025 оны төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэн ажилласан.Тайлант хугацаанд төлөвлөгөөт хяналт 12 удаа хийгдэж, зөвлөмжийн хэрэгжилт 87,5%, длтоод хяналтын багийн төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна.	85

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулж, иргэн бүрийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.

Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулах

95	1.1.1. Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг бусад салбар нэгжийн оролцоог ханган зохион байгуулж, хэрэгжилтийг ханган		Арга хэмжээний хэрэгжилтийн хувь	-	85%	Тайлант хугацаанд “Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх” арга хэмжээг зохион байгуулахад эрүүл мэндийн салбар байгууллагууд болон Боловсролын газар, Соёл урлагийн газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар болон төрийн бус 13 байгууллагуудтай хамтын оролцоог ханган ажиллалаа. Үүнд: -27 удаагийн өдөрлөг, аян, форум, 316 удаагийн сургалт сурталчилгаанд давхардсан тоогоор 20098 иргэнийг хамруулж, 24 төрлийн сурталчилгааны материалыг 6068 иргэнд түгээсэн. -Цахим хуудаст 789 төрлийн гарын авлага, шторк, зөвлөмжийг	100
----	---	--	----------------------------------	---	-----	--	-----

	ажиллана. ⁵					байршуулан давхардсан тоогоор 1013184 хандалттай байна. -Эрүүл мэндийн тэмдэглэлт өдөр болон салбарын хэмжээнд зохион байгуулсан удирдамж бүхий сургалт, цаг үеийн арга хэмжээний талаар 33 удаагийн мэдээ сурвалжилгыг орон нутгийн 5 телевизэд, 5 удаагийн мэдээллийг FM радиогоор хамтран бэлтгэж иргэдэд хүргэсэн. -Боловсролын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулийн 845 бүлгийн багшид сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 18457 суралцагчид эрүүл мэндийн боловсрол олгож ажиллалаа. -Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр 7 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 38 аж ахуйн нэгж, байгууллага, 36452 иргэнийг хамруулан мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлсэн. -Аймгийн Засаг даргын 2025 оны А/820 дугаар захирамжаар орон нутгийн 110 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын 29 багийн зорилтот бүлгийн 51620 гаруй иргэнийг нийгмийн эрүүл мэндийн нөлөөллийн арга хэмжээнд хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. -Сургуулийн өмнөх боловсролын 32 цэцэрлэгийн арга зүйч болон эмчид хүүхдийн эрүүл мэнд, эрүүл ахуй агуулгын хүрээнд 5 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 64 хүнийг хамруулсан. Арга хэмжээний хэрэгжилт 85,5 хувь байна.	
96	1.1.2.Нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр нийтийг хамарсан арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өргөнөөр татан оролцуулах арга хэмжээг зохион байгуулна. ⁵		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	4	Тайлант хугацаанд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр 8 удаагийн нийтийг хамарсан арга хэмжээнд 37 аж ахуйн нэгж, байгууллага, 11756 иргэнийг хамрууллаа. Үүнд: - Дэлхийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Эрүүл мэндийн салбарын 25 байгууллага, 5 холбоодын 250 гаруй эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд оролцон үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Тус өдөрлөгөөр давхардсан тоогоор 497 иргэнд үзлэг, зөвлөгөө өгч, 35 төрлийн гарын авлага зөвлөмжийг давхардсан тоогоор 1988 иргэнд түгээж ажиллалаа. Мөн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын дадал хэвшүүлэх зорилгоор 4 төрлийн тэмцээнд 70 иргэнийг хамруулсан. -Шүдний мэргэжилтний холбоо, Шүдний 5 эмнэлэгтэй хамтран малчдын үзлэгт 152 хүн, цэргийн насны 178 залуучууд, цагаан тоосны нөлөөллийн бүсийн 1500 нийт 1678 хүнд явуулаар амны хөндийн эрүүл мэндийн үзлэг хийж, шүд угаах аргачлалыг таниулах сургалт нөлөөллийг ажлыг зохион байгуулсан -Дэлхийн дархлаажуулалтын 10 хоногийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Дархлаажуулалтын ашиг тусыг хүн бүрд хүртээе” өдөрлөгийн зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр нийт 7 байгууллагын 100 гаруй	100

						төрийн албан хаагчдыг хамруулсан. -Бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, хүний папилома вирусын халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад Боловсролын газар, сум, 9 өрхийн эрүүл мэндийн төв, Амурлин тэнгис ТББ-уудтай хамтран 3 арга хэмжээг зохион байгуулж, 4750 сурагч, 2700 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нарын төлөөллийг хамруулаад байна. -Эрүүл зөв хооллолтын сурталчлах амталгаат, өдөрлөг зохион байгуулж 350 хүнийг хамруулсан. -“Эхийн сүүгээр хооллох, амьдралын алтан 1000 хоног” нөлөөлөл, сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан албан хаагчид, иргэд нийт 350 хүнийг хамруулсан. - Малчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалт өдөрлөгийг Баянцагаан багийн малчин иргэдийн дунд зохион байгуулж 60 малчин иргэдийг хамруулсан. -Цагаан тоосны дэгдэлтийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэх зорилгоор нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, Жаргалант сум, Баян-Өндөр сумын Говил, Баянцагаан багийн иргэд болон хүүхдүүдийг хамруулж, нийт 1201 иргэнд хүрч ажилласан.	
97	1.1.3. Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн болон хөхүүл эхчүүдийг аминдэмд хамруулна. ²	ОНТ 10.0 сая	Аминдэм жүүлэлтийн хангалтын хувь	17%	19%	Тайлант хугацаанд нийт 569 жирэмсэн, 639 эх төрсөн ба үүнээс нийгмийн халамж шаардлагатай цус багадалттай 295 жирэмсэн, хөхүүл эхчүүд байна. 2025 онд шинээр жирэмсний хяналтад орсон эхчүүдийн 4.8% нь цус багадалттай илэрсэн ба өмнөх оны мөн үеэс 3.5%-иар нэмэгдсэн байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/15 дүгээр тогтоолоор батлагдсан 10 сая төгрөгийн санхүүжилтээр Засаг даргын 2025 оны А/384 дугаар захирамж, Эрүүл мэндийн газрын даргын А/46 дугаар тушаалын дагуу Канадын олон найрлагат 295 ширхэг Gentle Iron бэлдмэлийг татан авч сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн халамж шаардлагатай цус багадалттай 535 жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд буюу зорилтот бүлгийн 32.5 хувьд 1-2 сарын хэрэглээг олгож, үр дүнд хяналт тавиж ажилласан. Цус багадалттай 181, эх барихын ужиг дурьдатгалтай 86, эх барихын бус бусад эмэгтэй 85, нийгмийн халамж нэн шаардлагатай 111, хөхүүл 72 эхэд олгон жирэмсэн, хөхүүл үеийн цус багадалтыг эмчлэн гарах эрсдэл хүндрэлийг бууруулсан байна.	100
98	1.1.4. Хорт хавдартай иргэдийн эмийн болон эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлнэ. ²	ОНТ 120.0 сая	Дэмжлэгт хамрагдсан хорт хавдартай иргэдийн хувь	69,2%	69,4%	2025 онд хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэх аймгийн зөвлөл 4 удаа хуралдаж, хорт хавдартай 213 иргэнд нийт 120,000.000 төгрөгний буцалтгүй дэмжлэг олгосон байна. 2025 онд шинээр батлагдсан 238 хавдрын тохиолдлын 89,5 хувь нь эмийн болон эмчилгээний дэмжлэгт хамрагдсан байна.	100

Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангаж, орчин үеийн оношилгоо эмчилгээний дэвшилтэт технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
Зорилт 1. Эмнэлгийн яаралтай тусламжийн төвлөрлийг сааруулах, иргэдэд үзүүлэх яаралтай тусламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх.							
99	2.1.1. Яаралтай тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад нэгж байгуулах, амь тэнссэн тусламж үйлчилгээг үзүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ. ^{2,3}	ОНТ 20,0 сая	Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгэ эний чадавх	90%	91%	Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чанар хүртээмж, багаж тоног төхөөрөмжийн хангалтад 2 удаа дэмжлэгт хяналт зөвлөмж өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Үнэлгээгээр яаралтай тусламж үзүүлэх багийг томилж үүрэгжүүлэн, дуудлагын схем, зураглалыг баталсан байгууллага 90,2%,амин чухал эмийн нөөц 96,5%,яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслийн хангалт 94,5%-д хүрч өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар нэмэгдсэн байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн яаралтай тусламжийн тасаг нь хүлээн авах, бүртгэлийнхэсэг, ажиглах,тогтворжуулах, ажилбарын өрөө гэсэн урсгалын дагуу яаралтай тусламж үзүүлэн, багаж хэрэгслийн хангалт 94,5%-тай, 15 эмч, 9 сувилагч, 4 дуудлага хүлээн авагч, 11 жолооч ажиллан аймгийн хүн амд яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээг үзүүлж байна. -Анхан шатны 9 байгууллагууд 100,0% яаралтай тусламж үзүүлэх нэгж байгуулж, яаралтай тусламж үзүүлэх багаж хэрэгслээр 87,5% хангагдсан байна. -Хувийн хэвшлийн 11 ор бүхий клиник 100,0% яаралтай тусламж үзүүлэх нэгж байгуулж, яаралтай тусламж үзүүлэх багаж хэрэгслээр 81,8% хангагдаж, яаралтай тусламжийн мэргэшсэн сувилагчийг 7 эмнэлэг ажиллуулж байна. -Баян-Өндөр сумын ИТХ, ЗДТГ-тай хамтран орон нутгийн 8,0 сая төгрөгийн санхүүжилтээр төрийн 64 байгууллагуудын 500 гаруй албан хаагчдыг амиллуулах суурь тусламжийн сургалтад хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн байна. -Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр: Тайлант хугацаанд Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг,БООТ-тэй хамтран “Орхон аймгийн Яаралтай тусламжийн өнөөгийн байдал”,“Амиллуулах суурь тусламж”, “Лавшруулсан тусламж”, “Шокын үеийн тусламж үйлчилгээ”, “Гэмтэгсдэд үзүүлэх тусламж үйлчилгээ”, “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” зэрэг 6 сэдвийн хүрээнд зохион байгуулсан орон нутгийн болон төвийн 4 удаагийн сургалт, 2 удаагийн ур чадварын гардан үйлдлийн тэмцээнд давхардсан тоогоор улс болон хувийн хэвшлийн бүх шатлалын 1082 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан ур чадварыг нэмэгдүүлсэн. -Дэлхийн эмч нарын баярыг тохиолдуулан нотолгоонд суурилсан анагаах ухааны мэдлэг чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Doctors quiz night” арга хэмжээнд 22 ЭМБ-ын 168 эмч, “Миний мэргэжил миний бахархал” ур чадварын тэмцээнийг Баян-Өндөр сумын ИТХ,	100

						ЗДТГ,Монголын яаралтай тусламжийн нийгэмлэг,Улаан загалмайн хороо, Юнител ХХК-ын салбартай хамтран зохион байгуулж,"Random number generator" программаар тэмцээнд оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар 18 байгууллагын 33 эмч,эмнэлгийн мэргэжилтнийг сонгон 3 баг оролцсоноос шилдэг багаар Avengers 81,4 оноогоор /Эрдэнэт медикал, Мөнхсүндрал ӨЭМТ, жаргалант СЭМТ, ХХЭМБ-уудын нэгдсэн/баг шалгарч 4,000,000 /4 сая төгрөгөөр шагнуулсан. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Төгсөлтийн дараах сургалтад 2024-2025 оны хичээлийн жилд “Яаралтай тусламжийн сувилахуй”-аар 6, “Эрчимт эмчилгээний сувилахуй”-аар 1 эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна. Амь тэнссэн үеийн тусламж үйлчилгээний чадавх 91,5%-тай байгаа нь өмнөх оноос 0,5%-иар нэмэгдсэн байна.	
100	2.1.2. Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагааг жигдрүүлэх, түргэн тусламжийн үйлчилгээг шуурхай үзүүлнэ.	ОНТ 385,0 сая	Түргэн тусламжийн төвийн үйл ажиллагаанд хийсэн үнэлгээ, Нэн яаралтай дуудлага д 20 минутын дотор очсон хувь	100%	100%	Аймгийн хэмжээнд Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь түргэн тусламжийн тасагт туулах чадвар сайтай, бүрэн тоноглогдсон 2, хагас тоноглогдсон 10 нийт 12 машин яаралтай тусламжийн дуудлагад үйлчилж ажиллаж байна. -Түргэн тусламжийн үйл ажиллагааны зардалд орон нутгаас 385 сая төгрөгийг шийдвэрлэн чадавхийг нэмэгдүүлсэн байна. Тайлант хугацаанд нийт дуудлага -12102 ирснээс насанд хүрэгчид 9924 хүүхэд 2178, Яаралтай дуудлага -2586 (22%)Алсын дуудлага-90 (0.74%),Үр дүнгүй дуудлага -84 (0.7%),Түргэн тусламжийн дуудлага аваад очсон хугацаагаар авч үзэхэд: Нэн яаралтай дуудлагад 0-20 минутын дотор очсон 8535 ба 70.5%, 21-40 минут – 2260 ба 18,6% 41-60 минут -1302 ба 10.7%,1 цагаас дээш-5 ба 0,04% эзэлж байна Дуудлагын шалтгаан: •Зүрх судасны өвчлөл- 3589 •Амьсгалын замын өвчлөл-1502 •Осол гэмтэл -905 •Архины шалтгаант-584 •Төрөх дуудлага-142 бөгөөд бусад шалгаантай дуудлагууд байна. -Нэн яаралтай дуудлагад 20 минутын дотор очсон хувь 70,5% байгаа нь өмнөх онтой харьцуулахад 9%-иар буурсан байна.Буурсан шалтгаанд орон нутагт зам засварын ажил эхэлсэнтэй холбоотой автомашины түгжрэл нэмэгдсэн, дэнж багийн бүс нутагт нэмэлтээр ажиллаж байсан /16:00-24:00 хүртэл/ жолооч,эмчийг буулгасантай холбоотой байна.	70
Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах							
101	2.2.1. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн		Нөөц эх үүсвэрийн бэлэн байдлын хувь	90%	91%	Бүсийн оношилгоо эмчилгээний төв 110 квт-ын чадалтай 2 нөөц цахилгаан үүсгүүртэй бөгөөд 3 блокийн 13 тасаг нэгжийг аваарын үед цахилгаан тэжээлээр ханган ажилласан бөгөөд тайлант хугацаанд 14 удаа цахилгаан тэжээл тасарсан үед нөөц цахилгаан үүсгэвэр нийт 268 минут ажилласан байна.Цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс	100

	тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана. ⁵					сэргийлэх хүрээнд: -Мэргэжлийн байгууллагаар 3 удаа шалгалт тохируулга хийлгэж, 3 удаа ажиллагааны шалгалт хийсэн. -Ажлын байран дахь аюулгүй ажиллагааны чиглэлээр тасаг нэгжийн 26 ажилтныг хамруулан сургалт зохион байгуулсан. -Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр хагалгаа, мэс заслын тоног төхөөрөмжүүдийг өдөр шалгалт тохируулга хийж тэмдэглэл хөтөлсөн. -Эрсдэлээс сэргийлэх чиглэлээр цахилгааны ил утсыг далд монтажтай болгох,өвчтөнүүдийн байнга харьцаж болох цахилгаан хэрэгслүүдэд өдөр тутмын хяналт хийж ажилласан. -Учралтбаяр ӨЭМТ 220 квт цахилгааны эх үүсгэвэр шинээр нэвтрүүлж байгаа ба тохируулга хийгдсэн байна. -Бусад сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженертэй гэрээ байгуулж инженер техник ашиглалтын аюулгүй ажиллагааны заавраар хангаж, урьдчилан сэргийлэх үзлэг, урсгал засвар, техникийн завсар үйлчилгээ хийж, газардуулга,хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжид хяналт хийж мэргэжлийн байгууллагаар баталгаажуулан ажилласан. -Эрдэнэт медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, Баян-Өндөрмед нэгдсэн эмнэлгүүд 110 квт цахилгааны эх үүсгэвэртэй, цахилгаан саатлын үед 24-48 цаг ажиллах боломжтой ба шатахуунаар цэнэглэн хэвийн ажиллах хүчин боломж бүрдсэн. -Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 10 ширхэг /хонда мотор/ цахилгааны эх үүсгэвэр байна. -Нөөц эх үүсвэрийн бэлэн байдал 91%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1,0%-иар нэмэгдсэн байна.	
Стратегийн зорилго 6. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалт ил тод байдлыг ханган ажиллах							
1. Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага зохион байгуулалтын чиглэлээр							
102	6.1.1. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу Эрүүл мэндийн газрын дунд хугацааны бодлогын баримт бичиг болох стратеги төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана. ⁵		Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	90%	90,5%	Эрүүл мэндийн газрын 2025-2028 оны “Стратеги төлөвлөгөө”-г боловсруулах ажлын хэсгийг ЭМГ-ын даргын А/89 дүгээр тушаалаар 8 хүний бүрэлдэхүүнтэй батлаж, нийт 3 удаа хуралдаж стратеги төлөвлөгөөг УЗХ-аар хэлэлцүүлсэн. Стратеги төлөвлөгөөг 9 бүлгийн хүрээнд байгууллагын тулгамдсан асуудал, статистик тоо үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, 60 хуулийн жагсаалтыг гаргаж, нийтлэг болон салбарт мөрдөгдөх хуулиар ялгаж мандатын шинжилгээнд ерөнхий чиг үүрэг-1, үндсэн чиг зэрэг-6, SWOT шинжилгээнд давуу тал-18,сул тал-15, боломж-7,эрсдэл-6-г тодорхойлж, PESTEL анализын аргаар хууль эрх зүйн чиглэлээр 9, нийгэм, эдийн засгийн чиглэлээр 17, гадаад харилцаа, түншлэлээр 11, технологийн чиглэлээр 15 давуу сул талуудыг тогтоон 12 шалгуур үзүүлэлт болон 13 зорилтын хүрээнд 47 ажлыг хийхээр төлөвлөн, 2024 оны үзүүлэлтийг суурь түвшингөөр тооцож, 4 жилээр шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц тоо болон чанарын үзүүлэлтээр гаргаж Аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж	100

						ажиллалаа. Стратеги төлөвлөгөөнд ЭМГ-ын эрхэм зорилго, зорилтуудыг шинэчлэн гаргасан байна. -Тайлант хугацаанд 2025 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 95.6%-тай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5,6%-иар нэмэгдсэн үр дүнд хүрсэн байна.	
2. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг сайжруулах							
103	6.2.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана. ⁵		Нэвтрүүлсэн сайн туршлага	1	2	Тайлант хугацаанд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл болон үйл ажиллагааг мэдээллийн самбар болон цахим хуудсаар сурталчлан, дэмжиж хамтран ажилласан.Тухайлбал: -Гэр бүлийн боловсрол олгох сургагч багшийн “Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол” 8 цагийн сургалт,Боловсролын газартай хамтран сургуулийн өмнөх боловсролын 24 багшид “Хүүхдийн шүдний эрүүл мэнд, шүд угаах арга” сэдвээр сургалт зэрэг 3 удаагийн сургагч багш бэлтгэх сургалтад 81 байгууллагын 174 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. -Дэлхийн эрүүл мэндийн өдрөөр 26 багийн идэвхтэн иргэн, 23 сургуулийн улаан загалмайн хороон гишүүн болон, хүүхдийн зөвлөлийн гишүүд нийт 100 хүнийг сургагч багшийн сургалтад хамруулан чадвхжуулсан -СЭМҮТ, "Ногоон хүрээлэнгийн багш нар" НҮТББ-тай хамтран "Сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь" сургалтыг Дотоодын цэргийн 50 албан хаагчдын дунд зохион байгуулсан. -Эрүүл эхээс-Эрүүл хүүхэд" уриатай "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг “Тогтвортой хөгжил” ТББ-тай хамтран зохион байгуулж, сургалтад 100 гаруй төрийн байгууллагын төлөөлөл, эмч, эх баригч жирэмсэн, төрөх насны эмэгтэйчүүд, бага насны хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчид 350 гаруй хүнийг хамруулж, бага насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийн талаар мэдлэг хандлага дадлыг нэмэгдүүлсэн. -Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, “Эрхэм нандин сувд” төрийн бус байгууллага, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан нарийн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэг, оношилгоог зохион байгуулж 0–18 насны хөгжлийн бэрхшээлтэй нийт 34 хүүхдэд нарийвчилсан үзлэг хийж, онош тогтоон, цаашдын эмчилгээ, хөгжлийн чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгсөн. -Иргэдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжиж 4 удаагийн явган алхалт зохион байгуулж, алхалтад 1000 иргэнийг хамруулсан ба “ Бүх хайраа гэр бүлдээ 100 км” улсын хэмжээний алхалтад хамрагдах 100 иргэнд Эрүүл мэндийн газар, Эм холбоотой хамтран 4 сая төгрөгийн үнэ бүхий	100

						аминдэмийн багцаар дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан.	
104	6.2.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавин ажиллана. ⁵		Хэрэгжилтийн хувь	80%	82%	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжилтийг хангуулах чиглэлээр бүх шатлалын ЭМБ-уудад сурталчлан, хэрэгжилтэд 2 удаа хяналт тавиж, зөвлөмжөөр хангаж ажилласан. -Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын дунд “Үйлчлүүлэгч ба үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулъя” аяныг зохион байгуулж, улс болон хувийн хэвшлийн 46 байгууллага оролцон чанарын нэгдсэн өдөрлөг-1, хэлэлцүүлэг- 4, дэмжлэгт хяналт, үнэлгээ -2, сургалт -4-ыг зохион байгуулж давхардсан тоогоор 247 эмч,эмнэлгийн мэргэжилтэн, менежер, ажилтнууд оролцсон. Үүнд: -Эрдэнэт Медикал төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт чанарын өдөрлөг зохион байгуулан 58 эмч, эмнэлгийн ажилтнууд хамрагдан үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, хэрэгцээг тодорхойлох, танин тодруулах, зөв эрэмбэлэх,эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварт өртөх эрсдэлийг бууруулах чиглэлээр туршлага солилцон чадавхжсан. -Сувилахуйн зөвлөлтэй хамтран “Сувилахуйн тусламж үйлчилгээний аюулгүй байдал-Тарилга хийх арга техникийг сайжруулах нь” хэлэлцүүлгийг 41 арга зүйч, ахлах сувилагчийг хамруулан зохион байгуулж, ур чадварыг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих стандарт MNS 7014:2023, Дохионы хэлний дунд шатны сургалт, Тарилгын аюулгүй байдал, Халдвар дамжих эрсдэл ба урьдчилан сэргийлэлт зэрэг 4 сэдвээр 66 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулан чадавхжуулсан. -36 эрүүл мэндийн байгууллага аяны хүрээнд хийсэн ажлыг итгэл тавих хэлбэрээр танилцуулж,үнэлгээ хийгдэн эхний 3 байранд шалгарсан эрүүл мэндийн байгууллагуудад мөнгөн урамшуулал олгосон. -Аяны үр дүнд эрүүл мэндийн байгууллагуудад дотоод болон гадаад орчны үнэлгээг хийж явган хүний налуу зам, замын бариул, хөгжлийн бэрхшээлтэй хүний автомашины зогсоол, зогсоолын тэмдэглэгээ зэргийг шинээр хийж, үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээллийн самбар, шатны зөөлөвч, таяг, харааны шил, дуугүй хөтөч, ханын бариул, дуслын хонх, дуут дохио зэргийг нэмэгдүүлсэн байна. -Аймгийн ЗДТГ-ын 535,200 төгрөгний санхүүжилтээр БОЭТ-ийн бүх тасаг нэгжийн ариун цэврийн өрөөнүүдийг эрүүл ахуйн болон барилгын стандартын шаардлагад нийцүүлэн засаж үйлчлүүлэгчдэд ээлтэй тав тухтай орчныг бүрдүүлэн“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилтийг хангаж ажилласан. -“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартын хэрэгжилт эрүүл мэндийн байгууллагуудад дунджаар 85%-тай үнэлэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 5,4%-иар нэмэгдсэн үр	100

						хүрсэн байна.	
105	6.2.4. Байгууллагын хэмжээнд иргэд, олон нийтэд хүрсэн шинэлэг ажлыг зохион байгуулж үр дүнг мэдээлнэ.		Зохион байгуулсан шинэлэг ажлын тоо	4	4	Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын хэмжээнд иргэд олон нийтэд хүрсэн шинэлэг 5 ажлыг зохион байгуулж, давхардсан тоогоор 3311 иргэнийг хамруулсан. -Монгол улсын зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор, чиглүүлэгч багш Бямбаагийн Батбаяр агсны нэрэмжит амилуулах тусламжийн “Миний мэргэжил миний бахархал” ур чадварын тэмцээнийг зохион байгуулж нийт 3 багийн 33 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулж, бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний яаралтай амилуулах суурь тусламжийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлсэн. -Цагаан тоосны дэгдэлтийн бүсэд амьдарч буй иргэдийн эрүүл мэндийг дэмжих, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, Говил, Баянцагаан, Жаргалант сумын Дулаан-Уул, Жаргалант, Улаантолгой багийн 1000 гаруй иргэнийг хамруулан зөвлөмж зөвлөгөө өгч эрүүл мэндийг дэмжиж ажилласан. -Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй “ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Бүх нийтийн явган алхалт”-ын арга хэмжээг зохион байгуулж 12 байгууллагын 210 албан хаагч, иргэд олон нийт оролцож, тэдний эрүүл зөв амьдрах дадал хэвшил, хандлагыг нэмэгдүүлсэн. - Дэлхийн эрүүл мэндийн өдрийн хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Эрүүл мэндийн салбарын 25 байгууллага, 5 холбоодын 250 гаруй эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд оролцон үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Тус өдөрлөгөөр давхардсан тоогоор 497 иргэнд үзлэг, зөвлөгөө өгч, 35 төрлийн гарын авлага зөвлөмжийг давхардсан тоогоор 1988 иргэнд түгээж ажиллалаа. Мөн иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл амьдралын дадал хэвшүүлэх зорилгоор 4 төрлийн тэмцээнд 70 иргэнийг хамруулан тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Эрүүл мэндийн салбарын эмч мэргэжилтнүүдээ алдаршуулах, иргэд олон нийтэд таниулах зорилгоор “Эмч, сувилагч танаараа бахархъя” аяныг 2 сарын хугацаатай зохион байгуулсан. Тус аяны хүрээнд эрүүл мэндийн салбарт ажиллаж буй нийт 300 гаруй эмч, сувилагчдаа хамруулсан 30 контент бүтээн цахим хуудсанд нийтэлсэн бөгөөд тус контентыг 16287 хүн үзэж танилцсан. Ингэснээр эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үнэ цэнийг нэмэгдүүлж иргэд олон нийтэд Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг таниулах ажлыг зохион байгуулсан.	100
106	6.2.5. Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг ил тод цахимжуулах, хөнгөн шуурхай хүргэх		Цахимжуулсан үйлчилгэ	1	2	Иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг erdenet.mn, or.mohs.gov.mn, Орхон аймгийн Эрүүл мэндийн газар цахим хуудас, олон нийтийн сүлжээнд мэдээ мэдээллийг байршуулан, иргэдэд түгээсэн. Цахимаар иргэдэд хүргэж буй үйлчилгээ:	100

[illegible]